Ногоон хөгжлийн төлөө

MONGOLIAN ECONOMY

Африкийн цөлөөс
талын Монгол хүртэл

Хүлээх бус санаачил

Монголын эдийн засаг, бизнесийн сэтгүүл 2013. 05 сар. №09 (043) www.mongolianeconomy.mn



АН САН СҮ ЧИ:
БУРУУ ЗАМААР АМЖИЛТ ОЛСНООС ЗӨВ ЗАМААР АЛДСАН НЬ ДЭЭР

XacBank
Зөв Банк

ЭХ ДЭЛХИЙ
ЭРДЭНЭТ ХҮМҮҮН
ЭРҮҮЛ АШИГ

ХУДАЛДААНЫ САНХҮҮЖИЛТ

ИМПОРТЫН ЭРСДЭЛИЙГ БУУРУУЛАХ, САНХҮҮЖИЛТ АВАХ БОЛОМЖИЙГ ТАНД САНАЛ БОЛГОЖ БАЙНА

Бид олон улсад танигдсан нэр хүнд, туршлагаараа дамжуулан дэлхийн өнцөг булан бүрт буй таны бизнесийн түнштэй таныг найдвартай холбоно.
Худалдааны санхүүжилтийн хэрэгслүүдийг ашигласнаар та импортын барааны төлбөрөө урьдчилж төлөх, дутуу эсвэл зөрчилтэй бараа хүлээн авах эрсдэлүүдээс өөрийгөө хамгаалж чадна.

БАРИМТЫН АККРЕДИТИВ

- ☑ Импортын
- ☑ Экспортын
- ☑ Standby

БАНКНЫ БАТАЛГАА

- ☑ Гүйцэтгэлийн
- ☑ Тендерийн
- ☑ Төлбөрийн
- ☑ Урьдчилгаа төлбөрийн
- ☑ Амжилтын гурвалжин

Бизнес дэвжээх шийдлийг эрхэмлэнэ



БИДЭНТЭЙ ХОЛБОО БАРИХ:
Лавлах: 1888
Цахим хуудас: www.xacbank.mn
И-мэйл хаяг: tf@xacbank.mn

МОНГОЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ЗӨВЛӨХҮҮДИЙН ИНСТИТУТ

MMCi
Монголын Менежментийн Зөвлөхүүдийн Институт

Эрхэм таныг
“Зөвлөхийн үндсэн ур чадварыг хөгжүүлэхүй“ мэргэшсэн зөвлөх бэлтгэх сургалтад урьж байна.

Сургалтын тухай

Зөвлөх хүнд зайлшгүй байх шаардлагатай үндсэн чадваруудыг олгох энэхүү сургалт маань зөвлөх үйлчилгээний чиглэлээр ажиллаж байгаа болон ажиллахаар зорьж буй зөвлөхүүдэд зориулсан тусгай сургалт юм. Үйлчлүүлэгч компаниа сэтгэл хангалуун байлгах үйлчилгээг үзүүлэхэд шаардлагатай дэлхийн түвшний мэдлэг, мэдээллийг олгож, практик арга техникүүдийг зааж сургахад энэхүү сургалт чиглэгдэж байгаа болно.

Энэхүү сургалтаар танд дараах давуу талууд бий болно.

- Үндэсний гэрчилгээжсэн зөвлөх болно.
- Олон улсын CMC (certified management consultant) авах боломж нээгдэнэ.
- Таны үзүүлэх зөвлөх үйлчилгээний зах зээлийн үнэлэмж өсөж, баталгаажна.
- Гадаад, дотоодын аж ахуйн нэгжүүдтэй хамтран ажиллах боломж нээгдэнэ.

Оролцогчдын тоо: 16-20 Зөвлөх

Сургалтын төлбөр: 400.000 ₮

Байршил: УБ, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, бага тойруу 7/1,
Төрийн банкны 9 давхрын, Хурлын танхимд болно.

Үргэлжлэх хугацаа: 2013 оны 5-р сарын 15 -18 ны өдрийг дуустал
4 өдөр танхимын сургалт үргэлжлэх ба өглөө 9 цагаас эхэлж 17 цагт дуусна.
Танхимын сургалтын дараа 1 сарын турш оролцогчид бие даалт,
даалгаруудыг гүйцэтгэж, хамгаална.

Гэрчилгээ: Сургалтад 90%-иас дээш ирцтэй оролцож бүх даалгаврыг амжилттай гүйцэтгэсэн оролцогчдод ММЗИ-ийн Сургалт, Гэрчилгээжүүлэлтийн хорооны үнэлгээгээр “Үндэсний зөвлөх” гэрчилгээг олгох болно.

Багш нарын баг: Их Британийн зөвлөхүүдийн холбооны гишүүн бөгөөд тус холбооноос менежментийн зөвлөх бэлтгэдэг тусгай сургалтыг амжилттай суралцаж төгссөн /**Certificate in management consulting essentials/ сертификаттай,** олон жилийн туршлагатай сургагч багш нарын баг удирдан явуулна.

ХӨНГӨЛӨЛТ: ММЗИ гишүүн бол 10% ийн хөнгөлөлт, гишүүн бус байгууллагын 3 –с дээш хүн сургалтад хамрагдсан тохиолдолд үнийн дүнгийн 5 % -ийн хөнгөлөлт эдэлнэ.

Бүртгүүлэх хаяг: УБ, Сүхбаатар дүүрэг, 1-р хороо, Чингисийн өргөн чөлөө VISTAV оффис төв, 3-р давхар. Утас: 77120003, 98116332,
И-Мэйл хаяг: Info@mmci.mn

Нөгөөн хөгжлийн төлөө

MONGOLIAN ECONOMY

ҮҮСГЭН БАЙГУУЛАГЧ, ЭРХЛЭГЧ:
Д.Бэхбаяр /9999-4248/

ҮҮСГЭН БАЙГУУЛАГЧ, ОРЛОГЧ ЭРХЛЭГЧ:
И.Отгонжаргал /8800-6228/

ХАРИУЦЛАГАТАЙ НАРИЙН БИЧГИЙН ДАРГА:
Б.Энхмарт

АНГЛИ ХЭЛНИЙ РЕДАКТОР: Теренс Эдвардс
ОРЧУУЛАГЧ: Р.Гантулга

СЭТГҮҮЛЧИД:
Б.Баяртогтох
Б.Энхцэцэг
Э.Зоригт
Х.Хулан

ДИЗАЙНЕР: Ш.Оюундарь
ВЭБ МАСТЕР: Б.Лхагвачулуун

МАРКЕТИНГИЙН МЕНЕЖЕР: Д.Барианжав /9409-2904/
Д.Баттулга /9409-2905/

БОРЛУУЛАЛТЫН МЕНЕЖЕР: С.Цэнд-Аюуш /9409-2906/

“ECONOMY” ТВ СТУДИ
РЕДАКТОР: Б.Үүрийнтуяа
ЗУРАГЛААЧ: Ц.Бат-Отгон
СЭТГҮҮЛЧ: Н.Оюунсувд

ХАЯГ:
Улаанбаатар, ЧД IV хороо,
Анкарагийн гудамж-23 Тод Тауэр-604 тоот

15160 Улаанбаатар, Төв шуудан, ш/ х-2762
www.mongolianeconomy.mn
info@mongolianeconomy.mn

УТАС/ФАКС: 976 - 7011 5476

БОРЛУУЛАХ ЦЭГҮҮД:

"Интер ном"
"Цэцэг төв"
"Минж плаза"
"Алтантулхүүр" номын дэлгүүр
"Номин" супермаркетийн бүх салбар
"Макс" супермаркетийн бүх салбар
"Преско" супермаркет
BTSI супермаркет
"Аз орчлон" номын дэлгүүр
"Билэг" их дэлгүүрийн номын тасаг
"Гранд Плаза" дахь супермаркет
"Мир" номын дэлгүүрийн
"Grand plaza"
"Metro mall"
"Sky" супермаркет
"Улаанбаатар" их дэлгүүр дэх салбар
"Max mall" салбарууд

“Улаанбаатар принт” ХХК-д хэвлэв
www.ubprint.mn

MONGOLIAN ECONOMY

II улирлын нэмэлт захиалга

Редакцид захиалбал үнэгүй хүргэнэ



www.mongolianeconomy.mn

Ардчиллаар гоёсон Монгол Улс

2013 оны дөрөвдүгээр сарын 27. Гадаад, дотоодын төлөөлөгчид төдийгүй ургах нартай уралдах хэвлэлийнхэн саатах тотгоргүй төв замаар салхи татуулан Төрийн ордонын зүг яарна. Эзэн Чингисийн хөшөөнд хүндэтгэл үзүүлэн гудайх 104 орны далбай жанжин Сүхбаатарын талбайг улам чимнэ.

10

Хүлээх бус санаачил

Хатагтай Лайсснар 2012 оны дөрөвдүгээр сараас АОХН-ийн анхны Ерөнхий нарийн бичгээр ажилласан. Ардчиллын алтан хараацайнуудын нэг тэрбээр хүний эрхийн төлөө тэмцэгч, залуучуудын дуу хоолойг улс төрийн индэрт хүргэхэд үнэтэй хувь нэмрээ оруулж буй хатагтай юм.

12

АН САН СҮ ЧИ: Буруу замаар амжилт олсноос зөв замаар алдсан нь дээр



...Тэмцэл, хагацал, зовлон дүүрэн амьдралыг туулсан Ан Сан Су Чи Монгол дахь айлчлалынхаа үеэр “Би өнгөрсөн амьдралдаа сэтгэл хангалуун байдаг” хэмээн инээмсэглэн хэлсэн билээ. Ан Сан Су Чи манай улсад АОХН-ийн Сайд нарын VII бага хуралд оролцсон билээ...

16

Түүчээ



...Орчин үеийн монгол залуусын мэдлэг оюун ухаан, авьяас чадвар, эрч хүч дэлхийн түвшинд гарлаа. Б.Болд энэ л гэгээлэг мөрөөдлийн замыг нээж өглөө. Манай олон залуу гаднын томоохон байгууллагуудад ажилладаг тухай мэдээлэл бий ч дэлхийд тэргүүлэгч компанийн удирдлагын багт багтана гэдэг ховор боломж ажээ...

40

АРДЧИЛАЛ

8 Африкийн цөлөөс талын Монгол хүртэл

10 Ардчиллаар гоёсон Монгол Улс

12 Хүлээх бус санаачил

15 Жинхэнэ ардчилсан оронд авлига үүрлэх орон зай гэж байдаггүй

16 АН САН СҮ ЧИ: Буруу замаар амжилт олсноос зөв замаар алдсан нь дээр

22 Хувьсгалын эзэж

24 Өндөр үнэлгээ өгч, зорилгоо тодорхойлсон

ЭДИЙН ЗАСАГ

30 Өглөг авлага нь тэнцүүхэн түншүүд

32 Түүхээр холбогдсон түншүүд

34 Бид алдаанаасаа суралцаж чадсан

37 Ашигт малтмалын төлөөх БНХАУ-ын өрсөлдөөн

40 Түүчээ

44 Эдийн засаг эрчимжэв үү

46 Гадаадын шууд хөрөнгө оруулалт Монголд хэрэгтэй юу

48 Аюулгүй ажиллагаа ба Германы “ноу-хау”

49 Олон жижиг алхамаас хөгжил бүрдэнэ

МОНГОЛД



Засгийн газраас “Үндэсний мэргэжилтэй ажилтан бэлтгэх хөтөлбөр”-ийг хэрэгжүүлж байгаа. Хөтөлбөрийн хүрээнд эхний ээлжинд 7000 орчим ажил хайгч Хөдөлмөрийн төв биржид бүртгүүлсэнээс нийт 4784 хүнийг сургалтад хамруулж, дадлагад гарсан байна. Хоёрдугаар ээлж нь 2088 хүнтэй сургалтаа эхлүүлжээ. Одоогоор ажил олгогчдын ирүүлсэн ажлын байрны саналын 70 орчим хувь нь барилга, техникийн ажил хийж чадах хүнийг эрэлхийлж байгаа аж.



“Улаанбаатар хотын олон улсын шинэ нисэх буудал барих төслийн нэмэлт хэлэлцээрийн”-ийн үеэр Японы “Мицүбиши Чиёода” компанийн хамтарсан түншлэл нисэх буудал барих төслийг хэрэгжүүлэхээр шалгарсан байна. Шинэ нисэх онгоцны буудлыг 47 тэрбум иенийн өртгөөр барих тооцоог гаргажээ. Японы Засгийн газраас авах зээлийн жилийн хүү 0.2 хувь бөгөөд 40 жилийн хугацаатай юм байна.


Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч Э.Бат-Үүл Газар эзэмших А/406 тоот захирамж гаргасан байна. Уг захирамжаар Баянзүрх дүүргийн XI дүгээр хорооны нутаг дэвсгэрт орших Хөлийн голын хөндийд 43 га газрыг “Улаанбаатар дулааны V цахилгаан станц”-ыг барих зориулалтаар Эрчим хүчний яаманд 15 жилийн хугацаатайгаар эзэмшүүлэхээр болжээ.



НҮБ-ын эдийн засаг, нийгмийн комиссоос жил бүр гаргадаг “Ази, Номхон Далайн эдийн засаг, нийгмийн 2013 оны судалгааны тайлан”-д Монгол Улсын эдийн засгийн өсөлтийг нүүрс болон зэсийн үйлдвэрлэлийн хэмжээнээс хамаарч 15.5 хувьд хүрэх боломжтой гэжээ. Гэхдээ үүнийг хэт өөдрөг төсөөлөл гэдгийг олон улсын шинжээчид анхааруулсан байна.

Германы олон улсын хамтын ажиллагааны нийгэмлэгийн “Эрдэс баялаг, түүхий эдийн иж бүрэн саанчилга” хөтөлбөр, Ерөнхийлөгчийн Тамгын газрын дэмжлэгтэйгээр ирэх сарын 06-10-нд “Уул уурхайн салбарын компанийн нийгмийн хариуцлага ба засаглал” бүсийн чуулга уулзалт болох гэж байна. Уулзалтад хөгжиж буй орнууд болох Лаос, Мьянмар, Вьетнам, Киргиз зэрэг улсын төрийн болон уул уурхайн компанийн төлөөллүүд оролцох аж.

Нээлттэй нийгэм форумын төсвийн талаарх дүгнэлтэд Засгийн газрын орлогын эх үүсвэр шууд татвараас хэт хамааралтай байгааг харуулсан байна. Энэ нь төсвийн орлогыг тогтворгүй, эдийн засгийн мөчлөгийн үед хэт эмзэг болгодог аж. Өндөр хөгжилтэй болон хөгжингүй орнын хувьд шууд татварын орлого дунджаар төсвийн орлогын 62 хувиас ихгүй хувийг бүрдүүлдэг байна.



Эхний улирлын байдлаар улсын хэмжээнд инфляцийн түвшин 9.8 хувь болж огцом буурав. Харин энэ оны хоёрдугаар улиралд инфляцийн хүлээлт ямар байх талаар Монголбанкны түүврийн аргаар авсан судалгааг хүснэгтээс харна уу

Иргэд аж ахуйн нэгж болон судлаачдын инфляцийн хүлээлт



ДЭЛХИЙ ДАХИНД

Мьянмар улсын ДНБ өмнөх таван жилд дунджаар таван хувийн өсөлттэй байсан бол өнгөрсөн онд 6.3 хувиар өсчээ. Тус улсын Засгийн газар эдийн засгийг чөлөөлж, реформ хийх зорилгоор 2011 оноос эдийн засгийн өсөлтийг дэмжих болсон. Өнгөрсөн онд болсон үерийн улмаас хөдөө аж ахуйн салбарын өсөлт саарч аж үйлдвэрийн бүтээгдэхүүн, үйлчилгээний өсөлт харьцангуй сайн байсан нь дээрх өсөлтөд эерэгээр нөлөөлжээ.

Австралийн Төвбанк гадаад валютын нөөцийнхөө таван хувьтай тэнцэх хөрөнгө оруулалтыг БНХАУ-ын Засгийн газрын бондод хийхээр төлөвлөөд байна. Тус банкны гадаад валютын нөөц 39.2 тэрбум ам.доллараар хэмжигддэг. Өнгөрсөн дөрөвдүгээр сарын эхээр хоёр улс своп хэлцэл хийсэн бөгөөд австрали доллар юаньтай шууд худалдаа хийдэг гуравдагч валют болж чаджээ.

БНСУ-ын эдийн засаг энэ оны эхний улиралд сүүлийн хоёр жилд байгаагүйгээр буюу 0.9 хувиар өссөн нь барилга, хөрөнгө оруулалт болон экспорт дахин сэргэсэнтэй холбоотой аж. Энэ нь эдийн засаг сэргэхгүй байх гэсэн түгшүүрийг арилгахад бага ч болтугай хувь нэмэр болжээ. Харин экспорт эхний улиралд 3.2 хувиар өссөн боловч өмнөх улирлынхаас 1.2 хувиар буурсан үзүүлэлттэй байв.

“HSBC” банкнаас хийсэн судалгаагаар өнгөрсөн сард БНХАУ-ын аж үйлдвэрийн салбарын өсөлт удааширчээ. Тус банкны PMI (purchasing managers’ index) аж үйлдвэрийн салбар өнгөрсөн гуравдугаар сард 51.6-аас 50.5 болж буурсныг харуулжээ. Шалтгааныг экспортын шинэ захиалгын тоо багассантай холбож буй бөгөөд энэ нь дэлхий дахинд эрэлт тааруухан байгаагийн илрэл гэжээ. Өнгөрсөн онд урд хөршийн эдийн засгийн өсөлт сүүлийн 13 жилд байгаагүйгээр буурсан үзүүлэлттэй байжээ.

ОХУ-ын хоёр дахь том зээлдүүлэгч болох төрийн өмчит “ВТБ” банк нь Кипр улс дахь үйл ажиллагаагаа зогсоож, тус улсын “Оросын арилжааны банк” салбарынхаа зээлийн ихэнх багцыг бусад салбар руу шилжүүлэхээр шийдвэрлэжээ. Шалтгаан нь тус салбараас ОХУ-ын бизнесмэнүүдэд ихэнх зээлийг олгосонтой холбоотой гэж санхүү эрхэлсэн захирал Херберт Мүүс хэлжээ. “ВТБ” банкны Кипр дэх салбарын хадгаламж ойролцоогоор хоёр тэрбум ам.доллартай тэнцэх аж. ■

А.Амарсайханы булан



Шог зургийг А.Амарсайхан

ОНЦЛОХ

АФРИКИЙН ЦӨЛӨӨС ТАЛЫН МОНГОЛ ХҮРТЭЛ

И.ОТГОНЖАРГАЛ

Монгол Улс өнгөрсөн сард том гүрний төр, засгийн тэргүүн, томоохон орны төлөөлөгчдийн хөлд дарагдав. Японы Ерөнхий сайд Шинзо Абэгийн шилийг дарж, Бүгд Найрамдах Турк улсын Ерөнхий сайд Режеп Тайип Эрдоан айлчилсан. Түрүүчийн айлчилсан төрийн тэргүүний Монголын Засгийн газартай хамтрахаар үзэглэсэн Санамж бичгүүдийн бэх нь хатаагүй байхад дараагийн “томчууд” мөрөн дээр нь гишгэх болж. Тухайлбал, Ерөнхий сайд Н.Алтанхуягийг Туркийн Ерөнхий сайдтай гадаад хамтын ажиллагааны талаар юу ярьсан бэ гэсэн улстөржсөн асуудлаар ээрэх үед дараагийн ээлж болох Ардчилсан орнуудын хамтын нийгэмлэг/АОХН/-ийн Сайд нарын төлөөлөл “Сайн байна уу, Монгол Улс” хэмээн элдэгхэн мэндчилэх жишээтэй.

Азийн жижигхэн Монголд АОХН-ийн Сайд нарын VII бага хурал болж, 100 гаруй орны 1000 гаруй төлөөлөгч дөрөв хоног тухаллаа. Улаанбаатар хотод 2003 онд Ардчиллыг шинээр болон сэргээн тогтоосон орнуудын олон улсын бага хурлыг 500 орчим төлөөлөгчтэйгээр хийж байсныг эс тооцвол олон улсын хэмжээний төр, нийгмийн томоохон хурлыг ойрын 20 жилд хийгээгүй тухай албаны хүмүүс мэдээлж байсан. АОХН-ийн хурал дэлхийн тавцанд яригдах дээд хэмжээний хурал гэдэг нь өнгөрсөн өдрүүдэд мэдрэгдэв. Манайх гурав, дөрөвхөн жилийн өмнө 1000 хүн хүлээн авах зочид буудал, хурлын танхим байхгүй гэж суудаг байсан бол өнөөдөр АОХН-ийн Сайд нарын 1000 гаруй төлөөлөгчийг түүртэж сандрах зүйлгүй бүр дээд хэмжээнд хүлээн авч, сайн зохион байгуулж, сайхан сэтгэгдэлтэй үдлээ. Хурлын үеэр үг хэлсэн гаднын зочид, төлөөлөгчид ч “Юуны өмнө Монгол Улсад АОХН-ийг өнгөрсөн хоёр жилд сайн даргалж, хурлыг сайхан зохион байгуулж байгаад талархаж буйгаа илэрхийлье” хэмээн олонтаа давтаж байсан нь манж үг биш байсан



нь хурлын үйл явцаас мэдрэгдэж байлаа. Хуралд ардчиллын цогтой тэмцэгч Нобелийн шагналт, Мьянмарын Парламентийн гишүүн Ан Сан Сү Чи, Йемений Нобелийн шагналт, хатагтай Таваккол Карман нарыг урьсан нь дээд хэмжээний уулзалтын ач холбогдлыг улам өндөрт өргөж байв. Түүнчлэн НҮБ-ийн Ерөнхий нарийн бичгийн даргын орлогч, Европын комиссын Дэд ерөнхийлөгч, Нигерийн Дэд ерөнхийлөгч, Тайландын Ерөнхий сайд, Финляндын Гадаад хэргийн сайд зэрэг дэлхийн нэр нөлөө бүхий эрхмүүд ч цөөнгүй оролцсон ардчиллын хурал шинэ Монголын нэр хүндийг дэлхийн тавцанд өргөсөн том үйл явдал боллоо. Африкийн цөлөөс талын Монгол хүртэлх цэнхэр гаригийн улсуудын талыг нь эгнээндээ нэгтгэсэн АОХН-ийг хүссэн орон нь даргалж, хурлыг зохион байгуулаад байдаггүй аж. Монгол Улс хоёр зүйлээрээ тус нийгэмлэгт нэр хүндээ өргөж чадлаа. Нэгдүгээрт, 2011 онд манай улс Литва улсаас АОХН-ийг даргалах хүндтэй үүргийг хүлээн авсан. Даргалах хугацаандаа идэвх, санаачилгатай ажиллаж чадсан гэдэг үнэлгээг анд нөхдөөсөө авч чадлаа. Монгол ийм үнэлгээ авахаар юу хийсэн бэ гэдэг талаар Ерөнхийлөгч Ц.Элбэгдорж “АОХН гэдэг энэ байгууллагыг бид жинхэнэ байнгын ажиллагаатай байгууллага болгож хувиргалаа. Биднийг анх хоёр жилийн өмнө даргалах үүрэг авч байхад Удирдах зөвлөл, Гүйцэтгэх хороо, Байнгын ажиллагаатай Ерөнхий нарийн бичгийн дарга гэж байгаагүй. Бид өнгөрсөн хугацаанд гишүүн улс орнуудтайгаа хамтраад Удирдах зөвлөл, Гүйцэтгэх хороо байгууллаа. Ерөнхий нарийн бичгийн дарга томилогдоод ажиллаж байна.

Бидний гол санаачилга бол ардчиллын боловсролыг түгээх ажил байсан. Энэ асуудлаар гишүүн орнуудтайгаа ярилцаж анх удаа НҮБ-ын Ерөнхий ассамблейн 67 дугаар чуулганаар ардчиллын боловсролыг дэмжих тогтоол батлуулсан. Энэ бол маш чухал зүйл. Мөн авлигыг үл тэвчих, туршлага сургамжаа хуваалцах, бүс нутгийн ардчиллыг идэвхжүүлэх гэсэн хэд хэдэн санаачилга гаргасан” гэв. Мөн энэ талаар АОХН-ийн Ерөнхий нарийн бичгийн дарга хатагтай Мариа Лайсснарын юу гэж хэлснийг манай сэтгүүлийн 12 дугаар хуудаснаас сонирхоорой.

Уг хурал Монголын нийслэл Улаанбаатарт гурван өдөр болж, зочин орнуудын улс төр, иргэний нийгэм, бизнес, залуучууд, эмэгтэйчүүдийн байгууллагын төлөөлөл ардчиллын үнэт зүйл, хөгжлийн тухай өргөн хүрээнд хэлэлцсэн нь монголчуудад ардчиллын үнэ цэнийг мэдрүүлэв. Монгол Улсын Ерөнхийлөгч хурлын дараа Ан Сан Сү Чи-тэй тусгайлан тавьсан илтгэлийнхээ үеэр “Манайхан хурлаас нэг л юмыг сайн ойлгосон байх гэж бодож байна. Ардчиллын төлөөх анд нөхөд маань бидний ярьдаг л юмыг ярьж байгааг анзаарсан байх” хэмээн онцлон тэмдэглэсэн. Тэд нээрээ л манайхны ярьдаг, маргадаг иргэний нийгэм, шударга ёс, шүүх засаглал, эмэгтэйчүүдийн шийдвэр гаргах түвшний оролцоо, залуучуудын боловсрол, эдийн засгийн ардчиллын тухай асуудлуудыг ярьдаг юм билээ. Гэхдээ ярихдаа үнэт зүйл, мөн чанар, тулгарч байгаа асуудал, шийдэх гарцыг нь илүү тодорхой, энгийн ойлгомжтой ярьж хэлэлцдэгээрээ манайхнаас өөр бөгөөд давуу байв. Бас их сонирхолтой байв.

Ялангуяа ардчиллыг төлөвшүүлэхэд иргэний нийгмийн байгууллага, залуучууд, эмэгтэйчүүдийн оролцоо ямар чухал вэ гэдэг талаар хуралд оролцсон Монголын салбар салбарын төлөөлөгчид энгийн хэрнээ шинэлэг ойлголт авсан нь манай сэтгүүлд орсон дотоод, гадаадын төлөөлөгчдийн ярианаас харагдана байх. 100 гаруй орны төлөөлөгчийг хамарсан АОХН-ийн Сайд нарын VII бага хурал нэгдсэн хуралдаанаас гадна иргэний нийгэм, эмэгтэйчүүд, залуучууд, бизнесийн ардчилал, парламентчдын чуулга уулзалт гэсэн таван салбар хуралдаанд тулгуурласан билээ. Энэ таван салбар бол ардчиллын үнэт зүйл, төлөвшилтэй холбоотой олон олон асуудал дээр байнга яригддаг чухал сэдвүүд. Тиймээс Монголын Парламентад суудлын тоо нь өнгөрсөн онд гурав дахин өссөн эмэгтэй УИХ-ын гишүүдийн хувьд уг хурал үнэ цэнэ, эрч хүч, эв эеийг нь илүүтэй мэдрүүлсэн хүндтэй арга хэмжээ байлаа гэж хэлж болно. Хурлын уур амьсгал, үйл явц, үр дүнгийн талаар манай дэлгэрэнгүй сурвалжлагаас сонирхоорой.

АОХН-ийн Сайд нарын VII бага хурлын ач холбогдол, үнэ цэнийг бодож “Mongolian Economy” сэтгүүл шинэ дугаарынхаа зай талбайг харамласангүй. Ардчиллын 24 жилийн түүхтэй талын Монголд ардчилагчдын бүтэн гурван өдөр туршлага, сургамжаа хуваалцсан хурлын сэдэв үүгээр дуусахгүй. Манайхыг ардчиллын андууд маань “Ардчиллын зүрх улс” хэмээн тодорхойлж байгаа ч бидэнд тэднээс суралцах зүйл их бий. Тийм учраас манай сэтгүүл дараа дараагийн дугаартаа авлига, иргэний нийгэм, залуус, эмэгтэйчүүд гээд ардчиллын сэдвийг байнга хөндөж, ардчиллын төлөвшил, хөгжилд хувь нэмрээ оруулах болно. ■

СУРВАЛЖЛАГА

АРДЧИЛЛААР ГОЁСОН **МОНГОЛ УЛС**



Б.ТУЯА

Ургуйн улирал айлчилж, ээх нарны элчтэй зэрэгцэх шувуудын жиргээн хотын гудамжаар “чихэлдэх” төмөр хүлгүүдийн хүнгэнэх моторын дуут нам даран эгшиглэх нь тэр. Цээж дүүрэн амьсгалах цэвэр агаар, “цэгцэнд” орсон нийслэлийн гудамж, талбай өнгө, зүс нэмэх нь сэтгэл сэргээж, нүд баясгах болов. Дүн өвлийн хүйтнийг дундрахгүй хар утаан дунд үдэх улаанбаатарчууд хаврын налгар өдрүүдийг тэсэн ядан хүлээсэн биз ээ.

Гэрэлтэж “гялтаганах” Улаанбаатар хот сая нэг “Мишээсэн дагина шиг” дүрээ нийслэлчүүддээ бүрэн утгаар нь харууллаа. “Хогондоо дарагдаад дийлдэхээ байлаа” хэмээн бухимддаг байсан нийслэлчүүд “Бид цэвэрхэн байж чаддаг юм байна” гэж урамтай нь аргагүй мишээхийн учир юунд байв?

2013 оны дөрөвдүгээр сарын 27. Гадаад, дотоодын төлөөлөгчид төдийгүй ургах нартай уралдах хэвлэлийнхэн саатах тотгоргүй төв замаар салхи татуулан Төрийн ордонын зүг яарна. Эзэн Чингисийн хөшөөнд хүндэтгэл үзүүлэн гудайх 104 орны далбай жанжин Сүхбаатарын талбайг улам чимнэ. ››

Дэлхийн өнцөг булан бүрээс цуглах ардчиллын алтан хараацайнуудыг эх орондоо урих хүндтэй үүргийг Монгол Улс хоёр жилийн тэртээ хүлээсэн билээ. Энэ хүрээнд Ардчилсан орнуудын хамтын нийгэмлэгийг (АОХН) ахалсан Монгол Улс зүтгэл нэгт гишүүн орнууддаа ардчиллыг хөхиүлэн дэмжих, сурталчилахад тулгарах саад бэрхшээл, ололт амжилт, туршлагаасаа хуваалцаж, санал бодлоо солилцох индэр болох үүднээс АОХН-ийн Сайд нарын VII бага хурлыг Азийн цагаан дагина гэгдэх Улаанбаатар хотноо чуулж байгаа нь энэ. Нийслэлийн бүү, хэл улсын түүхэнд ийм олон гаднын зочдыг өндөр дээд хэмжээнд урисан нь ховор. Хэдий тийм ч энэ их ажлын ард амжилттай гарсан тухай тус нийгэмлэгийн Ерөнхий нарийн бичгийн дарга Мариа Лайсснар, Европын комиссын Дэд Ерөнхийлөгч Катринь Аштон, АОХН-ийн Парламентийн чуулга уулзалтын Ерөнхийлөгч Эммануэл Зингэрс нарын нэр хүндтэй төлөөлөгч дуу нэгтэй хэлж байсан юм. Түүнчлэн залуу атлаа хүчирхэг ардчиллыг хөгжүүлж чадсан Монгол Улс ардчиллыг дэлгэрүүлэх элч орон төдийгүй ардчилсан тогтолцоонд шилжих гэж буй эсвэл дөнгөж шилжээд буй орнуудад сайн үлгэр дуурайлал болно хэмээн цохон тэмдэглэсэн юм. Гурван өдөр үргэлжилсэн уг чуулганыг Монгол Улсын Ерөнхий сайд Н.Алтанхуяг нээн “Дүр эсгэсэн ардчилал бус жинхэнэ ардчиллыг хөхиүлэн дэмжих зорилт тавьсан Ардчилсан орнуудын хамтын нийгэмлэгийг хоёр жилийн хугацаанд даргалсан нь манай улсын хувьд нэр төрийн хэрэг байлаа. Энэ хугацаанд нийгэмлэгийн хамт олноосоо ихийг сурч, ардчиллын замаар замнасан туршлагаасаа хуваалцах онцгой завшаан гарлаа” хэмээн онцолсон юм. Ингээд тус чуулганы хүрээнд Параламентчдын, Иргэний нийгмийн, Эмэгтэйчүүдийн, Залуучуудын болон Бизнесийн ардчиллын гэсэн салбар хуралдааныг зохион байгуулж, хоёр дахь өдрийн төгсгөлд ардчилсан нийгэмд эмэгтэйчүүд, залуус болон иргэний нийгмийн оролцоо амин чухал төдийгүй ардчилсан шилжилтийг дэмжиж, нээлттэй засаглалыг төлөвшүүлэх нь дүр эсгэсэн ардчиллыг халах үндсэн “жор” болох, ардчилал хэмээх аялалд итгэл, зүтгэл хамгаас чухал хэмээн тунхагласан юм. Түүнчлэн Сайд нарын хурлын үеэр МАХН-ын зохион байгуулсан тайван жагсаал Монгол Улсад хүний эрхийн тулгуур зарчим болох үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхийг эрхэмлэн дээдэлдгийг харуулсан үйл явдал боллоо хэмээн зарим төлөөлөгч сэтгэл хангалуун ярьж байсныг нуух юун.

Зочид төлөөлөгчдөөс олон сайд, дарга, эрдэмтэн судлаач нэгдсэн болон салбар хуралдаануудын найрсаг хийгээд ажил хэрэгч төрхийг илтгэх эрхэмсэг индэрт тухалж, хурал удирдаж, үзэл бодлоо илэрхийлж байсан. Ардчиллын тулгуур зарчим, үнэт зүйл, илт тод нээлттэй засаглал, авлигатай тэмцэх, хууль дээдлэх, шударга шүүх засаглал зэрэг үндсэн сэдвүүд хурал бүр дээр сөхөгдөж байлаа. Тухайлбал, Монгол Улс нээлттэй засаглалын чиглэлээр хэрхэн ажиллаж байна вэ гэдэг талаар манай Ерөнхий сайд болон ЗГХЭГ-ын дарга Ч.Сайханбилэг нар шинэчлэлийн Засгийн газар аль болох иргэдэд нээлттэй ил тод байх чиглэлээр нэлээд шинэчлэл хийж байгаа. Манай Засгийн газар 11 11 утас ажиллуулж иргэдийн санал гомдол хүлээн авдаг болсон. Түүнчлэн Иргэний танхимд Засгийн газрын сайд нар ээлжээр салбарынхаа талаар мэдээлэл хийдэг болсон тухайгаа зочдод сонирхуулсан юм. Тэгвэл гаднын орнуудад Засгийн газар ил тод нээлттэй байх чиглэлээр энгийн, ойлгомжтойгоор бүр ч ихийг хийдэг аж. Жишээлбэл, “Ардчиллын төлөөх нээлттэй засаглалыг төлөвшүүлэх нь” сэдэвт нэгдсэн хуралдааны үеэр Индонезийн Ерөнхийлөгчийн стратегийн санаачилга, олон улсын хамтын ажиллагааны асуудал эрхэлсэн дэд сайд хатагтай Тара Хидаяатай “Индонези 2011 онд нээлттэй засаглалыг төлөвшүүлэх хөтөлбөрөө баталсан. Энэ хүрээнд төсвийн нээлттэй индексийг сайжруулж чадсан. Төсвийн бүх үйл явц иргэдэд ил тод байдаг. Ингэхдээ төсвийг иргэдэд ойгомжтой байх хамгийн энгийн хялбар хэлбэрээр гаргасан байдгаараа онцлогтой. Засгийн газрын хариуцлага гэдэг бол зөв үйлчилгээг, зөв цагт олон нийтэд хүргэх үйл ажиллагааг хэлнэ. Мөн манайх Засгийн газрын яам, агентлагуудад иргэдийн зүгээс тавьсан асуудлыг шийдвэрлэх явц ямар түвшинд явна вэ гэдгийг иргэн интернэтээс шууд хараад мэдэх боломжтой байдаг” хэмээн сайн туршлагаасаа хуваалцав.

АОХН-ийн Сайд нарын VII хурал онцлог содон зүйлээр дүүрэн байсан ч гурав дахь өдрийн дуулианы эзэд өөрчлөлт, шинэчлэлийг зөвхөн эрчүүд бүтээдэггүйн тод жишээ болсон хүний эрхийн төлөө тэмцэгч, Нобелийн Энхтайвны шагналт Ан Сан Су Чи болон Нобелийн Энхтайвны хамгийн залуу шагналт Таваккол Карман нар байв. Тэргүүлэгчдийн ширээнд морилсон тэд ардчилал хэмээх энгийн атлаа төгсөшгүй тэмцэлд боловсрол агаар мэт чухал төдийгүй авилга, хүний эрхийн асуудлууд чөдөр болдог тухай өөрсдийн илтгэлдээ дурдаж байлаа. Ардчиллын боловсролыг бага наснаас эхлэн олгож, ойлгуулах нь цаашдын төлөвшил болоод улсын орны хөгжил “эрүүл” байх үндэс болдог хэмээн онцолсон. Түүнчлэн авилгаас ангид нийгэм ардчиллыг бэхжүүлэх тэргүүний шалгуур байдаг тухай Мьянмар улсын парламентийн гишүүн хатагтай Ан Сан Су Чи өөрийн орны жишээнээс дурдан тайлбарлаж байсан юм.

Ийнхүү гурван өдөр “Ардчилал” гэх нэгэн гэр бүл цуглан алдаа оноо, ололт амжилтаа хуваалцаж эргэн уулзах товоо Эль Сальвадор улсад тогтсон юм. Хурлыг хааж Монгол Улсын Ерөнхийлөгч Ц.Элбэгдорж “Өнгөрсөн гурван өдөр урам зориг бадраалаа. Та бүхнийг хараад надад Тереза эхийн хэлсэн үг санаанд орж байна. “Бид зүтгэж байна. Бид зүтгэсээр байх болно” хэмээн тэр хэлсэн байдаг. Та бүхний зүтгэлд баярлалаа” хэмээн Төрийн ордны Их танхимд цугласан олонд хандаж хэлсэн.

Эцэст нь хэлэхэд, төлөөлөгчид төдийгүй иргэдийн амгалан тайван байдлыг онцгой хамгаалан ажилласан цагдаа нар болон энэхүү чухал үйл явдлын талаарх мэдээллийг чадан ядан хүргэсэн үзэг нэгт хэвлэлийнхэндээ талархах нь зүйтэй болов уу. ■

ЗОЧИН

ХҮЛЭЭХ БУС САНААЧИЛ

Б.ҮҮРИЙНТУЯА

АОХН-ийн Ерөнхий нарийн бичгийн дарга Мариа Лайсснартай Монгол Улсад болсон АОХН-ийн Сайд нарын VII бага хурлын үеэр ярилцлаа. Шведийн Парламентийн гишүүн асан түүний улс төрийн түүхэн замнал арвин туршлагаар дүүрэн билээ.
Хатагтай Лайсснар 2012 оны дөрөвдүгээр сараас АОХН-ийн анхны Ерөнхий нарийн бичгээр ажилласан. Ардчиллын алтан хараацайнуудын нэг тэрбээр хүний эрхийн төлөө тэмцэгч, залуучуудын дуу хоолойг улс төрийн индэрт хүргэхэд үнэтэй хувь нэмрээ оруулж буй хатагтай юм.

-Ардчиллыг энгийнээр тайлбарлахгүй юу?

-Ардчилал гэдэг бол сонгуульд оролцож саналаа өгөх замаар засаглаж буй төрийг шинэчлэх боломжийг хэлдэг. Нэг үгээр, өмнөх засаглалд сэтгэл хангалуун бус байвал энхийн замаар өөрчлөлт авчрахыг хэлнэ. Зарим оронд сонгууль болдог ч олонхын саналыг үл ойшоох тохиолдол байдаг. Тэгэхээр сонгууль боллоо гээд ардчилал тогтоно гэсэн үг биш юм. Энэ нь эрх зүйт төрд саналын хуудсаараа хувьсгал хийхийг хэлдэг.

-Ардчилсан орнуудын хамтын нийгэмлэгийн (АОХН) гишүүн орон болохын тулд ямар шаардлагуудыг хангасан байх ёстой вэ. Нийгэмлэгийн гол зарчим юунд оршдог бол.

-Юуны өмнө, ардчилал гэх үгийг зөвхөн хэлэх бус хэрэгжүүлж, улмаар үнэнч байхыг чухал шалгуур болгодог. Үг хэлэх эрх чөлөө, хэвлэлийн эрх чөлөөг дээдлэх, олон намын систем зэрэг ардчиллын тулгуурыг эрхэмлэн дээдэлдэг байх учиртай.

АОХН-ийн Сайд нарын бага хурлаар илүү өргөн хүрээг хамрахыг зорьдог тул дэлхийн өнцөг булан бүрээс төлөөлөгчдийг урин оролцуулдаг уламжлалтай. Ардчилал бүрэн тогтоогүй улс, орнуудаас ч төлөөлөгчид ирэх нь бий. Харин удирдах зөвлөлд ардчиллыг улсынхаа гадаад бодлогын нэг хэсэг болгон, улмаар ардчиллын замаар гаднын орнуудтай хамтын ажиллагаа тогтоох хүсэлтэй орнуудыг багтаадаг.

Товчхондоо, АОХН-ийн үйл ажиллагааг дэмжиж, ардчиллыг нутагшуулахад үнэнчээр тэмцэх орнуудыг элсүүлдэг гэсэн үг.

-Монгол Улсын ардчиллыг залуу атлаа хүчирхэг гэдэг. Та үүнтэй санал нийлэх үү?

-Би ямарваа үнэлгээ эсвэл дүгнэлт өгөх эрхгүй. Би Швед улсын иргэн. Шведэд ардчилал хөгжөөд багагүй хугацаа өнгөрч буй ч хийх, өөрчлөх, шинэчлэх зүйл ундарсаар байна. Тухайлбал, цөөнхийн эрхийн асуудал, зарим сүмийн давамгайлсан эрх мэдэл зэрэг зөрчлийн цөм оршин тогтносоор байгаа.

Ардчилал шинэчлэлийг үргэлж шаардаж байдаг тул эцсийн зогсоол гэж үгүй. Монгол Улсын хувьд ардчиллын арвин туршлагатай орнуудтай харьцуулашгүй. Учир нь арчилалд шилжээд удаагүй байна. Гэсэн ч ихээхэн ахиц гарч байгаад сэтгэл хангалуун байна. Алхам алхмаар урагшилж, “эрүүл” хэлцэл, мэтгэлцээнийг хүлээн зөвшөөрөх, ингэхдээ эрх мэдлийг урвуулан ашиглахгүй байх нь ардчиллын хамгийн том шалгуур. Монголчуудаыг туулах урт зам хүлээж байна.

-Залуучууд, эмэгтэйчүүдийн оролцоог нэмэгдүүлснээр ардчиллыг жинхэнэ утгаар нь хөгжүүлдэг гэдэг. АОХН-ийн Сайд нарын VII бага хурлаар ч дээрх асуудлуудыг хөндөж, нухацтай хэлэлцсэн. Тэгвэл Монгол Улсад энэ индэрт хүрэх зам хэр ойрхон байна вэ?

-Би залуучуудад итгэл хүлээлгэдэг. Залуучуудыг нийгмээс тусгаарлахыг тэд хэрхэвч хүлээн зөвшөөрөхгүй. Өнөөдөр тэд хэвлэл мэдээлэл, интернэт гээд гадаад ертөнцтэй төвөггүй холбогдож байна. Тэд эрхээ мэддэг, эрхээ хэнээс хаанаас нэхэхээ ч ухамсарласан. Ийм учраас тэднийг өөрчлөлт хийсээр байна гэдэгт би эргэлздэггүй.

Харин эмэгтэйчүүдийн эрх, нийгэм дэх байр суурь, оролцооны асуудал зөвхөн Монголд гэлтгүй дэлхий даяар хүнд байна. Эмэгтэйчүүдийн ардчилсан төлөөлөл өнөөдөр тун бага төдийгүй тэднийг салан тусгаарлаж байна. Хүйсийн ялгаагаар эрчүүдэд боломж харамгүй олгодог нь





Фотог Б.Бямба-Очир

1985-1991 онд: Швед улсын Парламентын гишүүн. Энэ хугацаандаа тус улсын Гадаад харилцааны хороонд ажиллаж харъяатын албаны төлөөлөгч

1991-1994 онд: Афганистан дахь Шведийн тусгай хорооны ахлах

1995 онд: Либерал намын даргаар сонгогдож, тус намын анхны эмэгтэй дарга

2000 онд: Гадаад харилцааны яаманд ажиллах болсноор 2000-2004 он хүртэлх хугацаанд Гуатэмала, Хондурас, Эль Сальвадор, Коста Рика зэрэг оронд элчин сайд

2004-2005: Индонез дэх хүний эрхийн АММ байгууллагын ахлах зөвлөх

2006: Швед улсыг төлөөлөх Ардчиллыг дэмжигч элч

2006-2010: Швед улсын цөөнх ромачуудын асуудлыг хариуцсан Засгийн газрын төлөөллийн удирдагч

2012 он: Ардчилсан орнуудын хамтын нийгэмлэгийн Ерөнхий нарийн бичгийн дарга

нууц биш. Ийм нөхцөлд улс төрд төдийгүй нийгмийн хүрээнд эмэгтэйчүүдийн оролцоог нэмэгдүүлэхийн тулд хуулиар шийдвэрлэх тохиолдол байдаг. Албан бус хэлэлцээрээр зөвшилцөх нь ч бий. Зарим оронд, тухайлбал, Шведэд Их хурал, бусад албан тушаалд жендерийн тэгш байдлыг 40 хувиар тогтоодог. Харин зарим улсад квотын зарчим үйлчилдэг.

Монголд дээрх хоёр замыг аль нэгийг хэрэгжүүлэх хэрэгтэй. Энэ нь зөвхөн парламентад гэлтгүй нийгмийн бусад салбарт ч зохистой.

Жендерийн эрх тэгш байдал дэлхий нийтийн чихнээс хонх уясаар байна.

-Монголын ардчиллын ирээдүйг хэрхэн харж байна. Монгол Улс жинхэнэ ардчиллын тод жишээ болохуйц үлгэр дуурайлал үзүүлж чадах болов уу?

-Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газрын дарга П.Цагааны хэлсэнчлэн монголчуудын ардчилалд шилжсэн түүх баялаг. АОНХ ардчилсан тогтолцоонд шилжиж буй орнуудад туршлага судлах, хуваалцах, суралцах боломж олгохыг зорьдог. Үүний адилаар Монгол Улс тулгарч байсан саад бэрхшээл, ололт амжилтаасаа Мьянмар тэргүүтэй ардчилалд хөл тавьж буй бусад оронтой хуваалцаж буй нь ардчиллыг бэхжүүлэхэд оруулах үнэтэй хувь нэмэр болж байна.

-Сайд нарын удаах хурлыг Эль Сальвадор улс ахлахаар боллоо. Ямар шалгууруар энэ нэр хүндтэй чуулганыг зохион байгуулах эрхийг олгодог вэ. VII бага хурлыг ахалсан Монгол Улс танд болон АОХН-т ямар сэтгэгдэл үлдээв?

-Хурлыг ахлах улсыг бүсчилэн сонгохыг эрмэлздэг. Хэдий тийм ч ямар орнууд АОХН-ийн Сайд нарын хурлыг удирдан явуулах хүсэлтэй байна гэдгээс мөн хамаарна. Багахан хэмжээний өрсөлдөөн, сонгууль хэлбэрээр сонгон шалгаруулалт явуулж, хурлыг зохион байгуулахад хамгийн тохиромжтой гэсэн оронд дээрх эрхийг олгодог.

Монгол Улс ардчиллыг хөхиүлэн дэмжих чин эрмэлзэлтэйгээс гадна Мянганы хөгжлийн зорилтын есдүгээр буюу ардчиллыг хөгжлийн бодлогодоо тусгасан орнуудын нэг. Энэ утгаараа ардчиллыг дэмжигч орнуудыг төлөөлөх сайхан жишээ болж байгаа юм.

Ирэх хурлыг Эль Сальвадор улсад зохион байгуулах гэж байна. Эл улс ардчилсан шилжилт хийгээд удаагүй. Өнгөрсөн хоёр жилийн хугацаанд гаргасан Монгол Улсын хичээл зүтгэлтэй дүйцэхүйц оролцоо үзүүлнэ хэмээн итгэж байна.

-АОХН-т оруулж буй Монгол Улсын хувь нэмэр болоод энэ жилийн чуулганы онцлогыг дүгнэж хэлэхгүй юү?

-Бидний хүсэн хүлээснээр улстөрчдөөр хязгаарлагдахгүй нийгмийн бүхий л хэсгийг хамарсан санал бодлоо хуваалцах, туршлага солилцох сайхан боломж байлаа. Ардчилал гэх энгийн атлаа хувьсгалч энэ ойлголтын нэгээхэн хэсгийг олоход АОХН-ийн Сайд нарын хурлын цөм нь оршдог. Энэ удаагийн чуулганы бүтэц, зохион байгуулалт дээрхийг бүрэн агуулсан нь онцлог боллоо.

-Дүр эсгэсэн ардчиллыг халах үйлсэд дэм болж, тэмцэж буй Монголын ард түмэн, эмэгтэйчүүд, залууст хандаж хэлэх таны үг юу байх вэ?

-Бүжгийн урилга хүлээх хэрэггүй, харин санаачил. Эрх мэдэл, эрх чөлөөг бусад биш, чи өөрөө бүтээнэ. Хэлэлцээр, мэтгэлцээн зэрэг улс төрийн зэмсгээр тэмцэх нь ардчилалд хүрэх зөв зам байх болно. Орон зайгаа бүтээ гэж уриалмаар байна. ■

МЭНДЧИЛГЭЭ

ЖИНХЭНЭ АРДЧИЛСАН ОРОНД АВЛИГА ҮҮРЛЭХ ОРОН ЗАЙ ГЭЖ БАЙДАГГҮЙ



АОХН-ийн хурлын сүүлчийн буюу гурав дахь өдрийн хуралдааны үеэр АНУ-ын Ерөнхийлөгч Барак Обама болон НҮБ-ын Хүний эрхийн асуудал хариуцсан Дээд комиссар хатагтай Нави Пиллай нар видео мэндчилгээ дэвшүүлсэн билээ. Хүний эрхийн асуудал хариуцсан хатагтайн мэндчилгээг сонирхуулж байна.

Та бүхэнтэй уулзаж, энэхүү мэндчилгээг дэвшүүлэх болсондоо би сэтгэл нэн ханамжтай байна. Учир нь өнөөдрийн хурал дэлхийн хэмжээнд ардчиллыг хөгжүүлэх үйлсэд асар чухал үүргийг гүйцэтгэж байгаа юм. Надад үг хэлэх боломж олгосон Монгол Улсын Засгийн газар, зохион байгуулагч нарт талархал илэрхийлье.

Хүний эрх чөлөө гэдэг бол хүмүүс чөлөөтэй хуран чуулж, үзэл бодлоо чөлөөтэй, нээлттэй илэрхийлэх явдал юм. Энэ жил Хүний эрхийн конвенцийн 20 жилийн ой тохиох гэж байна. Тус конвенциар бид хүний эрх, үүргийг хамгаалж, бие биеэ харилцан мэдэж, нэгдэх үйлсийн төлөө хамтран зүтгэж байгаа. Тиймээс хүний эрхийн төлөө гэсэн хүсэл эрмэлзлэл бүхий хөрсийг зөв тавьж, энэ үйлсийг цаашид зогсолтгүй урагшлуулах боломжийг бүрдүүлэх гол үүргийг ардчилсан нийгэм үзүүлэх ёстой юм.

Хүний нэр хүндийг гутаан доромжлохгүй байх, хүнийг хүн ёсоор хүндлэн дээдэлнэ гэдэг бол Хүний эрхийн түгээмэл тунхаглалын оргил зарчим гэдгийг онцлон тэмдэглэе. Мөн үндсэн зорилтот зарчмуудын нэг юм. Хүний нэр хүндийг ямар ч Засгийн газар аль ч үед өөрсдийнхөө анхаарлын гадна орхиж болохгүй юм. НҮБ-ын дүрэм бол Хүний эрхийн түгээмэл тунхаглалд заасан энэ үндсэн гол зарчмыг зөрчих Засгийн газар байх ёсгүйг дахин сануулъя. Ардчиллын амин чухал, салшгүй нэг хэсэг бол шударга ёс, тэгш эрх. Тиймээс ямар ч нөхцөлд Засгийн газар ард түмнийхээ эрхийг хамгаалж, хүсэл эрмэлзлэлийг хүндлэн дээдэлж, ялангуяа бүх нийтийн сонгуулийн үр дүнтэй холбогдуулж үүнийг цохон тэмдэглэж байна. Мөн хүмүүсийн боловсрол эзэмших, эрүүл мэндийн үйлчилгээ авах эрхийг иргэддээ олгох ёстой. Гэхдээ ардчилал өөрөө энэ бүх зүйлийг анхнаасаа бий болгодог гэж үзэж болохгүй. Тийм учраас хүмүүс өөрсдөө ардчиллын төлөө тэмцэх хэрэгтэй. Энэ бүхнийг хангаж, эрхээ бэхжүүлнэ гэж үзэж байгаа бол аль ч улсын засаг төр ил тод, ард түмэнтэй хамт байх ёстой. Үүний тулд бие даасан шүүх засаглалтай байх явдал нь ардчиллын үнэт зүйл юм. Энэ бүх тавьсан зорилтод хүрэхэд ардчиллын саад бэрхшээлийг авлига бий болгож байдаг. Ер нь авлига өөрөө ардчилсан биш нийгэм дотор гарч ирж, өсөн бойжиж байдаг үзэгдэл юм. Яагаад гэвэл жинхэнэ ардчилсан орон, жинхэнэ эрх зүйт төр байхын сацуу хүний эрхийг дээд зэргээр хүндэлж, бүх зарчмыг ягштал биелүүлж байгаа оронд авлига үүрлэх орон зай гэж байдаггүй. Гэхдээ бид нар тийм ардчиллаар явж, тодорхой хэмжээний шинэчлэлтийн үедээ байна гэж хэлж болно. Шилжилтийн үе гэж ямар орныг хэлээд байна гэвэл ядуу, өөрөөр хэлбэл, хүй нэгдлийн тодорхой хэмжээний авлигатай, авлигын хөрстэй. Хүмүүсийн үзэл бодлоо илэрхийлэх эрх тодорхой хэмжээгээр хязгаарлагдмал байгаа орнуудыг хэлж байгаа юм. Тийм учраас миний хэлж буй гол зүйл бол хүний эрхийг эрхэмлэн дээдэлж, хуулийг дээдлэх бол салшгүй хүчин зүйл болохыг давтан хэлье. Яагаад гэвэл хүний эрхийг хүндлэн дээдлэхийн гол механизм нь юу вэ гэвэл тухайн улсын гаргаж, мөрдөж байгаа хуулинд байдаг юм. Тийм учраас хүний эрхийг дээдлэх, хуулийг дээдлэх нь салшгүй зүйл. Учир шалтгаан үүнд оршиж байгаа юм. Дараагийн анхаарал хандуулах зүйл бол янз бүрийн хэлбэрээр тулгарч болох асуудлыг зөв олж харах. Энэ бүхэнтэй тууштай тэмцэх шаардлагатай. Яагаад гэвэл тодорхой хэмжээнд өнөөдөр ардчилал бүрдсэн ч бидний замд бэрхшээл байна.

Хүний нэр хүндэд бүдүүлгээр халдаж байна. Хүний эрхийг зөрчиж байгааг бид мартаж болохгүй. Хүний эрхийн түгээмэл тунхаглалыг зөрчих үзэгдэл гарч байгаа. Энэ бүхнийг цэгцлэх үүднээс манай хорооноос чиглэсэн зорилтод ажлыг зохион байгуулж байна. Тухайлбал, эрх зүйн шинэчлэл явуулах, хариуцлага хүлээх чадвартай төлөөллийг, институцийг бий болгоход анхаарч байна. Үүнээс гадна хүний тархинд ардчиллын боловсролыг суулгаж өгөх талаар бид их ажил хийж байгаа. Энэ нь урт хугацаанд үргэлжлэх үйл явц юм. Үүнийг явуулах хөрс суурийг бүрдүүлэх ёстой.

Ардчилсан улс иргэдийнхээ оролцоог дэмжих хэрэгтэй. Оролцох боломжийг нь олгодог байх учиртай. Тиймээс иргэний нийгмийн байгууллагын хувь нэмрийг өндрөөр үнэлэх. Ардчиллын хурлаас гаргасан энэ талаарх баримт бичгийг сурталчилах, та бүхний үйл ажиллагааг эрчимжүүлэх, эрч хүчийг өгөх, дэлхийн хэмжээнд нэгдмэл ойлголттой байхад хурал үр дүнгээ өгнө гэж найдаж байна. Хүний эрх чөлөөг дээдэлж байгаагаа харуулах тод жишээ болно гэж бодож байна. ■

ИЛТГЭЛ

АН САН СҮ ЧИ:
БУРУУ ЗАМААР АМЖИЛТ ОЛСНООС ЗӨВ ЗАМААР АЛДСАН НЬ ДЭЭР

Хөрвүүлсэн Б.ЭНХЦЭЦЭГ

Өмнөд Африкийн домогт удирдагч Нелсон Манделатай зүйрлэдэг Мьянмар улсын Үндэсний Ардчилсан лигийн тэргүүн Ан Сан Су Чи үндэстнийхээ энх тайвны төлөө тэмцэж, ардчиллын аясын салхийг эх оронддоо авчрахад үнэтэй хувь нэмэр оруулсан эмэгтэй баатар билээ. Тун удахгүй 68 нас зооглох Ан Сан Су Чиг олон улсад танихгүй хүн үгүй болсныг түүний 1991 онд хүртсэн Нобелийн Энхтайваны шагнал гэрчилнэ. Үндэсний тусгаар тогнолын баатар генерал Ан Саны гэр бүлд төрсөн тэрбээр хоёрхон настайдаа аавыгаа алдсан. Ан Сан генералын амийг хөнөөснөөс ердөө зургаан сарын дараа тус улсын тусгаар тогтнол цуурайгаа хадаасан билээ. Оксфордын их сургуульд улс төр, эдийн засаг, философийн чиглэлээр боловсрол эзэмшсэн түүнд Мьянмарыг аврах баатрын зүрх зориг заяажээ. Ардчилсан шинэчлэлийн төлөө тэмцэгч ажилчид болон лам хуваргуудтай нийлэн анх бослого хөдөлгөөнд оролцож эхэлсэн тэрбээр амьралдаа хоёр удаа гэрийн хорионд урт хугацаагаар орж, шоронгийн хаалгыг олонтой татсан байдаг. Ан Сан Су Чи нийт 15 жилийн гэрийн хорионд суусан билээ. Түүний гэрийн хорио 2010 онд дууссан бөгөөд хүү Ким Арис нь өнгөрсөн хугацаанд эх орондоо очихоор виз олонтаа хөөцөлдсөн ч ээжийгээ суллагдсаны дараа буюу 10 жилийн дараа л эргэж ирэх боломж олдсон байдаг. Тэмцэл, хагацал, зовлон дүүрэн амьдралыг туулсан Ан Сан Су Чи Монгол дахь айлчлалынхаа үеэр “Би өнгөрсөн амьдралдаа сэтгэл хангалуун байдаг” хэмээн инээмсэглэн хэлсэн билээ. Ан Сан Су Чи манай улсад АОХН-ийн Сайд нарын VII бага хуралд оролцсон билээ. Манай сэтгүүл энэ удаагийн дугаартаа түүний илтгэлийг бүрэн эхээр нь орчуулан тавихын зэрэгцээ сэтгүүлчидтэй хийсэн уулзалтыг хүргэж байна.

Юуны түрүүнд намайг урьсан явдалд талархал илэрхийлье. Түүнчлэн энэхүү лекцийг тавих боломж олгосон Монгол Улсын Ерөнхийлөгч, Засгийн газрын гишүүд болон Монголын залуустаа баярлалаа.

Олон орны хүмүүстэй тэр дундаа залуустай хамтрах боломж олдоно гэдэг миний хувьд маш олзуурхууштай санагддаг. Би үргэлж хэлдэг шигээ Монголын залууст ч мөн та бүхэн хүн төрөлхтний найдвар шүү гэж хэлмээр байна. Учир нь, тэдний хүсэл эрмэлзлэл, итгэл найдвар, мэдрэмж юу болохыг бид мэдэж байх нь чухал юм. Манай оронд залуус жинхэнэ ардчилалд хүрэх гэсэн бидний зорилго, хичээл зүтгэлд оролцохдоо эрч хүч дүүрэн байгааг харахдаа урам зоригтой байдаг. Залуус эрх чөлөөг хүсдэг. Эрх чөлөө болон ардчиллыг салгаж үл болно. Гэвч ардчилалыг үргэлж үүрэг хариуцлага дагадаг. Үүнийг би цаг үргэлж онцлон тэмдэглэхийг чармайдаг. Зарим хүн ардчиллыг зөвхөн эрх эдлэх гэж ойлгодог. Энэ бол үүрэх ёстой хариуцлагаа үл огоорч, зөвхөн эрх чөлөөгөө эдэлнэ гэсэн үг. Энэ бол миний хөхиүлэн дэмждэггүй зүйл. Хүн төрөлхтний хийж чадах үнэтэй зүйлсийн нэг бол хариуцлагаа ухамсарлах гэдгийг бид ойлгох хэрэгтэй. Залуусыг хариуцлагатай хүн гэдгээрээ бахархдаг байхыг би хүсдэг. Тэднийг ажил үүргээ ямар нэг нэр хүнд, шагналын төлөө, аль эсвэл хөгшин, уйтгартай хүмүүсийн таалалд нийцэхийн тулд хийгээсэй гэж би хүсдэггүй. Одоогийнхоос илүү хариуцлагатай залуу хүмүүс бол аливаа үндэстний аугаа итгэл найдвар юм. Гэхдээ хариуцлага нь ятгалгаас үүдэн бий болдог. Тиймээс бид залуусаас хариуцлагатай байхыг хүсч байгаа бол тэднийг хариуцлагатай байхаас өөр аргагүй болгох ямар нэг үр дүнтэй зүйлээр ятгах, итгэлийг нь төрүүлэх ёстой. Олон жилийн туршид манай орны иргэд ардчиллын наад захын үндсэн эрх чөлөөгөө хасуулсан. Тэдгээр он жилүүдэд Мьянмар улс Зүүн өмнөд Азийн хамгийн дэвшилтэт орнуудын нэг хэмээх хүндтэй байр сууринаас хасагдаж, хойно хоцорсон. Манай ард түмэн ардчилсан эрх, эрх чөлөөгөө хасуулаад зогсоогүй, дотоод үнэлэмж, хүндлэлээ алдсан юм. Ард түмэн дотоод үнэлэмжээ алдана гэдэг үндэстний хувьд ирээдүйн мөхөл гэсэн үг. Бирм улсдаа ардчиллыг буцаан авчрахын тулд бид ард иргэдээ өөрсдийгөө хүндэлж сургах хэрэгтэй байв. Ард иргэд маань ардчиллыг сайн, сайхныг өөрсөддөө бий болгож, олж авахын төлөөх төгсгөлгүй аялал гэдгийг ойлгох хэрэгтэй болсон. Учир нь арчилсан байгууллыг бэхжүүлэх хичээл зүтгэлд төгсгөл гэж үгүй юм. Ардчиллын төлөөх үндэсний лиг буюу манай намыг яагаад ардчилалын төлөө тэмцээд байгааг хүмүүс асуудаг. Тэдэнд би үргэлж “Бид ард иргэд маань эх орондоо эрх чөлөөтэй, аюулгүй ажиллах амьдрах эрхээр хангагдаасай л гэж хүсдэг” ››



Фотог Б.Бямба-Очир

хэлдэг

Хэрэв ардчиллыг хөгжүүлэх гэж байгаа бол эрх чөлөө, аюулгүй байдлыг эрүүл, тэнцвэртэй хадгалах ёстой. Аюулгүй байдлын үүднээс манай ард түмний эрх чөлөө, аюулгүй байдал аль аль нь хангалтгүй байна. Тэд олон арван жилийн туршид үндсэн эрх чөлөөгөө хасуулсан. Эрх чөлөө талаасаа ч гэсэн өөрийгөө хүндэлдэг үндэстнүүдийн иргэн бүрийн хүртэх ёстой аюулгүй байдлыг ард иргэд маань эдлэхгүй байхыг бид хүснэ гэж үү. Тэгэхээр ардчилал гэдэг эрх чөлөө болон аюулгүй байдлыг эрүүл, тэнцвэртэй хадгалахыг хэлж байна. Энэ нь хариуцлага гэсэн үг. Бид зөвхөн өөрсдийн эрх чөлөөний төлөө бус, бусдын эрх чөлөөний төлөө хариуцлага хүлээж байгаагаа ойлгох хэрэгтэй. Үүний адил бид зөвхөн өөрсдийн аюулгүй байдлын төлөө бус, мөн бусдын аюулгүй байдлын төлөө хариуцлага хүлээж байна. Энэ нь бид яагаад хүчирхийллийн бус замыг сонгосны шалтгаан мөн. Хүчирхийлэл нь эрх чөлөө, аюулгүй байдлын аль алиныг нь заналхийлдэг. Биднийхийг ч, мөн бусдынхыг ч. Иймээс бид хүчирхийллийг хөсөр хаяж, ардчилалд хүрэхийг зорьж байна. Энэ талаар хүмүүс мөн асуудаг. Хүчирхийллийн эсрэг хүч хэрэглэн цэргийн дэглэмийг унагаах гээд бүтэлгүйтсэн олон хүн байдаг. Учир нь, цэрэг гэдэг зэвсэгт хүчнээр л тодорхойлогдоно. Цэргийн дэглэмийг зөвхөн цэрэг, армийн хүчээр унагах боломжтой гэсэн итгэл, үнэмшлийг олон хүн тээж явсан. Харин би хэзээ ч үүнд итгэж байгаагүй. Хүн төрөлхтөн учир, шалтгаанд нээлтэй байдаг гэж би боддог. Энхтайван замаар өөрчлөлтийг авчирч болдог гэдэгт би итгэдэг нь шалтгаанд нээлттэй байдгийнх. Энхтайван замаар замнах нь хүчирхийллийн замаас урт удаан байдаг. Гэхдээ урт удаан замд бидний зорьж буй зорилгод хүрэх зам бол богинохон. Учир нь хүчирхийллийн хор уршгаар эдгэхэд маш олон жил шаардагдах олон гүн шарх үлддэг. Заримдаа тэдгээр шарх улам идээлж, удаан үргэлжлэх нь ч бий. Мөн эргэн тойрны хүмүүст хуваагдал, гуниг зовлон, гансрал, үл итгэлцлийг авчирдаг. Эдгээр шарх нь эдгэхдээ маш удаан бөгөөд хүрэхээр зорьж буй эцсийн зорилгыг улам холдуулдаг. Харин хүчирхийллийн бус зам урт ч санагдах ч эцэст нь үлдэх шарх, зовлон бага байдаг. Энхтайвны төлөөх замналаас үүдсэн шарх амархан бороолдог. Тайван замаар замнаснаар бид тавьсан зорилгодоо урт хугацаанд хүрэх ч олон бэрхшээлтэй тулгардаг. Мэдээж зэвсэгтэй хүний өөдөөс гар нүцгэн өөрийгөө хамгаалах хэцүү нь ойлгомжтой. Тэгэхээр хүчирхийллийн бус замаар ардчиллын төлөө тэмцэхэд шийдлийг олж, бат зогсох ёс суртахууны эрэмгий зориг илүүтэй хэрэгтэй. Бидний хүсч буй зүйл цаашид тогтвортой үргэлжлэх шийдэл болохоос амархан сарних зуурдын шийдвэр биш. Ардчиллын талаар хэтэрхий их ярьж байна гэж зарим хүн хэлэх байх. Энэ бүхэн тэгээд юуны төлөө юм, юу нь тийм гайхамшигтай юм бэ гэж тэд асуудаг. Ингэж хэлдэг хүмүүс ардчилсан эрх чөлөөг удаан эдэлсэн хүмүүс байдаг гэж бид боддог. Намайг Лондонд байх он жилүүдэд олон найз маань сонгууль өгөх сонирхолгүй байгааг би анзаарсан. Энэ нь улстөрчдийг шинжлэх ухааны хүмүүс, эрдэмтдээс дорд гэж үздэг сэхээтний хүрээн дэх өвөрмөц сэтгэлгээ бөгөөд өөрсдийгөө гадагш гарч, тэдний төлөө сонгууль өгөх нь зохисгүй гэж тэд бодож байсан. Үүнд би үнэхээр сэтгэл дундуур байсан бөгөөд учир нь би Англид байх үедээ огт сонгууль өгч үзээгүй. Намайг мэдээ орох үеэс л манай оронд шударга, чөлөөт сонгууль гэж байгаагүй. Нэр дэвшигчид болон намд өөрийн сонголтоор санал өгөх нь ямар болохыг би мэддэггүй байлаа. Тиймээс ч би Англид байгаа найзууддаа хандан сонгууль

Бид өнгөрснийг ирээдүйн хичээл болгон ашиглах ёстой болохоос дөнгө болгож болохгүй. Хэрвээ бид өнгөрснөөр хөлөө тушиж, юу үзэж өдийг хүрсэндээ шаналсаар байвал өнгөрсөн рүүгээ буцсаар л байх болно.

өгөх эрхээ эдлэх хэрэгтэйг хэлдэг байв. Учир нь энэ та бүгдийн үүрэг учраас эрхээ эдлэх ёстой гэж. Хэрэв та бүгд өөрийн саналаа өгч, үүргээ биелүүлэхгүй бол нэг л өдөр эрхээ алдах аюул бий. Найзуудаа саналаа өгдөг болтол нь хангалттай үглэсэн гэж боддог. Сүүлд би Японд айлчлахдаа ахмад хүмүүс залуусын талаар надтай адилхан гомдоллож байгааг харсан. Тэнд залуус санал өгөх сонирхолгүй аж. Миний бие Японы их сургуульд залууст зориулан тавьсан лекцэндээ саналаа өгөх эрхээ эдлээч гэж хэлсэн. Учир нь энэ бол мөн тэдний хариуцлага юм. Саналаа өгөхгүй байх нь эрх чөлөөгөө доромжилж буй хэрэг. Түүнчлэн би одоо 68 настай ч чөлөөт, шударга сонгуульд нэг ч удаа саналаа өгч чадаагүйгээ тайлбарласан юм.

Манай оронд чөлөөт сонгууль 1990 онд болсон ч тэр үед би гэрийн хорионд байлаа. Би саналаа өгөхийг хүссэн. Хуулийн дагуу гэртээ хоригдсон ч саналаа өгч болох байв. Тиймээс санал хураалтыг миний өмнөөс зохион байгуулж, би харгалзагчийн хараанд санал өгсөн л дөө. Гэхдээ энэ бол өөрийн дэмжихийг хүссэн намд болон хүнд санал өгөх эрхээ эдэлсэн гэж үзэж болохгүй үйл явц байсан. Тухайн үед өөрийн амьдарч байсан хэсэгтээ намаасаа нэр дэвшихээр сонгогдсон ч нэр дэвшигчээс намайг түдгэлзүүлсэн. Харамсалтай нь дэндүү оройтсон учир манай намд тухайн тойрогт нэр дэвшүүлэх өөр хүн байгаагүй. Тиймээс л бид өөр намд саналаа өгөхөөс аргагүйдэж байлаа. Саналаа өгч чадсан гэж хэлж болох ч чөлөөт гэдэг ухагдахууны дор би саналаа өгч үзээгүй. Би өөрийн намын дэмжихийг хүссэн нэр дэвшигчийн төлөө саналаа өгч чадаагүй юм. Би үүнийг япон залууст тайлбарлаж, саналаа өгөх гэдэг хэчнээн үнэтэй эрх болохыг ойлгуулахыг зорьсон. Одоо ч би шударга, чөлөөт сонгуульд санал өгч үзээгүй л явна.

Өнгөрсөн жилийн дахин сонгуулиар төрсөн газрын минь суудал сул байгаагүй. Тиймээс би өөр газраас төрд гарсан. Тэр хэсэгт харьяаллаа шилжүүлэлгүйгээр саналаа өгч болохгүй байсан л даа. Тиймээс би одоо ч шударга ардчилсан сонгуульд саналаа өгөөгүй байгаа.

Монголын санал өгөх эрхтэй бүх залууст та бүгд эрхээ эдлэх ёстой шүү гэж хэлье.

2010 оны сонгулиас өмнө хүмүүст үүнийг их энгийнээр тайлбарлахыг хичээсэн. Гэвч тэдгээр сонгуулийн үеэр НҮБ-ын тодотголоор бид гүн шархалсан байв. Сонгуульд итгэх хүмүүсийн итгэл 2010 оны сонгуулиар төдийлэн сайжраагүй. Тиймээс түрүү жилийн бидний гол зорилгуудын нэг 45 тойрог бүхий сонгуулийн хэсэгт очиж саналаа өгөхийг уриалах явдал байлаа. Бидний уриалга их энгийн. Ямар нийгэмд амьдармаар байна, түүнийгээ тэд өөрсдөө шийдэх ёстой байв. Өөрөөр хэлбэл тэд улс, үндэстнийхээ ирээдүйд хариуцлагатай байх хэрэгтэй болсон. Хариуцлагатай байх нэг зам нь ганц л өдөр сонгуульд саналаа өгөх юм. Мөн хүн бүрийн санал өгөх эрх Ерөнхийлөгчийнхтэй адил эрх тэгш. Түүнд санал өгөх ганцхан эрх байдагтай ижил бусад жирийн иргэн бүрт нэг эрх бий. Тиймээс та бүхэн саналаа өгөх хэрэгтэй гэж бид ард түмнээ уриалсан. Учир нь энэ бол иргэний дээд эрх. Ерөнхийлөгч хүртэл чамаас давуу эрхгүй. Эцэст нь бидний кампанит ажил чамгүй амжилттай хүрч, сонгуульд оролцох эрхтэй хүмүүсийн 70 гаруй хувь нь санал хураалтанд оролцсон. Чөлөөт, ардчилсан сонгуульд дасал болоогүй манай ард түмэнд дээрх тоо нь гайхалтай үр дүн байлаа. Түүгээр зогсохгүй, манай ард түмэн сонгох эрх нь давуу байдал гэдгийг ойлгож эхэлсэн. Тиймээс ардчилал, эрх чөлөөний төлөөх замнал бол хүний оюун ухаан, зүрх сэтгэлээр дамждаг жим юм. Хүмүүст ардчиллын үйл явцад оролцох нь эрх төдийгүй үүрэг хариуцлага юм гэдгийг ятган ойлгуулах ёстой. Энэ эрх чөлөө бол хууль ёсонд захирагдахыг хүлээн зөвшөөрч, үүрэг хариуцлагаа ухамсарласан эрх чөлөө юм. Хууль ёс бол ардчилсан тогтолцоог бий болгоход асар чухал. Бид хууль ёс гэдэг шударга үнэнд нийцсэн тохиромжтой хууль гэсэн үг гэдгийг ойлгох ёстой. Хууль ёс гэдгээр бид Засгийн газар соёрхон батлагдсан тэдний эрх ашгийг хамгаалж, ташуурыг нь зузаатгасан хууль гэсэн утгаар нь хэлээгүй.

Өнгөрсөн жил манай нам сонгуульд өрсөлдөхөд бидний мөрийн хөтөлбөрт багтсан голлох ажлуудын нэг нь Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах явдал байлаа. Тус Үндсэн хууль нь 2008 онд бүх нийтийн санал асуулгаар батлагдсан хууль. Түүн дээр Үндсэн хуулийг батлахад нийт иргэдийн 92 хувь нь саналаа өгсөн гэдэг. Гэвч энэ тоо тун эргэлзээтэй. Үүнийг хойш нь тавиад харвал тус хууль маш сайн суурь бүхий хэсгүүдтэйд эргэлзэх зүйл үгүй. Үндсэн хууль бол улсын амин сүнс. Хэрвээ ардчилсан Засгийн газар тогтвортой, уян хатан урагшлая гэвэл амар тайван, өрнөл бүхий нийгмийг бүрдүүлж чадах хүмүүст хүлээн зөвшөөрөгдсөн шударга Үндсэн хуультай байх нь зайлшгүй юм. Хүмүүсийн итгэл төрөөгүй Үндсэн хууль бол жинхэнэ ардчилалд хүргэх хууль биш. Үндсэн хууль бол дээд хууль учир нэмэлт өөрчлөлт хийхээс өөр арга үгүй. Бид Үндсэн хуулиа хамгийн сайн нь байгаасай гэж хүсч байна. Ард түмний дийлэнх нь хүлээн зөвшөөрсөн хууль байх ёстой.

Бирм бол олон хүний гэр. Манай улс олон үндэстэн ястнаас бүрддэг. Манай улсын дотоодын ялгаатай байдал бидний үндэстнээрээ бахархах хүчин зүйл. Харамсалтай нь бид үүнийгээ хараахан сайн ойлгоогүй байна. Өөр байдлыг хүч гэж харахаар тэрхүү ондоошил нь биднийг заналхийлж байгаа мэт боддог хүн олон бий. Гэвч тийм биш. Хамаагүй өөр байна гэдэг харьцангуй олон боломж гэсэн үг. Амар тайван, харилцан зохицол дунд амьдарч сурах боломж юм. Бие биенээсээ өөр ондоо байдлыг үл харгалзан бид 1988 оноос хойш үндэсний нэгдлийн төлөө зүтгэж ирлээ. Ардчиллын төлөөх зам ч үндэсний эв нэгдлийн төлөөх зорилгод суурилж эхэлсэн. Бидэнд улс төрийн хүчин, ард түмний зүгээс хүлээн зөвшөөрсөн Ардчилал хэрэгтэй. Зөвхөн нэг нь хүлээн зөвшөөрснөөр хол явахгүй.

Цэргийн дэглэм олон жил ноёрхсоны дараа манай ард түмний дийлэнх нь цэргийнхэнд дайсагнах хандлагатай болчихсон. Гэвч үүнийг өөрчлөх хэрэгтэй. Бирмийн армийг энэ үндэстэнд тусгаар тогтнол авчрах гэж байгуулсан түүхтэй. Миний аав Бирмийн армийг 1940 онд байгуулж

байхад, тэд илүү их хүмүүсээр хүрээлүүлж, хайрлуулдаг байлаа. Манай ард түмэн цэргүүдийг хамгаалагч гэж хүлээн авдаг байв. Бид тийм л хандлагыг иргэдийнхээ дунд хадгалж үлдэх ёстой юм. Иргэний нийгэм, цэрэг арми хоорондын ойлголцлыг олон жилийн өмнөх бахархлаар хэмжигддэг байсан шигээ болж, эргэн сэргэнэ гэдэгт итгэж байна. Үндэсний эв нэгдэл сэтгэл зүрхнээс бий болох ёстой. Ийм л учраас бидний ардчилал, эрх чөлөөний төлөөх зам хүмүүсийн зүрх сэтгэл, оюун ухаанаар дамжин бий болох учиртай. Бид хүмүүсийг итгэ гэж хүчилж чадахгүй. Итгэсэн мэт дүр үзүүлүүлж чадах ч үнэн итгэлцэл албан хүчээр бий болдоггүй. Харин ухамсарт нь хүргэх замаар л үүсдэг. Хүчээр шийдсэнээс илүүтэй хүн амын дийлэнх хэсгийг ятгах замаар тодорхой үнэт зүйлүүдийг хүлээн зөвшөөрүүлэх нь хугацаа их шаарддаг. Авторитар/ Захиргаадалтын дэглэмийн дор амьдарч байсан Монголын иргэд магадгүй үүнийг илүүтэй сайн ойлгох биз ээ. Өөрийн өмнөх дотоод үнэлэмж, итгэлээ өөрчилж, одоогийнхтой нийцүүлнэ гэдэг ямагт хэцүү болохыг та нар мэднэ. Бид ард түмнээ дотоод ертөнцдөө зөрчилдөж, гаднаа нийцсэн мэт жүжиглэж, улмаар тарж бутраасай гэж хүсэхгүй байна. Хүмүүс итгэл үнэмшил, бодол саналаа чөлөөтэй илэрхийлж болох ч бусдад хохирол учруулах замаар эрхээ эдэлж үл болохыг ямагт санах нь зүйтэй. Бусдын эрх гэдэг өөрийн чинь эрхтэй адил юу юунаас илүү чухал. Зөвхөн өөрийн эрх, ямбаа бодож бусдынхыг огоордог хэсэг бүлэг ардчиллыг ойлгодоггүй.

Ардчилал өөр ондоо байдлыг нэг үнэт зүйл дор нэгтгэдэг. Энэ бол бусдын санаа бодлыг өөрийнхийгөө зөв гэж боддогтой адил хүлээн авч, үнэлж дүгнэх тухай юм. Өөрийгөө бусдаар хүндлүүлэхийг хүсдэг шиг бусдынхыг мөн хүндэлж сурна гэсэн үг. Эцэст нь, Ардчилал бол хэцүү байдаг шигээ амархан зүйл. Хүний нэр төр, үнэлэмжийг өөрийнх шигээ хүндлэхэд л ардчилал суурилдаг. Ийм учраас хүний эрхийг ардчиллаас салгах боломжгүй. Тиймээс л бид ардчилал, хүний эрхийн төлөөх тэмцлийн тухай ярьдаг.

Ардчилал бол тогтоон барихад хамгийн хэцүү тогтолцоонуудын нэг. Бид зөвхөн тэмцлээ зориулаад зогсохгүй түүний төлөө амьдрах хэрэгтэй. Зарим үед тогтолцооны төлөө амьдрахаас илүү тэмцэх нь амархан байдаг. Ардчилал руу алхах хамгийн хэцүү үе нь хувьсгалын тактикуудаа больж, илүү боловсронгуй улстөрч аргаар зорилгодоо хүрэх цаг нь болсныг ойлгох юм. Ардчиллын чухал чанар нь сөрөг хүчнээ хүлээн зөвшөөрөх байдаг. Эрүүл сөрөг хүчин эрүүл ардчлалыг хадгалах нөхцөл болдог. Би өөрийн улсдаа сөрөг хүчнээ төлөөлдөг. Манай намын хувьд олон түмний дэмжлэгийг нэлээд хүлээсэн нам гэж боддог. Бусад намаас илүү дэмжлэг хүлээдэг гэж хэлмээр байна. Хууль тогтоох байгууллагын хувьд бид 600 гаруй гишүүн дундаа ердөө 45-уулаа. Гэвч тэдгээр 600 хүн эрх баригч намд харьяалагддаггүй. Тэд олон үндэстний олон намаас бүрддэг. Эрх баригч Үндэсний нэгдэл, Хөгжлийн төлөөх эвлэлийн намаас гаднах Парламентад хамгийн олон суудалтай нам нь манайх юм. Хэдийгээр тоогоор цөөн ч хууль тогтоох байгуулал хамтран ажилладаг учир манай нам хүчтэй сөрөг хүчин байж чаддаг. Дээд, доод танхимийн дарга гар, гараасаа барилцан, хамтарч намуудад шударга ханддаг. Иймээс Парлемантад хэлэлцэж буй асуудлуудад бидний оролцоо өндөр. Энэ нь эв нэгдэл боломжтой бөгөөд, хамтарч ажиллах нь өнгөрсөнд өширхөж, бие биенийхээ эсрэг ажиллаж ирсэн үеэс илүү удаан, тогтвортой зам гэдгийг харуулж буй хэрэг юм. Бид өнгөрснийг ирээдүйн хичээл болгон ашиглах ёстой болохоос дөнгө болгож болохгүй. Хэрвээ бид өнгөрснөөр хөлөө тушиж, юу үзэж өдийг хүрсэндээ шаналсаар байвал өнгөрсөн рүүгээ буцсаар л байх болно. Үүнийг бид хүсэхгүй. Өнгөрсөн үе гэдэг нам, үндэстэн, ард түмний хувьд ирээдүйд алдаагаа давтахгүй байх хичээл юм. Хэрвээ бид өнгөрснөө дээш гарах шат болгон ашиглаж, илүү сайхан ирээдүй өөд зүтгэвэл, ичих зүйл үгүйгээр ардчилал, эрх чөлөөний аль алинд нь хүрэх нь дамжиггүй. Ирээдүйд үр хойчид маань ч ичих зүйл үгүй юм. Ялалтад хүрэх замнал нь ялалт шигээ үнэтэй.

Залуу Буруу замаар амжилт олсноос зөв замаар алдсан нь дээр гэж үргэлж хэлдэг. Учир нь ичгүүр сонжууртай, буруу замаар ирсэн амжилт бол жинхэнэ амжилт биш. Энэ бол хүн төрөлхтний ёс суртахууны хамгийн том алдаа юм. Харин бүтэлгүйтлээ даван гарч, илүү чадварлаг хүн, байгууллага, үндэстэн болж чадвал энэ бол алдаа бус ирээдүйд хүрэх гүүр юм. Ардчилал бол сурах үйл явц.

Сайн, муу, тэнэг, цэцэн гэж би ялгадаггүй. Харин сурч чадах, чадахгүй гэж хүмүүсийг ялгадаг. Сурна гэдгийг би ном сурах, бичиг, анги танхим, амьралаас сурах тухай гэж ойлгодог. Хэрвээ бид ардчилалд хүрэхийг хүсвэл мөн тэрхүү амжилтаа удаан оршин тогтноосой гэж хүсч байвал бид үргэлж суралцагсад байх ёстой. Бид насан туршдаа сурахад өөрсдийгөө бэлдэх нь зүйтэй. Ардчилалд хүрчихлээ гэж хэлэх нь зөвхөн хангалттай биш. Ардчиллын үнэ цэнэ нийгмийн амьдралд гүн үндсээрээ сууж, бат оршиход бид анхаарах ёстой. Ардчилсан байгууллалууд нь хүчтэй, үе уламжилсан байх нь зөв юм. Энэ бол бидний үр хойчдоо үеэс үед өвлүүлж үлдээх ёстой үүрэг, хариуцлага. Залуу үеэ суралцагч, үндэстнээ суралцагсад болгож чадахгүй аваас бид хүрсэн ардчиллынхаа алтан үнэ цэнээ тогтоон үлдээж чадахгүй. Бирм улс өнөөдөр ардчилалд нэвтрэх хаалганы өмнө зогсож байна. Бид хаалгаар хараахан орчихоогүй байна. Зүгээр л үүдэн дээр тулаад зогсож байгаа. Бидэнд олон боломж нээгдэж байгаатай адил олон аюул хаалга тогшин зогсож байна. Мөн аугаа их итгэл найдвар бидэнд бий. Хэрвээ бид боломжоо буруу ашиглавал, ийм боломжийг дахин олж авахад дахиад хэдэн жил зарцуулахыг төсөөлөхөд бэрх. Тиймээс манай улсын хувьд ямар сорилтуудтай нүүр тулах гэж байгаагаа сайн мэдэх нь чухал. Сорилтуудтай нүүр тулж байгаа энэ үед бид дэлхийн өнцөг, булан бүрт буй нөхөддөө, мөн эхлэл нэгтэй монгол найзуудаа хандаж байгаа. Би энд ирээд Ерөнхийлөгчтэй их сонирхолтой яриа өрнүүлж, түүнд манай улсын иргэд ч мөн хөх толботой төрдөг гэдгийг хэлсэн. Тиймээс бид холбоотой хүмүүс гэхэд эргэлзэх зүйл үгүй. Бид дэлхийн олон найзаасаа тэр дундаа төрөл садан монголчуудаасаа олон сорилттой тулгарч, гүн үндэст ардчилал, эрх чөлөөг ойрын ирээдүйд эх орондоо авчрахад туслаач хэмээн

Залуу үеэ суралцагч, үндэстнээ суралцагсад болгож чадахгүй аваас бид хүрсэн ардчиллынхаа алтан үнэ цэнээ тогтоон үлдээж чадахгүй.

ХЭВЛЭЛИЙН ХУРАЛ

БИДНИЙГ ДЭЛХИЙ ДАЯАР “АЛТНЫ ХОЁР ТОМ УУРХАЙ” ГЭЖ ЯРЬЖ БАЙГАА

Хатагтай Ан Сан Су Чи Монгол Улсын Ерөнхийлөгч Ц.Элбэгдоржтой лекц уншсаныхаа дараа хэвлэл мэдээлийнхэнтэй уулзаж, сонирхсон асуултад нь хариулт өгсөн билээ.

“Mongolian Economy” сэтгүүл:

-Мьянмар, Мозамбик болон Монгол Улс буюу “Гурван М” нь шинэ зууны “Торгоны зам” хэмээн цоллогдож буй. Танай улс Ардчилалд хөл тавиад удаагүй байна. Ардчилсан эдийн засагт орны хувьд чөлөөт худалдаа, гадаадын хөрөнгө оруулалт томоохон байр суурь эзэлдэг. Тэгвэл Мьянмар улс дэлхийн эрэлт, нийлүүлэтийн сүлжээнд нэгдэх тал дээр ямар бодлого баримтлах гэж байна вэ. Өөрөөр хэлбэл үүдээ хэрхэн нээх вэ?

-Хөрөнгө оруулалтын орчинг бид бүрдүүлэхээр ажиллаж байна. Боломжууд гарч ирж байна. Гэхдээ бидний хүссэн хэмжээгээр хөрөнгө оруулалт хараахан орж эхлээгүй байгаа. Бид сонголтоо тэр дундаа эдийн засгийн сонголтоо тун ухаалаг хийхгүй аваас эргээд төр, засгийн бодлого буруу замаар хэрэгжих вий гэдгийг хүмүүстэй хэлж байгаа. Бид төр, засгаасаа хариуцлагатай байдал, ухаалаг, холыг харсан зөв шийдвэрүүд мөн популист биш амлалт гаргаж чадах тийм эр зоригийг хүлээж байгаа. Тиймээс энэ гурван үндсэн зарчмыг хөрөнгө оруулалттай холбоотой гаргаж байгаа шийдвэрүүддээ суурь болгож авч үзнэ гэж хардаг.

-Та манай хоёр улсын хоорон дахь цаашдын дипломат харилцааг хэрхэн төсөөлж байна вэ?

-Монгол Улстай бид найрсаг, ойр дотно харилцаатай байна гэдэгтээ огт эргэлздэггүй. Хоёр улсын хооронд дипломат харилцаа тогтоох хөрс нь хэдийнэ бүрдсэн. Цаашдаа бидний харилцаа үргэлж дардан замаар явна.

Яагаад гэвэл, бид адилхан ардчилсан замналаар явж байгаа, үнэт зүйлс нэгтэй, нэг бүс нутгийн улсууд. Дээр нь биднийг дэлхий даяар “Алтны хоёр том уурхай” гэж ярьж байгаа. Энэ утгаараа бидэнд хуваалцах болон бие биеэсээ суралцах, хамтран давших боломжууд их бий.

-Ардчиллын бэлгэ тэмдэг болж яваагийн хувьд бид таны амжилт, тэмцлийг гэрчилсээр өдийг хүрлээ. Ардчиллын нэг хэсэг байхад эдийн засаг, улс төрийн хувьд эмэгтэй хүнд тулгарч болох хамгийн хүнд бэрхшээлүүд юу вэ?

-Намайг хүний эрхийн төлөө тэмцэгч, бэлгэ тэмдэг гэж ярихад надад эвгүй байдаг. Би ингэж хэлүүлэх төдийлэн дуртай биш. Зүгээр л ардчиллын төлөөх хар ажилчин гэж хэлбэл үнэнд илүү ойртох юм болов уу.

Манай улсад хүйсийн тэгш бус байдал ажиглагдаж байгаа. Ялангуяа “Эмэгтэйчүүдийг улстөрд оролцохдоо эрчүүд шиг амжилттай байж чадахгүй” гэсэн хэвшмэл ойлголт байдаг.

Бид эрчүүдэд байдаг энэ буруу ойлголтыг өөрчлөхөөс гадна эмэгтэйчүүддээ өөртөө итгэх итгэл өгөх замаар өөрчлөх ёстой. Өөрөөр хэлбэл, бид эмэгтэйчүүдэд илүү боловсрол олгож, илүү өөртөө итгэх итгэлийг нь сэргээж өгөх ёстой юм болов уу гэж бодож байна.



Монголын Үндэсний Олон Нийтийн Радио Телевиз:

-Юуны өмнө таны Монголд ирээд төрсөн сэтгэгдлийг сонсмоор байна.

-Мэдээж газар зүйн хувьд болоод байгаль, цаг уурын хувьд Монгол, Мьянмар хоёр өөр. Би өмнө нь Монгол шиг эрс тэс уур амьсгалтай оронд байж үзсэнгүй. Жишээ нь, Мьянмараас наашаа гарахад тэнд 39 градусын халуун байсан. Байгаль, цаг уурын хувьд бол ийм байна. Харин хувь хүний тухайд Монголд ирээд өөрийгөө гаднын хүн гэж огт төсөөлөөгүй. Монгол хүмүүсийг ч гэсэн миний зүрх сэтгэлээс хол хүмүүс гэж бодохгүй байгаа.

Гаднаас нь харахад ч бид Ази хүмүүс. Бидний баримталж байгаа дэг жаяг, үг хэллэг гээд олон төстэй зүйл ажиглагдсан. Харин монголчууд хоол хүнсэндээ цагаан идээ их хэрэглэдэг юм шиг санагдсан. Иймэрхүү цөөн ялгааг эс тооцвол бид адилхан хүмүүс.

-Та Монголын ардчиллын загварыг хэрхэн үнэлж байна вэ?

-Би ардчиллыг загварчлах дургүй. Монголын, Бирмийн загвар гэж хэлэхээс би татгалздаг. Манай орны өмнөх удирдагчид Бирмийн, Мьянмарын ардчилал гэж их ярьдаг байсан. Ингэж загварчлах тусам бид ардчиллыг хязгаарлаж, хайрцаглаж байдаг. Ингэснээр бид түгээн дэлгэрүүлэх ёстой ардчиллын бусад үзэл баримтлалыг хязгаарладаг гэж боддог учраас би ингэж ярих дургүй. Ер нь энэ бол бидний л сонгосон зам. Энэ зам ямар байх нь биднээс шалтгаална.

Монгол Улсыг өөрийнхөө оронтой харьцуулбал ардчиллын зам дээр биднээс нэлээд түрүүлж яваа. Гэхдээ бидэнтэй найрсаар хамтран ажиллаж буй учраас тун удахгүй бид тэнд хүрнэ. Бусад улс шиг Мьянмар ардчиллын замаар замнаж чадна гэдэгт би итгэдэг.

News.mn

-Таныг олон жил гэрийн хорионд байх үед манай одоогийн Ерөнхийлөгч Ерөнхий сайдаар ажиллаж байсан үе давхцдаг. Түүнийг таныг гэрийн хорионоос суллахын төлөө тодорхой алхмуудыг хийж байсан гэдэг. Таны энэ асуудал дээр үлдсэн сэтгэгдэл.

-Намайг гэрийн хорионд байхад миний төлөө дуу хоолойгоо өргөсөн дэлхийн бусад орны бүх удирдагчид би талархаж явдаг. Гэхдээ би Монгол Улсын Ерөнхийлөгчид илүү талархдаг. Учир нь, тухайн үед Азийн удирдагчдын дуу хоолой сонсогддогүй, тэд дуугардаггүй байсан.

Ази тивээс цөөн хэдэн хүн л дуугарч байлаа. Тэр үед Ц.Элбэгдорж Ерөнхийлөгч миний эрх чөлөөний төлөө зоригтой бөгөөд тод дуугарсан. Миний төлөө гаргасан түүний энэ сэтгэл миний зүрхэнд онцгой байр суурь эзэлдэг.

Би түүнд байнга талархаж явдаг. Би зөрчилдөх, тулалдах, тулгарах гэдэг үгийг би хэрэглэх дургүй. Үүний оронд зөрүү буруугаа арилгаж, нэг зүгт харах чадвартай болохыг хүсдэг.

Японы сэтгүүлч:

-2015 онд Мьянмарын Ерөнхийлөгчийн сонгууль болно. Та өрсөлдөх үү?

-Шууд хэлэхэд надад тийм сонирхол байгаа. Зарим хүмүүс энэ асуултад эргэлзэнгүй, бөөрөнхийлсөн хариулт өгдөг. Харин би тэгэхгүй. Надад Мьянмарын Ерөнхийлөгч болох төлөвлөгөө, хүсэл, зориг байгаа.

Улс төрийн намын тэргүүн байж, улстөрд ажиллана гэдэг улсынхаа Ерөнхийлөгч болох зорилготой л байна гэсэн үг. Тийм учраас би 2015 оны Ерөнхийлөгчийн сонгуульд оролцоно. ■



НОБЕЛИЙН ЭНХТАЙВАНЫ ШАГНАЛТАН

ХУВЬСГАЛЫН ЭЭЖ

Р.ГАНТУЛГА

Таваккол Карман нь Йемен улсад “Төмөр хатагтай” болон “Хувьсгалын ээж” хэмээн алдаршсан бөгөөд 2011 онд гарсан “Арабын хавар” хөдөлгөөний нэг хэсэг болох Йеменийн бослогыг удирдаж, ардчиллыг талархан дэмжигч олон улсын нүүр царай болж чадсан гавьяатай нэгэн.

Тэрбээр 1979 оны хоёрдугаар сарын 7-нд Йемен улсын Мекалиф Таизз мужийн Таиз хотноо төрж, өсчээ. Түүний эцэг Абдел Салам Карман нь улстөрч хүн бөгөөд тус улсын Хууль зүйн яамд хуульчаар ажиллаж байгаад тэтгэвэртээ гарчээ. Дүү Тарик Карман нь яруу найрагч, бас нэг дүү Сафа Карман нь “Ал Жазера” мэдээллийн агентлагт ажиллаж байна.

Боловсролын хувьд тэрбээр Йемен улсын нийслэл Санаа хотын Шинжлэх ухааны их сургуулийг худалдааны чиглэлээр, Санаагийн их сургуулийг улс төрийн шинжлэх ухааны чиглэлээр төгсч, 2012 онд Канадын Алберта их сургуулийн хуулийн докторын зэрэг хүртжээ. Одоо нөхөр, гурван хүүхдийн хамт амьдардаг аж. ▸▸



Фотог Б.Бямба-Очир

Таваккол Карманийн улс төрийн байр суурь

Таваккол Карман нь Лалын шашинтай Нобелийн шагнал хүртсэн хоёр дахь эмэгтэй, тэр дундаа хамгийн залуу шагналтнаар тодорсон юм. Сэтгүүлч, улстөрч, хүний эрхийн төлөөх зүтгэлтэн бөгөөд Ал-Ислах улс төрийн намын гишүүн. Тэрбээр 2005 онд “Women Journalists Without Chains” хэмээх эмэгтэй сэтгүүлчдийн холбоог бусад сэтгүүлчтэй хамтран байгуулж, тэргүүнээр нь ажиллах болсон. 2007 онд сэтгүүлчээр ажиллаж байхдаа хэвлэлийн эрх чөлөөний төлөөх тэмцэгчдийг дэмжин удирдаж, долоо хоногийн эсэргүүцлийн жагсаал зохион байгуулснаар олны танил болоод зогсохгүй тухайн асуудлыг реформ болгон өргөжүүлсэн байна. Тус улсын тэмцэгчдийг “Жасмин хувьсгал”-ыг дэмжихэд удирдан чиглүүлж, түүнийгээ “Арабын хавар” хэмээн нэрийджээ. Улмаар тус улсын Ерөнхийлөгч Али Абдуллах Салехийн бурангуй дэглэмийг унагах зорилгоор дуу хоолойгоо илэрхийлж, эсэргүүцсээр иржээ.

2010 онд болсон тэмцлийн үеэр нэгэн эмэгтэй түүний амийг хөнөөх гэж оролдсон боловч дэмжигчдийнхээ хүчээр амь гарч чадсан байна. Мөн 2011 онд тус улсын улс төрийн нэгэн эрх мэдэлтэн түүнийг утсаар сүрдүүлж, олон нийтийн эсэргүүцлээ даруй зогсоохгүй бол дүүгийнх нь амийг хөнөөнө гэж заналхийлж байжээ. Үүний цаана Ерөнхийлөгч Салех сүрдүүлсэн гэж “New Yorker” сэтгүүлд бичжээ.

Түүний гэр бүлийн гарал үүсэл Турк улсын Караман хэмээх газрын Анатолиа гэж тэрбээр мэдүүлэх болсон нь сүрдүүлгээс үүдэлтэй ч байж болох. Ямартай ч Туркийн Засгийн газар өөрийн иргэншлийг түүнд санал болгосон бөгөөд тэрбээр саналыг хүлээн авснаар өнгөрсөн онд Туркийн иргэншил авсан байна.

Таваккол Карман нь Ал-Ислах намын гишүүн бөгөөд намынхаа “Shura Council” гэх зөвлөлд алба хашдаг аж. Ал-Ислах нь нөлөө бүхий улстөрийн хүчин бөгөөд 2005 оноос хойш Ерөнхийлөгч Салехийг эсэргүүцэж эхэлснээр лалын ертөнцөд хүрээгээ улам тэлжээ. Гэхдээ уг намын гол бүрэлдэхүүн хэсэг “Muslim Brotherhood” болон “Salafists” бүлэглэлийн гишүүдээс бүрддэг байна. Карманы хувьд дээрх хоёр бүлэглэлийн алинд ч хамаарахгүй, дундыг баримталдаг.

Улс төрийн тэмцлээ өөрийн орны хэвлэлийн эрх чөлөөг өмгөөлж, хамгаалснаар эхэлсэн. Тэмцлээ эхэлж байх үедээ “Бид бурангуй ёст дэглэмийн төлөө, эрх чөлөөгөө хасуулахын тулд энд дуудагдаагүй” гэж бичсэн байдаг. Тэрбээр 2004 онд үндэсний телевизээр нэвтрүүлсэн хурлын үеэр анх удаа гивлүүргүй олны өмнө гарч, гивлүүр нь уламжлалт соёл болохоос лалынхны дарангуйлах хэрэгсэл биш гэсэн санаагаа илэрхийлж байжээ.

Эх орных нь охид, бүсгүйчүүд хоол, тэжээлийн дутагдалд орж байхад хөвгүүдийн нөхцөл өөр байгаа, бичиг үсэг үл мэдэх түвшин маш өндөр буюу ялангуяа эмэгтэйчүүдийн гуравны хоёр нь бичиг үсэг тайлагдаагүй байгаа зэрэг асуудлыг хурцаар тавьж, 17 нас хүрээгүй охидыг хүнтэй суулгахыг хориглох талаар хуулийн нэмэлт заалт оруулахыг олон нийтээр дэмжүүлж чадсан юм. Түүнчлэн Засгийн газрын авлигын эсрэг тэмцлийг удирдан зохион байгуулсан. Авлига авсан орон нутгийн эрх мэдэлтнүүд тосгон, суурин газар дахь олон гэр бүлийн газрыг хууль бусаар авах болсноос хойш Ерөнхийлөгч Салехийн эсрэг зогсох түүний байр суурь улам хүчтэй болсон юм.

Тэрбээр улс төрийн аль нэг намын харьяалалгүй, гаднын нөлөөллөөс ангид гэдгээ тодорхой илэрхийлдэг бөгөөд “АНУ, Европын холбоо болон Арабын орнуудтай хүний эрхийг хамгаалах үйл хэрэгт эрх тэгш хамтран ажилладаг” гэжээ. “Би бол энэ дэлхийн иргэн. Эх дэлхий бол миний эх орон бөгөөд хүнлэг чанар бол миний үндэстэн” гэж АНУ-ын Мичиганийн их сургуулийн өмнө хуран цугласан олны өмнө хэлжээ. ■

АЛБАНЫ ХҮНИЙ ҮГ

ӨНДӨР ҮНЭЛГЭЭ ӨГЧ, ЗОРИЛГОО ТОДОРХОЙЛСОН

Ардчилсан орнуудын хамтын нийгэмлэг (АОХН)-ийн асуудал хариуцсан Тусгай уурэгүйцэтгэгч Элчин сайд С.Бадралаас хурлын зохион байгуулалт болоод "Улаанбаатарын тунхаг"-ийн талаар тодрууллаа.



-АОХН-ийн Сайд нарын VII бага хурлыг Монгол Улс амжилттай зохион байгуулллаа. Энэ хурлыг зохион байгуулах бэлтгэлийн сайтар базаахаас эхлээд өндөр дээд хэмжээнд зохион байгуулж, өндөрлөх хүртэлх нийт хэчнээн төгрөгийн төсөв зарцуулсан бэ. Нөгөө талаас ийм Дээд хэмжээний уулзлтыг эх орондоо зохион байгуулах нь тухайн орны эдийн засагтаа ихээхэн ач холбогдолтой байдаг гэж ярьдаг шүү дээ.

-Нийтдээ улсын төсөвт 3.0 тэрбум төгрөг төсөвлөсөн байсан. Тэрнээс хэдийг нь зарцуулав гэдгийг одоо тооцож байгаа. Бид аль болох хэмнэлттэй зарцуулах тал дээр анхаарч ажилласан. Ер нь олон улсын хурал зохион байгуулахад Монгол Улсын эдийн засагт нэлээд орлого ордог. Манай холбогдох компаниудын ашиг орлого нэмэгдсэн. Дөрөвдүгээр сарын сүүлчээр жуулчны улирал хараахан эхлээгүй байдаг боловч МИАТ, томоохон зочид буудлууд, ресторан, үзвэр, үйлчилгээний газруудын орлого өмнөх жилийнхээ мөн үеэс огцом нэмэгдсэн байх гэж бодож байна. Мөн манай уламжлалт ноолуур, гар урлалын бүтээгдэхүүн сайн борлосон.

-Хурлын үр дүн юу байх вэ. Жишээ нь " Улаанбаатарын тунхаг"-т хамгийн гол нь ямар асуудлыг тусгаж өгсөн байгаа вэ?

-Хурлын үр дүн гэвэл олон байна. Тухайлбал, Монголд бараг ирээгүй байсан хүмүүс олноороо ирлээ. Тэд бол манай шинэ найз нөхөд. Манай орны хөгжил дэвшил, хүмүүсийн зочломтгой сайхан занд гаднын зочид маань маш өндрөөр үнэлсэн. Тэд дахин Монголд ирнэ гэсэн сэтгэгдэлтэй буцлаа. Хамгийн гол нь монголчууд ардчиллыг үнэхээр чин сэтгэлээсээ хүсдэг юм байна, ардчиллыг бэхжүүлэхийн төлөө сэтгэл гарган ажилладаг юм байна, ардчилалд Монгол Улс эргэлт буцалтгүй оржээ гэдгийг ардчиллын төлөө зүрх сэтгэлээ зориулсан олон улсын тэмцэгчид нүдээр харлаа.

-"Улаанбаатарын Тунхаглал"-д Монгол Улс АОХН-ийг даргалсан хоёр жилд хийсэн ажлыг өндөр үнэлээд цаашдын зорилтоо тодорхойлсон.

-АОХН-ийн хурлаас гадна АОХН-ийн Ази, Номхон далайн орнуудын Гадаад хэргийн сайд нарын уулзалт мөн болсон. Энэ хурлын анхаарал хандуулсан асуудал нь юу байсан бэ?

-Монгол Улс АОХН-ийг даргалахдаа таван зорилго тавьсны нэг нь бүс нутгийн хамтын ажиллагааг урагшлуулах асуудал байлаа. Энэ чиглэлээр бид анхнаасаа анхаарал тавьж ирсний жишээ бол 2011 оны наймдугаар сард Монгол Улсын Ерөнхийлөгч БНСУ-ын Ерөнхийлөгчтэй хамтран «Ардчиллын төлөөх Азийн түншлэл» хэмээх санаачилга дэвшүүлсэн явдал юм. Ази тивд улс төр, аюулгүй байдал, ардчиллын чиглэлээр хамтран ажилладаг механизм байхгүй байсаар өдий хүрсэн. Ийм шинэ механизм бий болгох гэж олон орон олон жил зүтгээд бүтээгүй байдаг. Иймээс дээр дурдсан манай Ерөнхийлөгчийн санаачилгыг урагшлуулахад амаргүй байлаа.

АОХН-ийн Ази, Номхон далайн Гадаад хэргийн сайд нарын зөвлөлдөх уулзалт зохион байгуулсан нь Азийн ардчилсан, ардчиллыг эхлүүлж буй орнуудыг нэгтгэх анхны алхам болснооро ач холбогдолтой. Бид хоёр жил дутам ийм зөвлөлдөх уулзалт зохион байгуулж байхаар шийдвэрлэсэн нь маш чухал үр дүн.

Улмаар бид энэ санаачилгаа алхам алхмаар урагшлуулж, ирээдүйд Азийн орнуудын улс төр, аюулгүй байдлын хамтын ажиллагааны механизм бий болгох зорилттой ажиллаж байна. ■



Фотог Б.Бямба-Очир


OF MONGOLIA



















Фотог Б.Бямба-Очир

“MONGOLIAN ECONOMY” СЭТГҮҮЛИЙН АСУУЛТ

-АОХН-ийн сайд нарын VII бага хурлын онцллог, ач холбогдол юу вэ?

Д.Ганболд /*АОХН-ийн Ажлын албаны ерөнхий зохицуулагч*/:



-Гурван өдөр үргэлжилсэн АОНХ-ийн Сайд нарын VII чуулган сайхан боллоо. Дэлхий нийтийн алдар цуутай, ардчиллыг дэмждэг, олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн хүмүүс Монголд ирж санал бодлоо хуваалцлаа. Энэ бол том нэр хүнд. Тэд зарим талаар сургамжтай үг хэлж, биднийг сонсож Монгол Улсын ардчиллыг хүлээн зөвшөөрч байгаа явдал нь томоохон ач холбогдолтой юм. Үр дүнгийн тухайд АОНХ-ийн сайд нарын VII чуулган амжилттай өндөрлөсөн гэдгээр дүгнэхэд хэцүү. Өндөр дээд хэмжээний үйл ажиллагаа цоо шинээр эхэлж байна. Тиймээс өнөөдөр хурал өндөрлөсөн боловч хурлын үеэр эхлэл нь тавигдсан олон ажил биднийг хүлээж буй. Тухайлбал, “Улаанбаатарын тунхаглал”-д Азийн бүс нутгийн иргэд ардчиллаас хэрхэн тэгш эрхтэйгээр эерэг үр дүн хүртдэг болох вэ гэдэг асуудлыг хөндлөө. Дэлхийн нийт хүн амын гуравны хоёр нь амьдардаг энэ тивийг монголчууд манлайлж, үлгэрлэж чадвал маш чухал үр дүнд хүрэх юм. Тиймээс энэ удаагийн чуулганаар бид асар том үүрэг, хариуцлага, хүлээлт авч үлдлээ гэж хэлж болно.

Л. Эрдэнэчимэг /*УИХ-ын Эмэгтэйчүүдийн бүлгийн ахлагч*/:



-Энэ удаагийн ардчиллын хурлаас иргэд нэг л зүйлийг ойлгож авсан байгаасай гэж бодож байна. Хурлын төлөөлөгч болгон ардчиллыг ярихдаа эмэгтэйчүүдийн оролцоог байнга ярьж байна.

АОХН-ийн хурал үндсэн таван салбар хуралдаанд тулгуурласны нэг нь “Бид хүчирхэг эмэгтэйчүүд, хүчирхэг ардчилал” гэсэн сэдвийн хүрээнд хурлаа хийсэн. Улс төрийн хаалга эмэгтэйчүүдийн өмнө нээлттэй байна. Гэхдээ эдийн засгийн хаалга хаалттай байна. Тиймээс Монгол Улсдаа хүчирхэг эмэгтэй буюу эдийн засгийн эрх мэдэлтэй эмэгтэйчүүдийг бий болгох шаардлагатай байна. Манай эмэгтэйчүүд боловсрол өндөртэй боловч ажиллаж байгаа салбар нь эрүүл мэнд, боловсрол гээд цалин багатай байдаг. Өндөр цалинтай уул уурхай, зам, барилгын салбарт эмэгтэйчүүд орж чадахгүй байна. Үүнийг Хөдөлмөрийн тухай хуулиар хязгаарлачихсан. Ашигт малтмалын салбараа хөгжүүлж байгаа дэлхийн бусад орны жишгийг харахад том оврын автомашин механизм дээр ажиллагсдын 45 хувьд нь эмэгтэйчүүд ажиллаж байх жишээтэй.

С.Дэмбэрэл /*УИХ-ын гишүүн*/:



-Төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагааг хэрхэн сайжруулах, авлигын эсрэг ямар арга хэмжээ авч болох вэ зэрэг асуудлаар олон улсын болон Монгол Улсын туршлагыг танилцуулж, санал бодлоо солилцлоо. Мөн компанийн нийгмийн хариуцлагын талаар олон улсын түвшинд хэрхэн ойлгодог талаар зочид, төлөөлөгчид санал бодлоо хуваалцсан. Нийгмийн хариуцлагыг бид яг юу гэж ойлгох вэ гэдэг чухал асуудал. Төр нь дээрээс компанийн нийгмийн хариуцлага нэхэж “донгодоод” байх уу. Эсвэл энэ ойлголт компанийн хөгжлийн философи гэдгийг хувийн хэвшлийнхэн ойлгож үйл ажиллагаандаа тусгах уу гэдэг чухал. Энэ мэт олон сэдвээр АОНХ-ийн Сайд нарын VII чуулганаар ярилцаж, тунхаглал гаргалаа. Уг тунхаглал хий хоосон зүйл биш. Нийт ардчилсан орон ажил хэрэг болгох чухал баримт бичиг юм. »

Эмануэлис Зингэрис ***/Ардчиллын төлөөх Парламентчдын форумын ерөнхийлөгч/:***



-Монголд сайхан байлаа. Энэ удаагийн хурлаас Монголын ардчилал насанд хүрчээ гэж дүгнэхэд буруудахгүй болов уу. Өнөөдөр дэлхийн олон улс ардчиллаас юу олж авах вэ гэдэгт анхаарлаа хандуулж байна. Ардчиллыг хөгжүүлэх, ардчиллын сайн сайхныг мэдрэх хамгийн чухал алхам бол ил тод байдлыг хөгжүүлэх юм. Дарангуйллын үед хэзээ ч ил тод байдал байдаггүй. Тиймээс бид ардчилал, ил тод байдал хоёрыг салгаж болохгүй. Ил тод байдлын дайсан бол авлига. Тиймээс бидний сонгосон Парламентийн гишүүд авлигаас ангид байхыг өөрийн биеэр бусдад үлгэрлэн үзүүлэх учиртай. Өнөөдөр цахим мэдээллийн хэрэгсэл хөгжиж, аливаа асуудлыг хил хязгааргүй дэлгэн тавьж байна. Тухайлбал, Засгийн газрын гишүүд офшор данс нээж, ёс зүйн алдаа хийж байгааг ил тодоор харж байна. Тиймээс далд, нууц зүйл гэж байхгүй болжээ. Энэ удаагийн хурлын үеэр МАХН-ын гишүүд жагсаж байгааг харсан. Энэ бол монголчууд хүний эрхийг дээдэлдэг, ардчиллын ил тод байдлыг тунхагладаг гэдгийг харуулж байгаа нэг тод жишээ юм. Тус жагсаал хийж байгаа намын гишүүд УИХ-д суудалтай бөгөөд төрийн үйл хэрэгт өөрсдийн үзэл бодлоо илэрхийлж байгаа гэдгийг сонсоод танай улсыг ардчиллын үлгэр дууриалал орон болжээ гэдгийг хүлээн зөвшөөрсөн юм.

Б.Бямбасайхан ***/Монголын бизнесийн зөвлөлийн дарга/:***



-АОНХ-ийн Сайд нарын VII чуулганы зарим салбар хуралдаан болон үндсэн хуралдаанд оролцсон. Ерөнхийлөгчийн үгийг сонслоо. Ан Сан Сү Чигийн хурлын үеэр хэлсэн үг их зүйл бодогдуулахаар байна. Түүний илтгэлд “Ардчилал бол бидний хүрэх ёстой зам. Тэр зүгт урт удаан хугацаанд тэмүүлж, тэмцэж байдаг” талаар дурдсан. Мөн ардчиллын төлөө тэмүүлж байгаа хүн бол “super human” байдаг гэлээ. Энэ их сайхан үг байлаа.

Ардчиллын ач тусаар иргэний нийгэм болоод бизнесийн салбарынханд эдийн засгийн эрх чөлөө бий болж, итгэл найдвар өгсөн гэж хэлж болно. Бизнесийн салбарынхны тухайд ардчилал гэдэг бол бидний амин сүнс юм. Тиймээс бид ардчиллыг хөгжүүлэхэд чадах чинээгээр зүтгэх хэрэгтэй. Өнөөдөр бид ардчиллаас олж авсан туршлага, алдаа оноогоо олон улстай хуваалцлаа. Энэ бол монгол хүний хувьд гайхалтай аз завшаантай хэрэг.

Н.Баярсайхан ***/“Хил хязгааргүй алхам” ТББ-ын зохицуулагч/:***



-Ардчилсан орнуудын хамтын ажиллагааны VII чуулганы үеэр иргэний нийгмийн бодит үр дүнтэй оролцоог чухалчлан ярилаа. Манай улсад иргэний нийгмийн ардчилал гэдэг зүйл бодитой байж чадаагүй юм байна. Тэгэхээр үүнийг цааш нь илүү бодитой болгох хэрэгтэй, бид жинхэнэ ардчиллыг хүсч байна. Иргэний нийгмийг хөгжүүлэхийн тулд төр, засгийн зүгээс эдийн засгийн таатай нөхцөл бололцоогоор хангах үүрэгтэй гэдгийг ойлголоо.

Иргэний нийгмийн байгууллага үүсэн байгуулагдана гэдэг эвлэлдэн нэгдэх тухай асуудал. Эвлэлдэн нэгдэх эрхийн хувьд улс орон бүр ялгаатай байна. Манай орны хувьд бусад оронтой харьцуулахад эвлэлдэн нэгдэх эрх нээлттэй. Гэхдээ иргэний нийгмийн оролцоог хангах бодитой нөхцөл, дэмжлэг байна уу гэдэг дээр анхаарах хэрэгтэй. ■



Фотог Б.Бямба-Очир

ХӨРШ

ӨГЛӨГ АВЛАГА НЬ ТЭНЦҮҮХЭН ТҮНШҮҮД

Б.ЭНХ

“Бидэнд бие биеэ нөхөн ажиллах сайхан боломж бий. Монгол орны баялаг, нөгөө талаас Японы технологи байгааг бид олон удаа ярьсан. Үүнийг одоо ажил хэрэг болгох ёстой” хэмээн Японы Ерөнхий сайд Шинзо Абэ энэ удаагийн Монголд хийсэн айлчлалынхаа үеэр онцолсон билээ. Олон улсад “За гэвэл ёогүй” улстөрч гэдгээрээ алдартай Наран улсын “Торгон жолоо” Шинзо Абэ Монголд зүгээр ч нэг дүрээ үзүүлж, сүрээ бадраахаар ирээгүй нь лавтай. Түүний Монголд тавьсан саналууд ч тунхагийн шинжтэй байхгүй биз. Тэрбээр энэ удаад тодорхой саналууд тавьж, жинхэнэ утгаар нь эдийн засгийн хамтын ажиллагааг шинэ түвшинд аваачихаар иржээ. Үүний баталгаа нь хоёрхон өдрийн айлчлалынхаа хүрээнд “Эрч” санаачилгыг танилцуулж, юу авч, юу өгөхөө шулуухан хэлчихээд явлаа.

“Эрч” санаачилгын хүрээнд Японы талаас Монголд үзүүлэх боломжууд

-IV цахилгаан станцыг шинээр барихад 4.2 тэрбум иенийн зээлийн тусламж,

- Нийт 640 км урт “Ажилчны гүүрэн гарц” болон “Улаанбаатар метро” барих хамтарсан бэлтгэл судалгаа /Иенийн зээлийн тусламж/,

-Монгол Улсын аж, үйлдвэрлэл, инженер, техник эрүүл мэндийн салбарын мэргэжилтнүүдийг хамтран бэлтгэх,

-Японы шилдэг технологи, мэргэжилтнүүдийг ашиглан шинэ онгоцны буудал барих /Явцаас шалтгаалан нэмэлт зээл олгох боломжтой/,

-Дарханы нефтийн үйлдвэрийн барилгын ажилд Японы Олон улсын хамтын ажиллагааны банк /JBIC/ болон хувийн хэвшлийнхний хамтарсан зээлийг олгох,

-Монголын компаниуд Японоос тоног төхөөрөмж болон үйлчилгээ худалдан авахад JBIC банкнаас зээл олгох,

- Монголын хиймэл дагуул хөөргөх сонирхлоос үүдэн Япон улсад үйлдвэрлэсэн хиймэл дагуулыг ашиглах хамтарсан хөтөлбөрийн санамж бичгийг байгуулах,

Монголын талаас

-Тавантолгойн нүүрсний ордын ашиглалтын төсөлд Японы оролцоог хангах,

-Японтой хийх худалдаа, хөрөнгө оруулалтыг Монголын талаас дэмжиж ажиллах, чөлөөт худалдааны гэрээ байгуулах ажлыг түргэвчлэх,

- Зүүн Хятадын тэнгис дэх арлын маргаан болон Хойд Солонгосын асуудалд Монголын талаас дэмжлэг үзүүлэх юм.

Ерөнхий сайд Шинзо Абэгийн айлчлалын үеэр Хятад болон Япон улсын хоорон дахь арлын маргаан түүнчлэн БНАСАУ-ын асуудал мөн сөхөгдсөн билээ. Тэрбээр арлын маргааны асуудал дээр Монголын тал Японы нөхцөл байдлыг ойлгож байгааг онцлоод, дэмжлэг үзүүлэхийг хүсч буйгаа илэрхийлсэн юм. Харин Монгол Улсын Ерөнхий Сайд Н. Алтанхуяг Хойд Солонгосын асуудлын хүрээнд өөрийн байр суурыа илэрхийлсэн билээ. Тэрбээр Монгол Улс Хойд Солонгостой хэвийн харилцаатай байдгийн хувьд зургаан талт хэлэлцээрийг эх орондоо зохион байгуулж, талуудын байр суурийг Пхеньянд дамжуулах байдлаар уг асуудалд оролцож болохоо хэлсэн билээ.

Ерөнхий сайд Шинзо Абэ Япон улсад эдийн засгийн хувьсгал хийж, хурдацтай өсөлтийг эргүүлэн авчирч, улсаа дахин хүчирхэгжүүлэх зорилготой байгаагаа нэгэнтээ илэрхийлсэн. Тиймээс ч иенийн ханшийг сулруулж, Өмнөд Солонгосын экспортын салбарт хүнд цохилт өгч, өөрсдийгөө аврах бодлогыг зоримог эхлүүллээ. Энэ нь Монголын хувьд ч тус улстай хамтран ажиллах боломжийг нээж өгөх сайн талтай байж болох. Иен суларснаар тус улстай хийх худалдаа нэмэгдэж, бизнесийн үйл ажиллагаа тэлэх нь дамжиггүй. Ерөнхий сайд Шинзо Абэгийн Монголд айлчлах болсон шалтгаан нь ч үүнтэй холбоотой байж мэдэх. Учир нь түүнд энэ удаад Монголд санал болгох боломж илүү олон байлаа.

Шинзо Абэ хэн бэ гэдгээ Ерөнхий сайд болсон даруйдаа харуулж, өөрийнхөө цалинг 30 хувиар, танхимын гишүүдийнхийг 10 хувиар бууруулж байна. Азийн луу Хятадыг эдийн засгийн өсөлтийн хувьд өмнөө гишгүүлсэн Их Наран улс тийм ч амар байраа тавьж өгөхгүй нь. Эдийн засгийн харилцан ашигтай, хамтын ажиллагаа байгуулж болох орнуудын тоонд Монгол томоохон байр суурь эзэлж буй. Монголын хувьд Япон стратегийн голлох түнш орон болохын хувьд тус улсын хөгжлийн бодлоготой нийцэж байж ч мэдэх. Хоёр улсын ашиг сонирхол нэгэн цэгт уулзаж, өөрөөр хэлбэл, бие биедээ өгөө аваа ихтэй орнууд болж таарч байна. ■



ХӨРШ

ТҮҮХЭЭР ХОЛБОГДСОН **ТҮНШҮҮД**

...Хуучин хөшөө дурсгал, хот, балгадын сууринууд
Хол газар одсон харгуй дардан замууд...
(Д.Нацагдорж “Миний нутаг”)

Х.ХУЛАН

Тэртээ нэгэн цагт Монгол орны нутаг дэвсгэр дээр Түрэг угсаатнууд төр улсаа товхинуулан оршиж байсан. Тэрхүү үеийг гэрчлэх түүх соёлын дурсгалын олон зуун ул мөр үлдсэн нь үнэхээр гайхалтай. Хээрийн салхи сэвэлзсэн талын Монголоор аялагчдад эртний нийслэл Хархорин, нум сум харвасан дайчин эрс илхэн төсөөлөгдөж, морин төвөргөөн сонстох шиг болдог болов уу. Түргийн Билгэ хаан, гарамгай жанжин Культегин, мэргэн сайд Тоньюкук зэрэг цуутай язгууртнуудын гэрэлт хөшөөнүүд өнгөрсөн үеийн түүхийг гэрчилнэм. Тэгвэл олон зуун жилийн түүхэн хэлхээгээр холбогдсон Монгол, Туркийн ард түмний найрсаг харилцаа өнөөдөр улам хөгжин цэцэглэж эхэллээ.

Турк жимс зооглоорой

Монгол Улсын Ерөнхий сайд Н.Алтанхуягийн урилгаар Бүгд Найрамдах Турк Улсын Ерөнхий сайд Режеп Тайип Эрдоан энэ оны дөрөвдүгээр сард манай улсад албан ёсны айлчлал хийсэн билээ. Хоёр улсын Ерөнхий сайд хамтарсан мэдэгдэл гаргахын сацуу Засгийн газар хоорондын гурван төрлийн санамж бичигт гарын үсэг зурлаа. Үүнд “Хоёр улсын иргэд харилцан визгүй зорчих”, “Аюулгүй байдлын салбарт хамтран ажиллах тухай хэлэлцээр”, “Соёл, боловсрол, шинжлэх ухааны солилцооны 2013-2016 оны хөтөлбөр” оржээ. Энэхүү айлчлалын үеэр Туркийн Ерөнхий сайд мөн Монгол Улсын төр, засгийн удирдлагуудтай уулзаж, санал бодлоо солилцсон байна.



Фотог Б.Бямба-Очир

Туркийн Ерөнхий сайд ноён Р.Т.Эрдоан манай улсад өмнө нь анх удаа 2005 онд айлчлах үеэр Хархорин сумаас Билгэ хааны музей хүртэлх 46 км замын шавыг тавилцсан билээ. Эл хатуу хучилттай замыг Туркийн олон улсын хамтын ажиллагааны байгууллага (ТИКА) барьж, 2008 онд ашиглалтад оруулсан юм. Архангай аймгийн Хашаат сумын нутагт Түрэгийн хаант улсын түүх, соёлын үнэт олдворууд цөөнгүй байдаг. Тухайлбал, Орхоны хөндийгөөс олдсон гэрэлт хөшөөнүүд дээр сийлсэн бичээс Туркийн түүх, хэл соёлын хосгүй өвд тооцогддог. МЭ VII-VIII зууны эдгээр олдвор Монгол-Турк орнуудыг түүхээр холбож буй гэрч болж байна. Иймд хоёр орны нөхөрсөг харилцааг улам ойртуулж, аялал жуулчлалын салбарыг тууштай хөгжүүлэх зорилгоор Монгол-Турк улсын Ерөнхий сайд нар визний асуудлыг шинэчилсэн аж. Монгол Улсын иргэн Турк руу нэг сарын хугацаанд визгүй зорчих журам 2007 оноос хэрэгжсэн. Тэгвэл Ерөнхий сайд Р.Т.Эрдоаны энэ удаагийн айлчлалаар Туркийн иргэд манайд 30 хоногийн дотор аялахдаа визгүй зорчдог болох асуудлыг дэвшүүлжээ. Турк улсын иргэд Монголын хилээр визгүй нэвтэрдэг болсноор манай аялал жуулчлалын салбарт хөгжлийн томоохон гарц нээгдэх ач холбогдолтой.

Сонирхуулахад, 2012 оны долдугаар сараас эхэлж Истанбул- Улаанбаатарын чиглэлд шууд нислэг нээгдсэн. “Turkish Airlines”-ийн нэг удаагийн нислэг 150 хүн тээвэрлэх хүчин чадалтай аж. Өнөөгийн байдлаар долоо хоногт гурван удаа нислэг үйлдэж байна. Турк улсад жилд 35 сая жуулчин очдог. Эл улс аялал жуулчлалын салбараас жилд 25 тэрбум ам.долларын ашиг олдог. Дашрамд дурдахад, Туркийн иргэний агаарын тээврийн “Turkish Airlines” компаниас Монголын аялал жуулчлалын компаниудад зориулж “Монгол Улсад аялал жуулчлал хөгжүүлэх нь” сэдвээр сургалт хийхээр төлөвлөсөн байна. Туркийн Засгийн газраас тус чиглэлийн нислэгийн тоог нэмэгдүүлэх, түүнчлэн ачааны онгоцны нислэгтэй болох саналыг Монголын талд дэвшүүлжээ. Эдгээр санал нааштай шийдэгдвээс тун удахгүй Турк улсаас төрөл бүрийн органик жимс манайд орж ирэх нь. Дэлхий дээр жимс, жимсгэний бүтээгдэхүүн үйлдвэрлэлээр тус улс зургаадугаарт жагсдаг. Номин цэнхэр далайтай нарлаг Туркт чангаанз, олив, инжир, алим, хушга, нимбэг, усан үзэм гээд ургахгүй жимс ховор. Эдгээр органик бүтээгдэхүүнийг манай зах зээлд нийлүүлвээс монголчууд боломжийн үнээр эрүүл хүнс хэрэглэх боломжтой болох нь.

Иж бүрэн түншлэлийн харилцаа

Монгол Улсын Гадаад бодлогын үзэл баримтлалд Бүгд Найрамдах Турк улсыг “гуравдагч хөрш”-өөр 2011 онд тунхагласан байдаг. Энэхүү шийдвэрийг хоёр улсын түүхэн холбоо хөгжиж, хамтын ажиллагаа сайжирч байгаад үндэслэн гаргажээ. Түүхээр холбогдсон хоёр улс 2004 оноос иж бүрэн түншлэлийн харилцааг хөгжүүлэн ажиллаж байна. Цаашид харин тус харилцаагаа улам ахиулж стратегийн түншлэлд хүргэх хэтийн зорилт



тавьж байгааг Туркийн Ерөнхий сайдын айлчлалын үеэр хоёр тал санал нэгтэйгээр мэдэгдлээ. Хэлэлцээний үеэр манай улс Турк улстай орон сууцны барилга, зам, гүүр барих, арьс шир боловсруулах үйлдвэрлэлийн шинэ цогцолбор байгуулах, аялал жуулчлал зэрэг чиглэлүүдийг түлхүү хөгжүүлэх сонирхолтойгоо илэрхийлсэн.

Р.Т.Эрдоан Турк Улсын 25 дахь Ерөнхий сайд. Тэрбээр 2003 оноос Ерөнхий сайдын үүргийг гүйцэтгэж байна. Истанбул хотын даргаар сонгогдон ажиллаж байсан тэрбээр хот төлөвлөлт, барилгын асуудлаар туршлагатай улстөрч юм. Р.Т.Эрдоан Ерөнхий сайдаар томилогдсоноос хойш орлого багатай иргэдийг орон сууцжуулах хөтөлбөр дээр амжилттай ажилласан. Сүүлийн 10 жилийн турш Туркийн Засгийн газраас 400 мянган орон сууц барьж эдгээр иргэддээ хүлээлгэн өгсөн байна. Дэлхийн хэмжээнд томоохон барилгын 250 компани байдаг. Үүнээс 37 нь хятад, 33 нь турк компани байх аж. Түүнчлэн Казахстаны нийслэл Астанагийн 75 хувийг туркчууд бүтээн байгуулжээ.

Манай хоёр орны түншлэлийн хүрээнд гэр хорооллыг дахин төлөвлөх, эрчим хүч, батлан хамгаалахын салбарт хамтран ажиллах талаар ч санал солилцож, хэлэлцэх шатанд явж байгааг дуулгая. Монгол-Турк орнуудын худалдааны эргэлт 2012 оны байдлаар 36 сая ам.доллар байгааг хоёр тал чамлахуйц хэмжээтэй байна гэж дүгнэсэн. Энэхүү хэмжээг 2015 он гэхэд 250 сая ам.долларт хүргэх зорилтыг Туркийн Ерөнхий сайдын айлчлалын үеэр дэвшүүлэв.

Түүхээр хүйн холбоотой хоёр улс эдийн засгийн салбараас гадна соёл, шинжлэх ухаан, нийгмийн чиглэлээр гар нийлж ажиллаж байна. Туркийн 12 хотын их, дээд сургуульд монгол оюутнууд эдийн засаг, анагаах ухаан, хөнгөн үйлдвэр, байгаль орчин, аялал жуулчлалын чиглэлээр суралцаж байна. Эдгээрийн ихэнх нь Туркийн Засгийн газраас тэтгэлэг авч, бакалавр, магистрантур, докторантурт элссэн байх жишээтэй. Бас нэг шинэ мэдээ дуулгахад, Налайхын ойролцоо орших Билгэ хааны хадам байсан мэргэн сайд Тоньюкукын гэрэлт хөшөө рүү хүрэх 20 км засмал замыг шинээр барихаар төлөвлөжээ. Анх 1969 онд дипломат харилцаа тогтоосон Монгол-Турк орнуудын хамтын ажиллагаа цаашдаа улам бүр өргөжин хөгжихийн эхлэлийг ийн тавилаа. ■

ЭЛЧИН САЙД

БИД АЛДААНААСАА СУРАЛЦАЖ ЧАДСАН

Манай улсын компаниудын хувьд хахууль өгч, авлигын хэрэгтэй ямар нэг байдлаар хутгалдах нь хууль бус. Америкийн компаниудын энэхүү ёс зүйн хэм хэмжээ нь хэлэлцээрийн ширээн дээр гаргаж тавих хамгийн чухал хүчин зүйлийн нэг.

Б.ЭНХЦЭЦЭГ

Гадаад харилцааны албаны ахлах ажилтан байсан Пайпэр Энн Уинд Кэмбэллийг АНУ-ын Ерөнхийлөгч Обама Монгол Улсад суух Элчин сайдаар нэрийг нь дэвшүүлж, Сенат баталсны дараа тэрбээр 2012 оны наймдугаар сарын 6-нд тангараг өргөж, Монголыг зорьжээ. Хатагтай Кэмбэлл 2011 оны зургадугаар сараас өнгөрсөн оны мөн хугацааг хүртэл Өмнөд Ирактад АНУ-ын Засгийн газрын Иргэний ахлах төлөөлөгчөөр ажиллаж, мөн оны долдугаар сард Басра хотод АНУ-ын Ерөнхий консулын газрыг анх нээж байжээ. Монгол Улсын гуравдагч хөрш, дэлхийн хамгийн хүчирхэг эдийн засагтай орон болох АНУ-ыг төлөөлөн манай улсад суугаа Элчин сайд Пайпэр Энн Уинд Кэмбэллийг "Mongolian Economy" сэтгүүл энэ удаад "Элчин сайд" буландаа урин ярилцлаа.

-Монголд ажиллах хүсэлтийг хэрхэн хүлээж авсан бэ?

-Гадаад хэрэг хариуцсан албанд ажиллаад 24 жил болжээ. Таны хэлсэнчлэн би амьдралынхаа сүүлийн 10 жилийг Ирак, Афганистан тэргүүтэй эрсдэл өндөртэй орнуудад өнгөрүүлсэн. Монголд ирэх болсон нь ч үүнтэй холбоотой. Орчноо ялимгүй өөрчлөхийг хүссэн ч түүний зэрэгцээ зөрчил мөргөлдөөнт орнуудаас хуримтлуулсан туршлагаа өөр орчин нөхцөлд ашиглахыг хүссэн юм.

Ажлын гараагаа эхлэх үедээ амьдралынхаа дийлэнх хугацаанд Азид дипломатчаар ажиллана гэж боддог байлаа. Үүний зэрэгцээ зөрчилдөөнт талбарт ажиллах сонирхолдоо хөтлөгдөх болсон л доо. Гэвч Азид эргэн ирж, өөриймсөг санагддаг бүс нутгийн асуудлуудад анхаарал тавих нь миний хувьд чухал байсан. Харилцаа гэдэг зүйлийг зохицуулах тал дээр сөргөлдөөнт бүс нутгууд надад ихийг заасан.

-Монгол болон АНУ-ын харилцаа аль зүгт явж байна вэ?

-Хоёр орны харилцаа өргөн хүрээнд, гүнзгийрч буй. Саяхан УИХ-ын дарга З.Энхболд анхны айлчлалаа АНУ болон Канадад хийсэн явдлыг талархан хүлээж авсан. Мөн АНУ-ын Төрийн нарийн бичгийн даргын орлогч Билл Бюрнс Монголд болсон Ардчилсан орнуудын хамтын нийгэмлэгийн Сайд нарын бага хуралд оролцлоо.

Мөн бидний соёлын хүрээн дэх хамтын ажиллагаа балар эртний түүхэн олдвор болох Триннозавр Батаарыг эргүүлэн авах тал дээр амжилттай хамтран ажиллаж байгааг жишээ болгож хэлмээр байна. Орчин үеийн түүх, соёл хүртэлх олон талаар хамтран ажиллаж буй. Мөн 2008 оны долоодугаар сарын 1-ний үеэрх галд өртсөн зарим уран зургийг сэргээн засварлах ажилд Монгол болон АНУ-ын мэргэжилтнүүд хамтарч ур чадвар, тоног төхөөрөмжийн хувьд туршлага солилцож байна. Түүх соёлын хүрээнд хоёр орны харилцаа балар эртний үеэс өнөөг хүртэлх өргөн хүрээнд тэлж байгааг харахад таатай байна.

Хоёр орны харилцаа эхний 25 жилийн хугацаанд хөгжлийн туслалцаанд суурилж байсан бол өнөөдөр бид эдийн засаг, худалдааны



Фотог Э.ЗОРИГТ

салбар дахь түншлэлийн хүрээнд харилцаагаа өргөжүүлэхийг илүүтэй сонирхох болсон. Харилцаа хамтын ажиллагааны хүрээнд аль ч талаас нь харсан Монголын эдийн засгийн хөгжил, өөрчлөлтийн нөлөөлөл их байгаа бол нөгөө талаас АНУ-ын бүсээ чангалж буй үйл явц ч тодорхой хэмжээнд нөлөөлж байгаа юм.

-Тэгвэл хоёр орны худалдаа ямар түвшинд явж байна вэ. Тодорхой өсөлтөө хадгалаад явж байна уу эсвэл гадаадын хөрөнгө оруулалт Монголоос дайжихад хүргэсэн улс төрийн тодорхойгүй байдлаас үүдэн буурах хандлагатай байна уу?

-Худалдааны хувьд өнгөрсөн хоёр жилийн турш тасралтгүй өсч байна. Өнгөрсөн хоёр жилийн хугацаанд 17 болон 12 хувийн өсөлтийг Монголын эдийн засагт авчирсан гол хүчин зүйл нь Монголыг чиглэсэн гадаадын хөрөнгө оруулалт гэдгийг бид мэдэж байгаа. Үүнийг дагаад хоёр орны худалдаа ч чамгүй өссөн. Бидний зүгээс дээрх өсөлтийн хандлага үргэлжилнэ гэж найдаж байна. Гадаадын хөрөнгө оруулагчид өдийг хүртэл Монголын талаар сайн муу мэдээллийг авдаг. Үүнтэй зэрэгцэн Монголын Засгийн газар хөрөнгө оруулалтын таатай орчинг бүрдүүлэх тал дээр идэвхийлэн ажиллаж буй талаарх эерэг мэдээллийг тэд сонсож байна. Гэсэн ч хөрөнгө оруулагчид Гадаадын хөрөнгө оруулалтын тухай хуульд өөрчлөлт орох эсэхийг анхааралтай ажиж бас хүлээж байгаа нь илт байгаа юм. Мөн Ашигт малтмалын хуулийг ч дахин хэлэлцэж, олон улсын хөрөнгө оруулалтын орчинд нийцсэн зөв суурийг тавьж өгнө гэж итгэж байна.

Америкийн болон олон улсын компаниудын хувьд тааварлахуйц хэмжээнд тодорхой, ил тод нээлттэй байдал чухал. Ийм л нөхцөлд тэд урт хугацаанд хөрөнгө оруулах эсэхээ шийддэг. Ялангуяа Монголын хувьд хэзээд хаяад явахад бэлэн итгэлгүй / fly by night /компаниудтай түншлэхийг хүсэхгүй байх. Удаан хугацаанд тогтвортойгоор хөрөнгө оруулах дэлхийд данстай нэр хүнд бүхий компаниудыг Монголд ирээсэй гэж хүсч буй. Тэгвэл тийм компаниудын хувьд ойлгомжтой, амархан өөрчлөгдөөд байдаггүй тоглоомын дүрэмтэй орнуудад л хөрөнгө оруулах тухай бодож үздэг.

-Хэрвээ нууц биш бол АНУ-ын Элчин сайдын яам болон танай хөрөнгө оруулагчид Монголын төр, засгийн ямар шийдлийг сонирхон харж суугаа вэ?

-Мэдээж хөрөнгө оруулалтын орчныг илүү тогтвортой, ил тод болгох тал дээр Засгийн газар авч чадах алхмуудаа хийх нь чухал. Мөн голлох төслүүд дээрх Засгийн газрын шийдвэр. Бидний хувьд Засгийн газар ямар төслүүдийг Чингис бондоос санхүүжүүлэх шийдвэр гаргах бол гэдэг сонин байна. Стратегийн ач холбогдолтой төслүүдийн хүрээнд Засгийн газар ямар шийдвэрүүд гаргаж, цааш нь авч явах бол гэдгээ тодорхой болгох хэрэгтэй байгаа юм.

Нууцлаад байх зүйлгүй л дээ. Тухайлбал, Америкийн "Пийбоди" компани Тавантолгойн нүүрсний нөөцийг ашиглах төсөлд оролцохоор нэлээд хүчин чармайлт гаргаж байна. Бид бусдын л адил Монголын Засгийн газар ашигт малтмалын нөөцүүдээ цааш нь хэрхэн удирдан авч явах бол хэмээн харж, хүлээж сууна.



-АНУ-ын компаниуд Монголын эдийн засгийн ямар салбарт түлхүү оролцоотой байна вэ?

-Юун түрүүнд АНУ эртнээс Монголын уул уурхайн салбарт шууд болон шууд бус замаар тодорхой хэмжээнд оролцоод явж байгаа гэдгийг хэлье. Манай улсын компаниудын нэлээд хувь нь энэ салбартай холбогдож байна. "Вагнер Ази" компанийн хувьд сайн туршлагуудыг үлгэрлэн Монголд үйл ажиллагаа явуулж буй Америк компаниудын нэг. Хэдий тус компани уул уурхайн суурийг бүрдүүлэгч тоног төхөөрөмжийн ханган нийлүүлэгч ч монгол ажилтнуудаа чадавхжуулж, мэргэшүүлэх тал дээр багагүй ажил хийж яваа. Энэ бол АНУ-ын олон улсын хэм хэмжээ, ил тод байдал, байгаль орчны хамгаалалт тал дээр дэлхийд нэртэй компани. Энэ мэт ажлын байр бий болгож, уул уурхайн салбартай холбогдсон олон Америкийн компани бий. Нөгөө талаас Монгол Улс голлох төсөл дээрээ "Пийбоди" компанийг үндсэн түншээр сонгоно гэдэг бол Монголын эдийн засаг дахь Америкийн оролцоо тэр хэмжээнд өсөн нэмэгдэж, шинэ шатанд гарна гэсэн үг. Мөн нүүрс олборлолтод хэрхэн байгаль орчны өндөр стандартыг мөрдөж, мэргэжлийн түвшинд хийж гүйцэтгэх сайн туршлагыг Монголд өгнө гэж бодож байна.

- Америк компаниудтай томоохон төслүүд дээр хамтарлаа гэхэд бусдаас ялгарах давуу тал нь юу вэ?

-Би энд гурван зүйлийг цохон хэлмээр байна. Нэгдүгээрт, АНУ бол гаднын оронд компаниуд ямар ёс зүйг баримталж үйл ажиллагаа явуулах вэ гэдгийг хуульчилж, компаниудаа хазаарласан хамгийн анхны орнуудын нэг. Манай улсын компаниудын хувьд хахууль өгч, авлигын хэрэгтэй ямар нэг байдлаар хутгалдах нь хууль бус. Америкийн компаниудын энэхүү ёс зүйн хэм хэмжээ нь хэлэлцээрийн ширээн дээр гаргаж тавих хамгийн чухал хүчин зүйлийн нэг.

Хоёрдугаарт, технологийн шилжүүлэг. Өндөр туршлага, шалгарсан тоног төхөөрөмж, арга барилыг өвлүүлэх боломж юм. "Женерал Электрик" компанийн Салхитын салхин станц дахь оролцоо болон бусад Америкийн компанийн Монгол дахь үйл ажиллагааг харвал тодорхой ялгаатай түвшинд технологийн дэвшил авчирч буйг анзаарна.

Гуравдугаарт, байгаль орчны тал дээр баримтлах өндөр стандарт шаардлагатай. Манай улсад өнгөрсөн хугацаанд компаниудаа тодорхой зохицуулалтгүйгээр үйл ажиллагаа явуулахыг зөвшөөрсөн гашуун туршлага бий. Тухайлбал, миний өссөн газарт уул уурхайн үйл ажиллагаа явуулсан компани зүй бусаар аашилж, нутагт маань химийн хорт бодис үлдээгээд явсан. Улмаар хүмүүст болон тэдний амьдралд нөлөөлсөн байдаг.

Бид алдсан туршлагаасаа суралцсан. Тиймээс л компаниуддаа маш өндөр байгаль орчны стандартуудыг тогтоож өгсөн байдаг. Тэд үүний хариуд сайн технологи, байгаль орчноо гэсэн анхаарлыг бий болгодог.

-Америкийн компаниуд Монголд хөрөнгө оруулахад ямар саад учирч байна вэ?

-АНУ-ын Элчин сайдын яамнаас жил бүр хөрөнгө оруулалтын тайлан гаргадаг. Энэ нь Америкийн төдийгүй монголчуудын хувьд мэдээллийн сайн эх сурвалж болдог. Тус тайланд бид АНУ-ын компаниудад Монголд хөрөнгө оруулахад ямар саад бэрхшээл тулгарч байгааг харуулахыг зорьдог. Орчноо мэдэхийн чухал нь хууль эрх зүй, нөхцөл байдлаар дамжуулан урагшлах үгүйгээ тунгаахад оршдог. Тиймээс Засгийн газрын гаргасан өөрчлөлт бизнесийн орчныг орвонгоор нь өөрчлөхгүй байх нь бизнест хэрэгтэй.

-Зөрчил мөргөлдөөнт газруудад амьдарч байсан хүний хувьд одоогийн Хойд Солонгосын өдүүлсэн нөхцөл байдлыг хэрхэн харж байна вэ?

-Балкан, Ирак болон Афганистаны зөрчилдөөнт нөхцөлд амьдралынхаа нэлээд хугацааг өнгөрүүлсэн. Түүнчлэн Индонез, Зүүн Тиморт ч ажиллаж үзсэн. Зөрчил мөргөлдөөнийг сонгосон орон болгоноос гарз хохирол, өвчин зовлон, заналхийлэл л харагддаг. Балканд ажиллаж байх хугацаандаа уулзсан Серб болон хорватчууд бүгд л "Бид өмнө нь ямар сайхан амьдралтай явснаа ухаараагүй явжээ" гэдэг. Хойд Солонгос төдийгүй бусад тайван бус бүс нутгийн удирдагч нарын хувьд бодох ёстой хамгийн чухал зүйл бол "Төрийн нарийн бичгийн дарга асан Хилари Клинтоны хэлснээр "Юу хийж байгаагаа нүдээ нээгээд хараач" гэмээр байна. Тэдгээр бүс нутгийн хувьд хөгжлийн суурь болох тогтвортой байдал чухал. ■

ГАДНЫН СЭТГҮҮЛЧИЙН НҮДЭЭР

АШИГТ МАЛТМАЛЫН ТӨЛӨӨХ БНХАУ-ЫН ӨРСӨЛДӨӨН



Монгол Улсын экспортын хамгийн том хэрэглэгч БНХАУ бөгөөд цаашид ч ийм байх боломжтой боловч энэ нь үргэлж онцгой харилцаатай байх ёстой гэсэн үг биш.

ТЕРЕНС ЭДВАРДС

Монгол Улсад мандаж буй уул уурхайн салбарт БНХАУ-ын эзлэх байр суурь санаархаж буй ашигт малтмалдаа бүдрэх эрсдэлтэй хэмжээнд хүртэл нэмэгдэх болсон бөгөөд энэхүү сайхан боломж бусад орны анхаарлыг ихээр татах болсон.

БНХАУ болон Япон улсын төрийн шинэхэн лидерүүд Монгол Улсад албан ёсны айлчлал хийж, Монгол Улсын хөгжилд туслалцаа, дэмжлэг үзүүлэхээ амлаж, хүчтэй дохио өгөх болжээ.

Японы улсын Ерөнхий сайд Шинзо Абэ өнгөрсөн гуравдугаар сарын 30-нд Монголд айлчлахдаа хоёр улсын хамтын ажиллагааг бэхжүүлэх “Эрч” санаачилгыг албан ёсоор байгуулав. Тус санаачилга нь дэд бүтцийн хөгжил, эрчим хүч болон уул уурхайн салбарт хамтын ажиллагаагаа өргөжүүлэхэд чиглэжээ. “Энэхүү санаачилга нь уул уурхайн салбарт хамтран ажиллахад зориулсан тогтвортой орчныг эхлүүлж байна” гэж Ерөнхий сайд Абэгийн айчлалын үеэр хэлсэн.

Өнгөрсөн гуравдугаар сард БНХАУ-ын ерөнхийлөгчөөр томилогдсон Си Жинпин өнгөрсөн сарын 8-нд болсон “Азийн төлөөх Боаогийн форум 2013”-ын үеэр УИХ-ын дарга З.Энхболдод дээрхтэй төстэй “дохио” өгсөн талаар “China Daily” мэдээллийн агентлаг мэдээлжээ. УИХ-ын дарга З.Энхболд “Монгол Улс БНХАУ-тай гадаад

харилцааны салбарт хамгийн дээд түвшинд хамтран ажилладаг” гэж тодорхойлжээ.

Монгол Улс ардчиллаа улам бэхжүүлэх үүднээс мөн Япон улстай ойр дотно харилцаатай байхыг эрмэлзэж буй. Өмнө нь Монгол Улс ОХУ, БНХАУ гэсэн хоёр хөршийнхөө хараат байсан. Гэтэл сүүлийн 22 жилд хуучин замналаа халж, ардчиллаар замнах болжээ. Монгол Улс хоёр хөршөөсөө хэтэрхий хамааралтай байдлаасаа ангижрахын тулд Япон, Австрали, АНУ зэрэг хилийн чанадын орнуудтай хамтран ажиллах гуравдагч хөршийн бодлогоо яаралтай тодорхойлох болжээ.

Ашигт малтмалыг хүсэмжилсэн хоёр гүрэн

2011 оны гуравдугаар сард Фүкушимагийн атомын цахилгаан станц дэлбэрснээс хойш Япон улс нүүрснээс эрчим хүч гаргах гэх мэт эрчим хүчний өөр эх үүсвэрийн эрэлд гарсан. Тэдний энэхүү хичээл зүтгэлийн гол зангилаа нь дэлхийд томоохонд тооцогдох Тавантолгойн нүүрсний орд болоод байгаа бололтой. Тавантолгойн Баруун Цанхийн орд газрын уурхайг хөгжүүлэх зорилгоор Монгол Улс консорциум сонгох шийдвэрийг 2011 онд гаргах үед Япон улс эсрэг байр суурьтай байв. Засгийн газраас уг төлөвлөгөөг даруй зогсоосон боловч өдийг хүртэл тухайн уурхайд тохирох төлөвлөгөө гараагүй байна. Өнгөрсөн оны гуравдугаар сард Монгол Улсын Ерөнхий сайд асан С.Батболд төрийн өмчит Тавантолгойн ордоос нүүрсийг шууд худалдан авах төлөвлөгөөнд зориулсан харилцан ойлголцлын санамж бичгийг “Mitsui & Co” компанитай хийж, гарын үсэг зурах үед Япон дээрх зорилгодоо хүрэхийг ихэд чармайж, тус компани Тавантолгойгоос нүүрс худалдан авах болсон. Гэхдээ нүүрсийг БНХАУ руу гаргаж, “Чалко” компани боловсруулалт хийсний дараа.

“Эрч” санаачилгын гол санаа нь мөн л тухайн сэдвийг онцгойлон хөндсөн байна. Үүнд “Өнгөрсөн оны гуравдугаар сард манай хоёр улсын Ерөнхий сайд нар Тавантолгойд Япон улсын оролцоог хангана гэж хэлэлцсэн. Тиймээс Япон улс Монголыг энэхүү амлалтаа биелүүлнэ гэдэгт гүнээ найдаж байна” гэжээ.

Японы JICA-гаас гаргасан баримтаас харахад, Монгол Улсад гаднын тусламжийг Япон улс хамгийн их үзүүлдэг ажээ. 2011 онд л гэхэд 75.6 сая ам.долларын буцалтгүй тусламж, зээл олгож, техникийн хамтын ажиллагаа өрнүүлжээ. “Эрч” санаачилгын хүрээнд Улаанбаатар хотод метро барих, нефть боловсруулах үйдвэр байгуулахад хамтран ажиллах төлөвлөгөөнүүдийг тусгаад байгаа. БОНХЯ-наас хүлэмжийн хийг бууруулах, Япон руу нүүрс экспортлох зэрэг төслүүдийг хэрэгжүүлэх боломжийг Монголд олгох уян хатан тогтолцоог хангах зорилгоор Японтой “Зээлийн хамтарсан механизм”-ийг хэрэгжүүлэхээр ажиллаж байна. Монгол Улс өнгөрсөн сард Ардчилсан орнуудын хамтын нийгэмлэгийн Сайд нарын VII бага хурлыг зохион байгуулсан.

Илүү тохирсон нь хамгийн сайн ятгагч мөн үү

Монгол Улсын хамгийн том гадаадын хөрөнгө оруулагч бол БНХАУ бөгөөд 2011 онд гаднын нийт хөрөнгө оруулалтын 31.7 хувийг эзэлж, 3.65 тэрбум ам.долларын хөрөнгө оруулалт хийжээ. Харин Япон улс тэртээ хойно хоцорч, гаднын хөрөнгө оруулалтын ердөө 1.6 хувийг эзэлж, аравдугаар байрт жагсжээ. Япон улсаас хийсэн хөрөнгө оруулалт 184.7 сая ам.доллар байв.

Монгол Улс нь Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллага /OECD/-ын гишүүн орон бөгөөд түвшингээ улам ахиулахыг зорьж буйгаас үзэхэд хоёр хөршөөсөө зайгаа барих талтай.

Тэрбээр “Олон улс өөрсдийн нийгэм болоод нөхцөл байдалд хамгийн тохиромжтой засаглалын загвар олох гэж чармайж байгаа өнөө үед Ази тив дэх ардчиллын ач холбогдлын талаар бид эргэн харах тохиромжтой цаг үе одоо тохиож байна. Учир нь, эдгээр улсын сонгох зам бүс нутаг болон түүнээс ч цаадах олон тэрбум хүний амьдралыг тодорхойлох болно“ гэж хэлжээ. ■

ЕРӨНХИЙ ИВЭЭН ТЭТГЭГЧ:

ЦАХИМ ӨРТӨӨ КОЛЛЕЖ
монгол улсын хөгжлийн хөтөч

ЗОХИОН БАЙГУУЛАГЧИД:

ХӨДӨЛМӨРИЙН ЯАМ

НИЙСЛЭЛИЙН БОЛОВСРОЛЫН ГАЗАР
НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ

МОНГОЛЫН ИХ ДЭЭД СУРГУУЛИУДЫН КОНСОРЦИУМ

МОНГОЛЫН ХУВИЙН ИХ, ДЭЭД СУРГУУЛИУДЫН ХОЛБОО

MISHEEL GROUP
EXPO - FURNITURE - BUSINESS PARK



БОЛОВСРОЛЫН ШИНЭЧЛЭЛ 2013
ҮЗЭСГЭЛЭН

Та мэргэжлээ сонгосон уу?



Дээд боловсролын тогтолцоог олон улсын жишигт нийцүүлэх хөгжүүлэх, боловсролын бодлогын асуудлыг сурталчилах, боловсролын салбарын хөгжлийн түвшин, өнөөгийн үйл ажиллагааг олон нийтэд таниулах, нийгэмд эрэлт хэрэгцээтэй байгаа боловсролын чиг хандлагыг тодорхойлж, оюутан, сурагчдыг мэргэжлээ зөв сонгох, чанартай боловсрол эзэмшихэд нь туслалцаа үзүүлэх, их-дээд сургууль, коллежид элсэгчдэд шалгалтаа өгөх, бүртгүүлэхэд нь шаардлагатай зааврууудын талаар танилцуулах, сурталчилах, олон нийтэд дэлгэрэнгүй мэдээ, мэдээлэл хүргэх зорилгоор "Боловсролын Шинэчлэл 2013" үзэсгэлэнг 2013 оны 4 дүгээр сарын 27-29 нд "МИШЭЭЛ ЭКСПО" төвд амжилттай зохион байгуулж өндөрлөлөө.

*Нийт оролцсон их, дээд сургууль, коллеж, мэргэжил сургалт үйлдвэрлэлийн төвийн ажилтнуудад "**МИШЭЭЛ ГРУПП ХХК**"-ын хамт олноос гүнээ талархал илэрхийлж байна.*

2014 оны 4 сард болох "Боловсролын Шинэчлэл 2014" үзэсгэлэнгээр дахин уулзацгаая !!!

МОНГОЛЫН БАХАРХАЛ

ТҮҮЧЭЭ


Д.БЭХЭЭ

Монголын хөрөнгө оруулалт буурах боллоо, Оюутолгойн хувь нийлүүлэгчдийн хуралдаан наашгай биш байна зэрэг таагүй мэдээ хөврөх үед монголчуудын чихнээ нэгэн сайхан мэдээ дуулдсан юм. Энэ бол Б.Болд “Рио Тинто” компанийн Зэсийн группын Олон улсын үйл ажиллагаа хариуцсан ерөнхийлөгчөөр томилогдсон явдал байв.

Орчин үеийн монгол залуусын мэдлэг оюун ухаан, авьяас чадвар, эрч хүч дэлхийн түвшинд гарлаа. Б.Болд энэ л гэгээлэг мөрөөдлийн замыг нээж өглөө. Манай олон залуу гаднын томоохон байгууллагуудад ажилладаг тухай мэдээлэл бий ч дэлхийд тэргүүлэгч компанийн удирдлагын багт багтана гэдэг ховор боломж ажээ.

Дэлхийд данстай компаниуд боловсон хүчнээ, ялангуяа удирдлагын түвшинд ажиллах хүнийг мэдлэг боловсрол, ур чадвар, удирдах болон бизнесийн ухаан, хэлний мэдлэг, алсын хараа зэрэг маш өндөр шалгуур үзүүлэлтүүдээр олон жил судалж, шалгаж байж сонгодог гэдэг.

“Рио Тинто”-гийн Зэсийн группын Олон улсын үйл ажиллагаа хариуцсан ерөнхийлөгчийн албан тушаал нь хэн бүхний хүсэж, тэмүүлээд хүрчихдэг өндөрлөг биш. Мэдлэг, авьяас чадвар юугаан хослуулсан хүн л энэ өндөрлөгт очих боломжтой. Өвөг дээдсийн үлдээсэн газар доорх баялгийг маань дэлхий сонирхож байгаа нь үнэн. Тэгвэл монгол иргэн, монгол хүний оюун ухаан дэлхийн тэргүүлэх компаниудын удирдлагын багт тэнцэх хэмжээнд хүрснийг энэ томилгоо харууллаа. Тэрбээр энэ албанд очсоноор зөвхөн Монголтой харьцахгүй. Дэлхийн олон өнцөгт үйл ажиллагаа явуулж буй “Рио Тинто”-гийн Зэсийн группын төслүүдийг хариуцаж ажиллах юм байна. Монгол хүн дэлхийн том төслүүдийг, гадаадын хашир, туршлагатай “толгойтнуудыг” удирдан



чиглүүлж хянаж ажиллана гэсэн үг. Б.Болдод өндөр хариуцлага ногдож байгаа юм. “Рио Тинто”-гийн Зэсийн төслийн олон мянган ажилтан, ялангуяа удирдах түвшний олон нүд, чих түүнийг харж, сонсож байгаа. Хөгжиж буй

жижиг орны иргэн биднийг удирдах болж байна гэх мэт янз бүрийн сэтгэгдэлтэйгээр хүлээж суугаа. Тэгэхээр хэрхэн яаж ажиллах, удирдаж, хянах вэ. Монгол хүн ийм өндөрлөгт хүрч чадлаа. Одоо монгол хүн ингэж ажиллаж чаддаг юм аа гэдгийг л харуулах хэрэгтэй.

Өөр өнцгөөс харвал Оюутолгойн гэрээнд өөрчлөлт оруулахтай холбоотой Хувь нийлүүлэгчдийн хурлын талаар дотоод, гадаадын хэвлэлээр эерэг, сөрөг мэдээлэл байнга гарч буй энэ үед "Рио Тинто" удирдах багтаа Б.Болдыг, монгол хүн сонгосон нь хоёр талтай байж болохыг хүмүүс хэлж байна. Нэгдүгээрт, монгол хүний үнэлэмжийг өргөсөн сайн талтай. Нөгөө талаас Оюутолгой төслийг урагшлуулан, эрчимжүүлэхэд, хэлэлцээр хийхэд, монгол хүнийг, монгол сэтгэлгээг ойлгоход дөхөм алхам болсон гэж уул уурхайн салбарынхан ярьж байна. Бас л хариуцлага, нэр хүнд. Эх орон нь, элэг нэгт ахан дүүс нь Оюутолгой төсөлд Б.Болдыг хэрхэн оролцох, ямар байр сууринаас хандахыг харж, хүлээх нь ойлгомжтой. Тэгэхээр түүнийг хувь хүн талаас нь авч үзвэл амаргүй албанд очиж байгаа юм. Ямар байр сууринаас Оюутолгойд хандах нь "Рио Тинто"-гийн Зэсийн группын шинэхэн ерөнхийлөгчийн мэдэх хэрэг. Гэхдээ л мэдээж аль аль талдаа ашигтайгаар, эх орондоо илүү боломжтойгоор асуудал шийдэгдэх талд монгол хүний сэтгэл нь байх биз ээ.

"JP Morgan"-ы Болд

Монголчуудад өөрийн авьяас чадвараараа цойлоод гараад ирсэн нэгнээ дэмжиж, урамшуулж, бахархаж, үлгэр дуурайл авах чанар дутагддаг талаар манайхан олонтаа ярьдаг. Бүр одоо яаж унагахав гэдэг талаас нь бодож эхэлдэг тухайд бүгд мэднэ. Ийм сэтгэлгээтэй байхад улс орон хөгжинө гэж үү.

Миний бие НҮБ-ын Ерөнхий нарийн бичгийн дарга Бан Гин Мүний тухай номыг уншаад бахархах сэтгэл төрж билээ. Өмнөд Солонгос улс дэлхийн Засгийн газрын тэргүүнд өөрийн иргэнээ олон жилийн өмнөөс бодлого, төлөвлөгөөтэй бэлтгэж, төр, засаг, ард иргэдээрээ дэмжиж түүнийг ялалтад хүргэсэн тухай Бан Гин Мүн өөрөө дурссан байсан юм. Өнөөдөр тус орны иргэд дэлхийн хэмжээний өндөр албан тушаал хашиж буй мэдээллийг бид сонссоор л байгаа. Тэгвэл бид солонгосчууд шиг биш юм аа гэхэд өөрсдийн чадлаар гараад ирсэн нэгэндээ үнэн сэтгэлээсээ талархаж, баяр хүргэж, бас бахархаж чаддаг соёлд суралцмаар байна. Зөвхөн урлаг, соёл, спортынхноор бус өөр бусад салбарт ч Монгол бахархлыг төрүүлсэн хүмүүс олон байдаг шүү дээ. Тиймээс" Mongolian Economy" сэтгүүл "Монгол бахархал" шинэ булан нээж байна. Энэхүү булангийн анхны нийтлэлийн эзэн бол Б.Болд.

Түүнийг хүмүүс АНУ-ын J"P Morgan"-д ажиллаж байсан, мөн "Ньюком"-ын, одоо "Алтан Дорнод Монгол"-ын Болд гэдгээр илүү мэддэг. Тэрбээр сонин хэвлэлд өөрийнхөө тухай ярилцлага, мэдээлэл өгөх тун дургүй нэгэн. "Би УИХ-д нэр дэвших гэж байгаа биш дээ" гэнэ.

Монгол оронд ардчиллын салхи сэвэлзэж, капиталист гэгддэг орнууд нээлттэй болж, монголчууд ч хилийн чанадад чөлөөтэй аялж сурах, ажиллах боломж нөхцөл бүрдсэн 1990-ээд оны дундуур Америк орныг Монголоос нэгэн залуу зорьсон нь Б.Болд байлаа. Нийслэлийн III төрөх эмнэлэгт мэндэлсэн, жирийн сэхээтэн айлын хүү Политехникийн дээд сургуулийн үйлдвэрлэлийн менежерийн ангийг 1994 онд төгсчээ. Японы нэгэн мэргэжилтний бичсэн брокер дилерийн хувьцааны талаарх номыг уншаад, найз нартайгаа хамтран брокер дилерийн компани байгуулна хэмээн мөрөөдөж, хувьцааны үнэ ханш, хэлбэлзлийг судалж, үзмэрч тааварч мэт ажилтай, санхүүгийн салбартаа л сайн дурын урансайханч явсан тухайгаа дурсдаг.

Харин удалгүй АХБ-нд орчуулагчийн ажилд орсноор түүний банктай холбогдсон түүх эхэлсэн юм. 1990-ээд оны үед сардаа 1000 ам.долларын цалинтай англи хэлний орчуулагчийн ажил хийнэ гэдэг нэлээд том амжилт. Орос гуравдугаар сургууль төгссөн тул унаган орос хэлтэй, бас германаар ч ярьчихна. Тэрбээр АХБ-нд ажилласнаар англи хэлээ сайжруулж, мэдлэг боловсролоо дээшлүүлэхийн зэрэгцээ тус банкнаас Монголбанкинд хэрэгжүүлсэн хоёр ч төсөл дээр ажилласан нь банкны талаарх мэдлэгийг нь ихээхэн нэмэгдүүлсэн гэдэг. Улмаар ардчиллын өлгий нутагт очиж суралцан АНУ-ын Коннектикут мужийн Брижпордын их сургуулийг Бизнесийн удирдлагын магистр зэрэгтэй дүүргэж, Харвард, Колумб, Стэнфорд зэрэг Америкийн ТОП -10 их сургуулийг төгссөн, туршлагатай америкчуудтай өрсөлдөж дэлхийд хоёрт ордог хөрөнгө оруулалтын "JP Morgan" банкны шалгалтад тэнцсэнээр дэлхийд нэртэй банкинд ажиллаж эхэлжээ.

Хөрөнгө оруулалтын банк нь компани нийлж, салах, худалдах, худалдан авах, хувьцааг нь гаргах, зээл босгох гэх мэт олон чиглэлийн үйл ажиллагаа явуулдаг. Тэрбээр тус банкны энэ бүх чиглэлээрх

"Рио Тинто" компани нь Англи улсад төвтэй бөгөөд Лондон, Нью-Йоркийн Хөрөнгийн биржид бүртгэлтэй. Тус компани нь Рио Тинто Плс, Австралийн Хөрөнгийн биржид бүртгэлтэй Рио Тинто Лимитед компаниудыг нэгтгэсэн олон улсын уул уурхайн шилдэг компанийн нэг.

Компанийн үндсэн үйл ажиллагаа нь ашигт малтмалын эрэл хайгуул, олборлолт, боловсруулах. Тус компанийн үндсэн бүтээгдэхүүнд хөнгөн цагаан, зэс, алмаз, эрчим хүчний болон металлургийн аж үйлдвэрийн нүүрс, уран, алт, аж үйлдвэрлэлийн зориулалттай ашигт малтмал (борын хүчлийн давс, титаны давхар исэл болон давс) болон төмрийн хүдэр багтдаг.

Дэлхийн хоёр дахь том уул уурхайн компани нь олон улсын хэмжээнд ажилладаг бөгөөд Австрали болон Хойд Америкаас гадна Ази, Европ, Африк болон Өмнөд Америкт өргөн хэмжээний үйл ажиллагаа явуулж байна.

хэлтэс, газруудад ажиллаж байгаад 2007 онд Лондон хотноо “JP Morgan” банкны Оросын зах зээлийг хариуцсан төлөөлөгчөөр томилогдсон байна. Б.Болд нь “JP Morgan”-д ажиллах 10 жилийн хугацаанд гэрээ хэлцэл, компанийн үнэлгээ, хувьцааг хэрхэн арилжих талаар дагнан ажиллаж, ОХУ, тусгаар орнуудын хамтын нөхөрлөлийн гишүүн орнууд болон Монголыг хариуцсан гүйцэтгэх захирлын алба хашиж байжээ. Болд захирал “JP Morgan” банкийг Монгол Улстай холбох, анхаарлыг нь хандуулах чиглэлээр идэвхтэй ажиллаж, “Эрдэнэс Тавантолгой”-д зөвлөгөө өгч, “Монголиан майнинг корпэрэйшн”-ий хувьцааг Хонконгийн биржид гаргахад голлох үүрэг гүйцэтгэжээ.

“Ньюком”-оос “Алтан Дорнод Монгол” руу

Тэр 10 гаруй жил Америкт амьдарч ажиллаад эх орондоо ирэхдээ “Ньюком”-ыг сонгож гүйцэтгэх захирлаар нь ажилласан юм. “Ньюком”-ын хувьд үйл ажиллагаа нь жигдэрсэн, оюунлиг залуусаар багаа бүрдүүлсэн, байгальд ээлтэй үйлдвэрлэл явуулдаг манай урдаа барьдаг компаниудын нэг. Болд захирал тус компанийн үйл ажиллагааг эрчимжүүлж, гадаад харилцаа, боловсон хүчнийг бэхжүүлэхийн зэрэгцээ томоохон төслүүдийн эхлэлийг тавьсан гэж үздэг. Тухайлбал, олон жил зогсонги байдалтай байсан салхин паркийн төслийн багийг бүрдүүлж, санхүүжилтийг босгох анхны хэлэлцээрүүдийг хийж эхэлсэн гэх мэт. Мөн хилийн чанадаас мэдлэг боловсролтой, томоохон байгууллагуудад ажиллаж байсан олон залууг араасаа дагуулж, заримыг нь “Ньюком”-доо авч ажиллуулсан билээ. Гар утас, иргэний нисэх, салхины эрчим хүч гэсэн ногоон чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг нэр хүндтэй компанийн гүйцэтгэх захирал нэг л өдөр огцом шийд гаргаж, олныг алмайруулсан юм. Тэрбээр “Ньюком”-ын гүйцэтгэх захирлаас “Алтан Дорнод Монгол” компанийн гүйцэтгэх захирлын албанд очсон нь олныг гайхашруулахад хүргэсэн хэрэг л дээ. Нөгөө Болд чинь очиж очиж “Алтан Дорнод”-ыг сонголоо гэж үү гэсэн хандлага нийгэмд нэг хэсэгтээ түгсэн.

“Алтан Дорнод Монгол” компанийн хувьд нэр хүнд нь тухайн үед навс унаж, Алтан Дорнод шиг муу, бас толгойд багтамгүй их өртэй компани Монголд байхгүй болсон цаг үе байв. Олон тэрбумын өрөнд баригдсан, газар дэлхийг сүйтгэсэн нэртэй компанийг Т.Ганболд, Б.Болд нар хамтран Оросын Паушок гэдэг нөхрөөс худалдан авч ажиллах шийдвэр түүний нэр хүндэд сөргөөр нөлөөлсөн юм. Гэхдээ тэрбээр “Монгол залуус монгол компаниа гаднын нөхрөөс салгаж аваад хөл дээр нь босгож, үндэсний сайн компани болгоё гэсэн зорилготой ажиллаж байна. Энэ тийм муу зорилго уу” хэмээн нийгэмд эерэг мэссэж өгч байлаа. Дэлхийн ТОП менежерүүд бэлэн ажил дээр бус хийж бүтээх, дампуурсныг сэргээн босгох ажлыг түлхүү сонирхдог гэсэн ТОП менежерүүдийн үг Болдын сонголтыг ийн тодотгоно.

Тэрбээр үндэснийхээ дампуурсан, хамгийн муу нэртэй компанийг босгон ирж, Монгол Улсын шилдэг аж ахуйн нэгж болгож, ТОП 100-д багтаахыг хүсч байна. Үүнд би хүчээ, мэдсэн сурснаа зориулмаар байна” хэмээн ярьсан нь ч бий. Үнэхээр ч бүх зүйл нь хараар будагдсан “Алтан Дорнод Монголыг” босгох ажлыг хүссэн болгон хийж чадахгүй нь ойлгомжтой байсан цаг. Зөвхөн татварт 74 тэрбум төгрөгийн өртэй, бүх эд хөрөнгө нь битүүмжлэгдсэн компани байлаа. Харин өнөөдрийн тус компанийн амжилт бол эдгээр залуусын зориг, өөрсдөөө найдаж, өөрсдийн хүч чадал, эрдэм мэдлэг, удирдах чадварт итгэснийх. Тэд нэг жил гаруйн хугацаанд 700-гаад ажлын байр шинээр бий болгож, компаниа шилдэг эко уурхай, шилдэг аж ахуйн нэгж болголоо. Улсад 24 тэрбум төгрөг тушаажээ. Энэ бол том амжилт бус уу.

Өнгөрсөн жил Болд захиралтай уулзахаар өрөөнд нь ороход самбар дээр шүүх хурлын нэрс жагсаастай, ширээн дээр нь шүүхийн, өрийн материалууд өрөөстэй байв. “20-иод шүүх хурлаас одоо гарын таван хуруунд багтахаар үлдлээ дээ” хэмээн суусан. Гадаадын хүний хийсэн хэргийг монгол залуус үүрч, үндэснийхээ компанийг өөд татах, шилдэг болгох, өрийг дарах, шүүхийн танхимаас салгах зэрэг маш том зорилго өөд тэд хамтдаа зүтгэж, богино хугацаанд энэ компанийг босгож ирж байна. Тэд өөрсдийн үл хөдлөх хөрөнгө юу л байгаагаа барьцаанд тавьж, өрөө дарж байгаа гэсэн юм.

“Ньюком” компанид цэлгэр өрөөнд сууж голдуу гадаад орнуудаар “аялж”, хөрөнгө босгох ажилд өөрийгөө сорьж, мэдлэг чадвартай залуусыг чиглүүлэн ажиллаж байсан Болд захирал “Алтан Дорнод”-од ирснээр байдал эсрэгээр эргэж, уулын гутал өмсөн, Заамарын уурхайг зорьж, шүүхийн танхимын хаалгыг тогшиж, өрийн дарамтаас салах арга чарга хайн компанийн үйл ажиллагааг сэргээхийн төлөө хүчээ зориулсан нэг жил гаруйн хугацаа өнгөрөв. Үр дүн, амжилт нь “Алтан Дорнод Монгол” компани 2012 оны шилдэг аж ахуйн нэгж болж, ТОП-150 компанийн 19-д жагслаа.

“Рио Тинто”-гийн Болд

Тэрбээр зургадугаар сарын 3-наас шинэ албаа авч, Лондон хотноо суурьшин ажиллаж, амьдрах юм байна. “Рио Тинто” компанийн Зэсийн группын гүйцэтгэх ерөнхий захирал Жан Себастьян Жак “ Б.Болдын томилгоо манай зэсийн бүтээгдэхүүний группэд хүч нэмж буй хэрэг юм. Б.Болд нь Австрали, Өмнөд Африк, Папуа-Шинэ Гвиней, Индонез, Аляск дахь төслүүдийг хариуцсан Зэсийн группын тодорхой хөрөнгийг борлуулах үйл ажиллагааг хянах, хөрөнгө оруулалтын багцыг нэгтгэхэд оролцох үүрэгтэй ажиллана” хэмээсэн бол “Оюутолгой компанийн Ерөнхийлөгч бөгөөд Гүйцэтгэх ерөнхий захирал Камерон МакРей “Рио Тинто” компанийн Зэсийн группын олон улсын үйл ажиллагаа хариуцсан өндөр албанд сонгогдсон Б.Болдын томилгоо нь Монгол Улс болон Монголын уул уурхайн салбарын хувьд сайн мэдээ. Тэрбээр бизнесийн болон иргэний нийгмийн манлайлагч хүмүүсийн нэг бөгөөд бизнесийн хөрөнгө оруулалтын тааламжтай орчинг Монгол Улсын эрх ашигтай хослуулах чиглэлд их зүйл хийсэн хүн” хэмээн ярьжээ.

“Mongolian Economy” сэтгүүлийн зүгээс монгол залуусын манлайлал, түүчээ болсон Болд захиралд баяр хүргэхийн зэрэгцээ шинэ ажилд нь амжилт хүсч, цаашид илүү ихийг бүтээхийг хүсье. ■

“MONGOLIANECONOMY” СЭТГҮҮЛИЙН АСУУЛТ:

“Рио Тинто” компанийн Зэсийн группын олон улсын үйл ажиллагаа хариуцсан ерөнхийлөгчөөр Б.Болдыг томиллоо. Монгол хүн анх удаа дэлхийн хэмжээний компанийн удирдлагын багт багтлаа. Та ямар бодолтой байна вэ?

МОНГОЛЧУУД БОЛДООРОО БАХАРХАХ ХЭРЭГТЭЙ

Д.Жаргалсайхан ***/“МІН” группын ерөнхийлөгч/:***

-Урьд нь ийм том хэмжээний компанид Монгол хүн ажиллаж болдог албан тушаал гэж байсангүй. Хүрч болдог өндөрлөг нь тодорхой түвшинд л байсан. Энэ төсөөллийг Болд эвдлээ. Олон улсын хэмжээний компанийн толгой группыг монгол хүн удирдах гэж байгаа нь баяр баҳдал бас бахархал юм. Нэг талаасаа дэлхийн хэмжээний компани монгол хүнийг үнэлж, итгэж, тоож байна. Бизнесийн салбарт үнэлэгдэнэ гэдэг амаргүй шүү дээ. Тиймээс өнөө болон ирээдүй цагийн эздэд үлгэр дуурайлал болсон үйл явдал өрнөж байна. Өөрөөр хэлбэл, монгол хүн дэлхийн хэмжээнд үнэлэгдэж болдог юм байна гэсэн итгэл үнэмшил, хүсэл тэмүүллийг өгч байна. Энэ хэрээр Монголын нэр хүнд гадаад ертөнцөд, тухайлбал, бизнесийн салбарт богино хугацаанд өсч, дараа дараагийн үүд хаалга нээгдэнэ шүү дээ. “Рио Тинто” компанийг дэлхий мэднэ. Түүнийг удирдах багт монгол хүн ажиллана гэдэг үнэ цэнэтэй хэрэг. Үүнээс гадна монгол хүнийг хүлээн зөвшөөрнө гэдэг онцлон тэмдэглэх үйл явдал.

Жим Двайр ***/Бизнесийн зөвлөлийн гүйцэтгэх захирал/:***

-”Рио Тинто” шилдэг удирдлага сонголоо. Болдын хөрөнгө оруулалт, банк санхүүгийн чиглэлээр ажиллаж байсан туршлага Тус компанийн үүрэг хариуцлагын хүрээнд маш сайн суурь болж өгнө.
“Рио Тинто”-гийн зэсийн групп нь монгол хүнээр удирдуулах болсон нь Монгол Улсад ихээхэн боломжийг өгнө гэсэн үг. Болд Оюутолгой болон улс орхныхоо эдийн засаг, бизнес, уул уурхайн талаар гүнзгий мэдлэгтэй хүн. Түүний Оюутолгойн асуудлаарх оролцоо Лондон дахь “Рио Тинто”-гийн төвд онцгой ач холбогдолтой байх биз ээ.

Б.Батхүү ***/Уул уурхайн яамны Бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга/:***

-Дэлхийн зэсийн зах зээлд Монголын байр суурь өргежин тэлж буй ийм цаг үед “Рио Тинто” компанийн удирлагын багт монгол хүн ажиллах гэж байгаа нь нэр төрийн хэрэг. Цаашилбал, энэхүү томилгоо нь Монгол Улсын зэсийн зах зээлд эерэг нөлөө үзүүлэх бүрэн боломж гэж харж байна. Түүнчлэн олон улсын зэсийн зах зээлд Монгол Улсыг бүрэн дүүрэн таниулах хөтөч байх болов уу. Мөн Оюутолгой төслийг зөв явуулахад шууд бус ч гэсэн тодорхой хэмжээнд чухал байр суурьтай оролцох байх гэж ойлгож байгаа.

Каролин Кларк ***/Прайсуотерхаус Куперс Аудит компанийн удирдах партнер/:***

Болдын тус албан тушаалд томилогдон ажиллах болсон нь зөвхөн түүний авьяас чадлын илрэл бус Рио Тинто компани Монгол Улстай харилцах цаашдын харилцаандаа итгэж, энэ улс орны төлөө гэсэн сэтгэл зүтгэл гаргаж байгааг харуулж буй хэрэг юм. Энэ удаагийн томилгоо Засгийн газар, Монголын ард түмэн, Рио Тинтогийн хоорон дахь харилцан ойлголцлыг гүнзгийрүүлж, цаашдын хоёр талын хэлэлцээрт нааштай үр дүн авчрахад гол түлхэц болох нь илт байна. Түүнчлэн Монголын залуучуудын хувьд дэлхийн тавцанд байр сууриа олоход үлгэрлэх нэгэнтэй боллоо.

Ч.Хашчулуун ***/МУИС-ийн Эдийн засгийн сургуулийн багш, доктор, профессор/:***

-Монгол хүний нэр хүнд, үнэлэмж дэлхийн хэмжээнд өсч яваач уг шийдвэр харуулж чадлаа. Өөрөөр хэлбэл, Монгол хүний оюун ухаан, эрдэм мэдлэг, авьяас чадварт итгэж найдсан шийдвэрийг “Рио Тинто” компани гаргалаа шүү дээ.

Х.Алтай ***/Монголын хөрөнгийн биржийн гүйцэтгэх захирал/ :***

-Баяртай үйл явдал боллоо. Манай улсын хувьд нэр төрийн хэрэг гэж бодож байна. Үүнээс гадна Монгол Улсад ашигтай байх боломж нэмэгдэх магадлал өсч байна. Болд захиралтай өмнө нь хамтарч ажиллаж байсан хүний хувьд маш их бахархаж байна. Манай биржийн ТУЗ-ийн даргаар ажиллаж байсан хүн өнөөдөр дэлхийн хэмжээний компанийн удирдлагын багт ажиллах гэж байгаа нь бахархууштай явдал.

Н.Алгаа ***/Монголын уул уурхайн үндэсний ассоциацийн гүйцэтгэх захирал/:***

-Монголчууд монгол хүнээрээ, Болдоороо бахархах хэрэгтэй. “Рио Тинто” компанийн Зэсийн группын ерөнхийлөгч гэдэг бол нэр төрийн болоод өндөр хариуцлагатай албан тушаал. ■

ТОЙМ

ЭДИЙН ЗАСАГ ЭРЧИМЖЭВ ҮҮ

И.ОТГОН

Монголын улс төр, эдийн засаг, гадаад харилцаа, аж үйлдвэр, зохион байгуулалт гээд цөөнгүй зүйл “хөдөлгөөн”-д орсон хагас сар үргэлжлэв.

Хөрөнгө орлогоо нуун дарагдуулж, Швейцарийн банкинд нэг сая ам.доллар “гувчуулан” хадгалсан УИХ-ын гишүүн болоод хөдөө талд төөрч, хүргэн Г.Дэнзэн зэрэг хамаатнуудтайгаа тендерийн хэл аманд өртөж, суудлаа өгөх эсэх дээрээ тулсан Ерөнхий сайд тэргүүтэй эрхмүүд өнгөрч буй өдөр хоногуудын улс төрийн гол үзвэр байлаа. Тэдний асуудлыг УИХ-ын Ёс зүйн байнгын хороо, МАН, АН-ын бүлэг бараг 14 хоног хэлэлцсэний эцэст, Ерөнхий сайд Н.Алтанхуяг суудалдаа үлдэж, эрхэм гишүүн С.Баярцогт УИХ-ын дэд даргын албан тушаалаа өгсөнөөр “жүжиг”-ийг өндөрлүүлж байх шив дээ.

Улс төрийн эрхмүүдийн чих халууцуулж, иргэдийнхээ урмыг хугалж, ичээсэн ийм явдлын хажуугаар монгол хүн анх удаа дэлхийн шилдэг компанийн удирдах албан тушаалд томилогдсон сайхан мэдээ дуулдлаа. Монголын шилдэг бизнесмэнүүдийн нэг, “Алтан Дорнод Монгол” компанийн гүйцэтгэх захирал Б.Болд “Рио Тинто”-гийн Зэсийн группын олон улсын үйл ажиллагаа хариуцсан ерөнхийлөгчөөр томилогдсон нь монголчуудын мэдлэг, чадвар дэлхийд танигдаж эхэлснийг харуулсан үйл явдал юм. Түүнчлэн Монголын эдийн засгийн гол хөдөлгүүр, энэ оны төсвийн тулгуур болоод байсан Оюутолгой, “Эрдэнэс тавантолгой” компанийн ажил идэвхжсэн тухай зарласан нь сайн хэрэг. Тухайлбал, Эрдэнэс тавантолгой” компани өнгөрсөн сарын 22-ноос нүүрсний экспортоо сэргээлээ. Түүнчлэн УИХ-аар зөвхөн улс төрийн асуудал биш, Төсвийн болон Эдийн засгийн байнгын хороо хуралдаж, шавыг нь тавиад мартах шахсан Хөшигийн хөндийн олон улсын нисэх буудлын талаарх асуудлыг хэлэлцэж, нэмэлт хөрөнгө оруулалт болох 117 тэрбум төгрөгийн санхүүжилтийг гүйцэтгэгч Японы тал өгөхөөр болов. Энэ нь 0.2 хувийн хүүтэй зээл юм. Үүнээс гадна удтал яригдсан V цахилгаан станц барих газрыг тодорхой болгосон гээд нийгэмд хүлээгдэж буй дэд бүтцийн ажлууд урагшлахаар болов.

Мөн эмтрэн унахын ирмэгт тулж очоод байсан эдийн засагт их эрчмийн гэрэл гэгээ дэлхийн санхүүгийн төв болсон Лондон хотоос цацарсан нь яах аргагүй тэмдэглэх зүйл болов уу. Монголын улс төрийн бодлого шийдвэрийн тааламжгүй байдлаас болж огцом хумигдаж эхэлсэн гадаадын шууд хөрөнгө оруулалтын талаар өнгөрсөн сарын 16-18-нд Лондонд болсон “Монголын хөрөнгө оруулалтын чуулга уулзалт” хөрөнгө оруулагчдын хөрсөн сэтгэлийг хөөргөж чадлаа. Тус чуулганд Эдийн засаг, хөгжлийн яам, Монголбанк, Монголын хөрөнгийн бирж, “Эрдэнэс Тавантолгой” болон “Оюутолгой” компани, “Монголын бизнесийн зөвлөл” зэрэг төрийн болон хувийн хэвшлийн томоохон байгууллагын удирдлагууд явж, Монголын царцанги хөрөнгө оруулалтад эерэг хандлага бий болгов. Уг уулзалтын зочид төлөөлөгчид “Оюутолгой” компанийн ерөнхийлөгч бөгөөд гүйцэтгэх захирал Камерон МакРейн амнаас Монголын Засгийн газар болон “Рио Тинто”-гийн хэлэлцээрийн талаар тун таагүй үг унана байх гэсэн хүлээлттэй байсан байж болох. Харин тэрбээр “Монгол газар зүйн төгс байрлалтай, дэлхийд манлайлах боломжтой улс” хэмээн зарлаж, чуулганы танхимд халуун дулаан уур амьсгал бий болгосон нь дэлхийд түгж байна. Түүнчлэн манай бусад албаны болоод бизнесийн төлөөллүүд ч Монголын хууль эрх зүйн орчинд хатуу, зөөлөн хосолсон, шударга тогтолцоог бий болгох талаар ажиллаж байгааг “Блүүмбэрг” мэтийн дэлхийн томоохон агентлагуудаар зарласан нь хандлагыг эргүүлэхэд



голлох нөлөөтэй байсан гэж үзэж болно. Жишээ нь, Гадаадын хөрөнгө оруулалтын хязгаарлалтын тухай хуулийн зарим зүйл, заалтыг эргэн харах болсон нь гадаадын хөрөнгө оруулагчдын хувьд сайн мэдээ байв. Тэгээд ч зогсохгүй НҮБ-ын Эдийн засаг, нийгмийн комиссоос гаргадаг “Ази, Номхон далайн Эдийн засаг, нийгмийн 2013 оны судалгааны тайланд “Монгол Улсын эдийн засаг ирэх он жилүүдэд улам бүр идэвхжин, хүчирхэгжих хандлагатай байгаа”-г онцолжээ.

Мөн өнгөрсөн сарын сүүлчийн хагаст дотоодын эдийн засагт дуулдсан чихэнд чимэгтэй нэгэн мэдээ бол инфляци буурч, нэг оронтой тоонд дөхсөн явдал юм. 14.3 хувьтай байсан инфляци оны эхний улиралд 5.5 хувиар буурсан нь таатай мэдээ ч үүнд чухам юу нөлөөлөв гэдэг оньсого шиг асуултад иргэд битгий хэл, эдийн засагчид ч хараахан хариулж чадахгүй сууна. Монголбанкны инфляцийг нам түвшинд барьж, нийгмийн дундаж давхаргыг дэмжинэ гэсэн том зорилго биелэх цаг айсуй юу. Эсвэл удахгүй болох Ерөнхийлөгчийн сонгуулийн үгтвар засал уу гэсэн асуулт ам дамжин “айлчилж” байна. Олон нийт ингэж учрыг нь олох гэж улайрах нь аргагүй. Нэг талаас Төвбанкны Засгийн газартай хамтарч хийж буй гол нэрийн бараа, улирлын чанартай бизнесийн түүхий эд, материалын нийлүүлэлтийг сайжруулахаар олон тэрбум төгрөг зарцуулж уйгагүй зүтгэж байгааг үнэлэх л асуудал. Гэвч үүний үр дүн харагдах хараахан болоогүй гэдэгтэй цөөнгүй эдийн засагч санал нэгдэж буй. Тэгвэл юу нөлөөлсөн байх вэ. Инфляцийн бууралт иргэдэд мэдрэгдэж эхлэв үү хэмээн сонирхоход эерэг зүйл тодийлэн анзаарагдахгүй байгаа. Тухайлбал, хэрэглээний үнийн индекст цаг ямагт ахиу жин дардаг махны үнэ буурсан уу гэвэл үзэх аваас буух биш, харин ч өссөн байх жишээтэй. Засгийн газраас олон тэрбумын зээл авсан нефть импортлогчид өнгөрсөн гурван сарын хугацаанд бүтээгдэхүүний үнээ бууруулаагүйг хэн хүнгүй мэднэ. Тэдний нэг хэсэг нь үгсэн хуйвалдаж үнээ нэмсэнийхээ торгууль шийтгэлийг улсад төлж эхэлсэн учраас ойрын хугацаанд шатахууны үнэ буурна гэдэг яриа хэр ортой бол доо.

Түүнчлэн МУИС-ийн эдийн засгийн сургуулийн захирал Ц.Даваадорж “Цаашид инфляци эрчимтэй буурах эсэхэд эргэлзээ төрүүлсэн нэгэн судалгааны дүнг дурдмаар байна. Өнгөрсөн оны аравдугаар сард манай сургууль санамсаргүй түүврээр сонгосон 2000 гаруй хүнээс “Хэрэглэгчийн итгэлийн индекс”-ийн судалгааг авсан. Судалгааны дүн энэ онд инфляци нэг оронтой тоонд шилжих итгэлийг төрүүлэхээргүй гарсан” хэмээн хэлсэн нь манай www.mongolianeconomy.mn цахим хуудаснаа гарсан. Гэхдээ Монголбанкны инфляцийг онилж байгаа олон арга хэмжээ үүнд огт хамаагүй гэж хэлэхгүй. Тухайлбал, Монголбанкны өнөөдрийг хүртэл баримталж ирсэн Мөнгөний бодлого нь буруугүй байсан гэдгийг Ерөнхий сайд асан Д.Бямбасүрэн манай сэтгүүлд өгсөн ярилцлагадаа дурдсаныг энд тэмдэглэе. Мөн МУИС-ийн Эдийн засгийн судалгаа, эрдэм шинжилгээний хүрээлэнгийн захирал Б.Түвшинтөгс мөнгөний бодлого боломжийн орон зай бий болгосон гэж олзуураж байв. Энэ бүхнээс үзэхэд огцом буурсан инфляцид нийгмийн байдал цаашид хэрхэн нөлөөлөх бол гэдэг асуудал юм.

Мөн Ардчилсан орнуудын хамтын нийгэмлэгийн Сайд нарын VII бага хурал болох гэж буйтай холбоотойгоор цэмцийсэн нийслэлтэй, эдийн засгийн сэргэлттэй хагас сар өнгөрч байна. Хөрөнгө оруулалтын эерэг хандлага, эдийн засгийн эрчимжүүлэлт цаашид хадгалагдвал ямай даа. ■



Л.БЯМБААГИЙН БУЛАН

ГАДААДЫН ШУУД ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ МОНГОЛД ХЭРЭГТЭЙ ЮУ

Стратегийн ач холбогдол бүхий салбарт үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгжид гадаадын хөрөнгө оруулалтыг зохицуулах тухай хууль өнгөрсөн оны тавдугаар сард батлагдсан. Дэлхийн эдийн засгийн суурь орчин төдийлэн сайнгүй байхад Монголыг зориод ирсэн гадаадын хөрөнгө оруулагчдад энэ нь гэнэтийн зүйл болж, шинээр орж ирэхээр төлөвлөгдөж байсан хөрөнгө оруулалтуудыг зогсоож эхэлсэн юм. Тухайн үед ямар сөрөг үр дагавар гарч болох, мөн уг хуулийг хэрэгжүүлэх бодит боломж байгаа эсэх талаар цөөнгүй хэлэлцсэн ч бодлогын үр нөлөөний судалгааг гүйцэд хийлгүйгээр баталсан байдаг.

Саяхан дээрх хуульд нэмэлт өөрчлөлт оруулж, гадаадын хөрөнгө оруулалтын хязгаарлалтыг бууруулах, УИХ-аас зөвшөөрөл авах босгыг нь нэмэгдүүлсэн байна. Нэг талаар алдаагаа залруулсан нь зөв болсон ч, нөгөө талаас алдаа гаргахгүй байж болох байсан эсэх, залруулсан ч сөрөг үр дагавар нь бүрэн арилах эсэх, мөн энэ нь хөрөнгө оруулагчдын итгэлийг эргэн олоход хангалттай юу зэрэг асуулт тавигдаж байгаа юм.

Бид гадаадын хөрөнгө оруулагчдаас юу хүснэ вэ?

Дээрх асуултын хариултыг бид өөрсдөө мэдэхгүй, бодолцоогүй учраас маргаантай, ойлгомжгүй гэмээр нөхцөл үүсээд байдаг мэт санагддаг. Анхнаасаа гадаадын хөрөнгө оруулагчдад хатуу болзолтой байх нь хамаагүй, тодорхой хүлээн зөвшөөрсөн хөрөнгө оруулагч орж ирэх боломжтой болно. Тэгвэл Монгол гадаадын хөрөнгө оруулагчдад ямар нөхцөл тавих нь зүйтэй юм бэ? Баахан хөнгөлөлт эдлүүлээд, татвараас чөлөөлөөд “эрхлүүлээд” байх уу, эсвэл хатуухан байж өөрийн байр сууриа хамгаалсан нь зөв үү? Бодлогын чиг баримжаа тогтооход зах зээлийн зарчмаар бүх зүйл эрэлт, нийлүүлэлтээс хамаардаг гадаад мөнгө бидэнд хэр их хэрэгтэй байгаагаас хамаарна гэж бодогддог.

Эдийн засгийн өсөлт, бүтээн байгуулалт ид өрнөж байгаа энэ үед санхүүжилтийн хэрэгцээ асар их байгаа нь ойлгомжтой. Саяхан болсон хөрөнгө оруулалтын нэг чуулга уулзалтын үеэр ойрын таван жилд манай улсын зөвхөн дэд бүтцийн төслүүдийн санхүүжилтэд 45-68 орчим тэрбум ам.доллар буюу 95 их наяд орчим төгрөг шаардлагатай тухай ярьж байсан. Тодорхой жилийн тухайд санхүүжилтийн эрэлт хэрэгцээгээ гаргачихаад ямар хөрөнгийн эх үүсвэрээр санхүүжүүлэх боломжтой, мөн аль нь илүү оновчтой вэ гэдгийг бодолцох шаардлага урган гарах учиртай.

Хөрөнгө оруулалтын төсөл	Мөнгөн дүн, /тэрбум ам.доллар/
Уул уурхай	12-20
Дэд бүтэц	8-12
Хотын хөгжил	6-8
ХАА	1-2
Аж үйлдвэр	15-20
Байгаль орчин	1-2
Нийгэм	1-2
Санхүүгийн салбар	1-2
Нийт	45-68

Эх сурвалж: ХХБ


Нөгөө талаас санхүүжилтийн эрэлт, хэрэгцээг хангах санхүүгийн ямар эх үүсвэр бидэнд байна вэ гэдгийг судлая. Үүнд улсын босгосон мөнгө, төсөв, банкны зээл, дотоодын хувийн хөрөнгө оруулалт, гадаадын зээл тусламж, мөн гадаадын шууд хөрөнгө оруулалт зэргийг нэрлэж болно.

Эдийн засагт хэрэгцээтэй санхүүжилтийн хэрэгцээ болон эх үүсвэрийг 2013 оны тухайд жишээ байдлаар хийсвэрлэн тооцож үзье.

Ойрын таван жилд доод тал нь Монгол Улсад 63 их наяд төгрөг шаардагдах юм бол зөвхөн энэ оны

тухайд бүтээн байгуулалтын төслүүдэд нийт 13 их наяд төгрөг шаардлагатай гэж үзье.

Тэгвэл 13 их наяд төгрөгийг хаанаас бүрдүүлэх вэ. Эх үүсвэр



талд Чингис бондын 2.1 их наяд, мөн улсын төсөвт хөрөнгө оруулалтад зориулан нийт 1.9 их наяд төгрөг тусгасан байгаа. Монголын санхүүгийн зах зээлд энэ оны эхний улирлын байдлаар банкуудаас нийт олгосон зээлийн үлдэгдэл 7.4 их наяд төгрөг байна. Харин энэ оны тухайд шинээр гаргах боломжтой зээлийн хэмжээ 1.5 их наяд орчим байх болов уу. Хөрөнгийн зах зээлээс түүхэн хугацаанд нь нийт босгосон хөрөнгийн хэмжээ ердөө 75 тэрбум төгрөг байсан, энэ жилийн тухайд анхдагч зах зээл дээр тодийлэн их мөнгө босгох боломж харагдахгүй байна. Гадаадын шууд хөрөнгө оруулалтаар хоёр орчим их наяд төгрөг татаж чадна гэж тооцлоо гэхэд л цаана нь 5.4 их наяд дутагдахаар харагдаж байна. Дүгнэхэд, санхүүжилтийн эрэлт хэрэгцээний дөнгөж 60 орчим хувь хангагдах нь.

Иймэрхүү байдлаар тооцоолол хийгээд хөрөнгө оруулалтын төлөвлөлтийг үндэсний хэмжээнд олон жилээр хийдэг байх ёстой. Ингэсний үндсэн дээр бидэнд гадаадын хөрөнгө оруулалтын мөнгө хэр их хэрэгцээтэй, мөн санхүүгийн талаас ямар нөхцөл тавих уу гэдэг нь ойлгомжтой болно.

Мөнгө гэхээсээ илүү төлөвлөлт чухал байна

Үндэсний хөгжлийн стратеги тодорхой хөгжлийн үе шат, хэрэгжүүлэх хөтөлбөр, санхүүжүүлэх эх үүсвэртэйгээ уялдаж гарахгүй байна. Макро том төслүүдийн төлөвлөлт нь санхүүгийн эх үүсвэртэйн хамт хийгддэг болчихвол нийт санхүүжилтийн хэрэгцээний хэдийг нь төсвийн хөрөнгөөр, хэдийг нь зээлээр, хэдийг нь төр-хувийн хэвшлийн хамтарсан хэлбэрээр, хэдийг нь дотоодын болон гадаадын хувийн хөрөнгө оруулалтаар шийдэх нь тодорхой болно.


Хөрөнгө оруулалтын шаардагдах хэмжээг тогтоосон тохиолдолд бид хөрөнгө оруулагчдад хэр уян хатан нөхцөл санал болгох нь ойлгомжтой болно. Тэгэхээр бидэнд юуны өмнө, нэн ялангуяа том бүтээн байгуулалтын төслүүд дээр удаан хугацааны төлөвлөлт чухал байна. Сайтар төлөвлөөд эхэлчихвэл төсөл байхгүй байхад мөнгө босголоо, төсөл байхад мөнгө олсонгүй гэх мэт асуудал яригдахгүй болно.

Гадаадын хөрөнгө оруулалтад мөнгөнөөс гадна өөр үнэ цэнэ бий

Гадаадын хөрөнгө оруулалтын тухайд мөнгө, санхүүжилтээс гадна хоёр чухал зүйл байдгийг дурдах нь зүйтэй. Нэгдүгээрт, ноу-хау буюу төслийг хэрэгжүүлэх явцад Монголд орж ирж байгаа технологийн болон бизнесийн мэдлэг, туршлага. Дэвшилтэт технологи, бизнесийн аргачлал, техник тоног төхөөрөмж, мэдлэг гээд мөнгөнөөс гадна олон зүйл орж ирдэг. Олон улсын тэргүүний туршлагыг шууд авч хэрэгжүүлэх боломж нээж өгдөг. Тухайлбал, Оюутолгой төсөл дээр дэлхийд цөөн улсад ашиглагддаг уул уурхайн техник технологийг ашиглаж байгаа нь бид зах зээлийн тэргүүний туршлагыг хөрсөн дээрээ шууд буулгах боломжтой болсон. Үүнийг дагаад хүний нөөц, боловсон хүчний чанар, ур чадварыг дээшлүүлэх давуу тал үүсдэг.

Хоёр дахь чухал зүйл бол хугацаа. Мөнгөний үнэ цэнийг ярьж байхад хугацааны хүчин зүйл зайлшгүй тооцогддог. Хэдий хэмжээгээр эрт эхэлж чадна уу, төдий хэмжээгээр бидний алдагдсан боломж бага байх болно. Монголын гараа бусад хөгжилтэй оронтой харьцуулахад нэгэнт оройтсон байгаа. Солонгос, Америк, Австрали зэргийн хөгжлийг хойноос нь хөөгөөд богино хугацаанд гүйцэхгүй нь мэдээж. Хөгжилтэй орны түвшинд хүрэхийн тулд илүү сайн төлөвлөж хэрэгжүүлэх хэрэгтэй.

Нэгтгэж хэлэхэд хэнийг, хэзээ, хаана оруулахаа бид өөрсдөө шийдэх эрх нь байна, хэлбэр, хэмжээ, нөхцлийг нь бид төлөвлөлтөө сайтар хийгээд тодорхойлно, хүний мөнгийг ашиглан бүтээн байгуулалтаа хийж авах нь бидний хойч үеийнхнийхээ өмнө хүлээж байгаа үүрэг. Энэ явцад бодлого тууштай бөгөөд тодорхой л байх хэрэгтэй. ■



ХӨДӨЛМӨРИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ

АЮУЛГҮЙ АЖИЛЛАГАА БА ГЕРМАНЫ “НОУ-ХАУ”

Х.ХУЛАН

Та амьдралынхаа хэдэн хувийг ажилдаа зарцуулдаг тухай бодож байсан уу? Ихэнх хүн амьдралынхаа гуравны нэгийг ажлын байрандаа өнгөрөөдөг гэсэн судалгаа байдаг. Тэгвэл сэтгэл хангалуун, хөдөлмөрийн бүтээмжтэй ажиллахын тулд юуны өмнө цэвэр, аюулгүй орчин шаардлагатай юм. Эл энгийн бөгөөд чухал нөхцөл ажиллагсдын эрүүл мэнд, цаашилбал тэдний амь настай ч хамааралтай бөлгөө. Иймд хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн стандартыг хэрэгжүүлэх нь аливаа бизнес эрхлэгчийн хамгийн гол үүрэг.

Германы олон улсын хамтын ажиллагааны “Эрдэс баялаг, түүхий эдийн иж бүрэн хөтөлбөр”-өөс (ЭТИС) энэ сарын 6-7-ны өдрүүдэд “Хөдөлмөрийн аюулгүй байдал ба эрүүл ахуй” сэдвээр чуулга уулзалт зохион байгуулах гэж байна. Уг арга хэмжээ “Blue Sky” зочид буудалд болох бөгөөд ХБНГУ-ын Хөдөлмөр хамгааллын бараа, үйлчилгээ үзүүлэгч компани, Монголын төр болон хувийн хэвшлийн байгууллагын төлөөлөгчид оролцож туршлага солилцох аж. Түүнчлэн тус компаниудын бараа, бүтээгдэхүүнээ танилцуулах үзэсгэлэн гарах юм байна.

ЭТИС хөтөлбөр МХЕГ-ын Хөдөлмөр, нийгмийн хамгааллын хяналтын хэлтэстэй хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах ажлын хэсэг, “Монгол алт” компанийн Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй байгаль орчны хэлтэстэй тус бүр хамтран ажиллаж байна. Тухайлбал, “Монгол алт” компани дээр хөдөлмөрийн эрүүл, аюулгүй байдлын удирдлагын тогтолцоо OHSAS 18001-ийг системтэйгээр хэрэгжүүлэх тал дээр дэмжлэг үзүүлж байгаа аж. OHSAS буюу хөдөлмөрийн эрүүл ахуй, аюулгүй байдлын стандартыг ажиллагсадтай холбоотой эрсдлийг арилгах эсхүл бууруулах зорилгоор аль ч байгууллага хэрэглэх боломжтой.

Ажлын байрны аюулгүй байдал нь тухайн компанийн өрсөлдөх чадварыг сайжруулах хүчин зүйл болдгийг манай улсын аж ахуйн нэгжүүд хүлээн зөвшөөрч байна. Ялангуяа уул уурхай, барилгын салбарт орчин үеийн шинэчлэлт техник технологи, ноу-хаугийн хэрэгцээ ихээхэн гарч буй. Сүүлийн жилүүдэд Монгол Улсад уул уурхайн олборлолтын үйлдвэрлэл эрчимжиж, үүнтэй зэрэгцээд ханган нийлүүлэх болон бусад жижиг үйлдвэрүүд хөгжиж улмаар хөдөлмөрийн зах зээл өргөжин тэлж байна. Гэхдээ үйлдвэрлэл хөгжихийн хэрээр хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн асуудал улам бүр чухлаар тавигдах ёстойг анхаарууштай.

Ажиллагсдын хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйг хангана гэдэг өргөн хүрээний ойлголт мөн. Манай улсад энэ асуудал хурцаар тавигдах салбар бол уул уурхай, барилгын салбар юм. Эдгээр салбар өндөр цалинтай боловч хамгийн их эрсдэл дагуулсан ажлын байранд орж байна.

Энэ бүхэн тээвэрлэлт, логистикийн салбарт аюулгүй байдлын хамгаалалтын хэрэгсэл, тоног төхөөрөмжний шинэчлэл, хөдөлмөрийн аюулгүй байдал ба ажиллагсдад зориулсан эрүүл ахуйн сургалт зэргийг багтаасан цогц ойлголт билээ.

Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн орчныг сайжруулахад салбар бүр өөрийн онцлогт тохирсон, дэлхийн жишигт нийцсэн хөдөлмөрийн аюулгүй байдлын хувцас хэрэглэлээр ажилчдаа хангахаас гадна тэдэнд хөдөлмөрийн аюулгүйн дүрэм журмын тухай сургалт явуулж, түүний ач холбогдлыг ойлгуулах нь юу юунаас чухал.

ЭТИС хөтөлбөрийн санаачилгаар зохион байгуулах энэхүү хөдөлмөрийн аюулгүй байдлын чуулга уулзалтаар Германы тэргүүлэх компаниуд өөрсдийн туршлагаасаа хуваалцаж, бүтээгдэхүүнээ танилцуулах юм байна. ■

Үйлдвэрлэлийн осол салбараар /2012 он



ҮЗЭЛ БОДОЛ

ОЛОН ЖИЖИГ АЛХАМААС ХӨГЖИЛ БҮРДЭНЭ



ШТЕФАН ХАНСЕЛЬМАНН, /ГОУХАН-ийн "Эрдэс баялаг, түүхий эд иж бүрэн санаачилга хөтөлбөр"-ийн захирал/

Амьдралд байнга тохиолддог ганцхан зүйл нь байнгын өөрчлөлт юм. Өөрчлөлт боломжийг хязгаарлаж байдаг. Монголоос өөр үүнийг сайн батлах газар алга. 2009 оны аравдугаар сард "Оюутолгой" компанитай хөрөнгө оруулалтын гэрээ байгуулснаас хойш Монгол Улс хэрхэн өөрчлөгдөж байгаа нь үнэхээр гайхалтай. Гэхдээ хүн бүр үүнд баярлахгүй байна. Монгол Улсын уул уурхайн салбарын хөгжил нь эдийн засгийн гэрэлт ирээдүйд хүргэх түлхүүр болохынхоо хувьд энэ салбар Монгол Улсын иргэн бүрт сайн сайхан амьдрал авчирна гэдэгт эргэлзэхгүй байна. Гэхдээ амжилтад хүрэхэд нэлээд ул суурьтай төлөвлөсөн макро эдийн засгийн бодлого, суурь эдийн засгийн хөгжлийг дэмжсэн уялдаа холбоо бүхий бодлогын орчныг шаардана. Монгол Улс харилцан уялдаа бүхий нэгдмэл бодлогыг хэрэгжүүлж чадвал уул уурхайн баялгийг бат бэх, тогтвортой, тэгш шударга хөгжилд хүрэхэд ашиглах болно. Үүнийг илүү тодорхой тайлбарлавал, уул уурхайн баялгийг сургууль төгссөн залуучуудад ажил болгон хувиргах, зам, дэд бүтцийг сайжруулах, хөгшид настны нийгмийн хамгааллыг нэмэгдүүлэх, их, дээд сургуулиудын чанарыг сайжруулах, судалгааны ажилд зарцуулах хөрөнгийн хэмжээг нэмэгдүүлэхэд чиглүүлнэ гэсэн үг.

Эдийн засагчид байгалийн баялагт суурилсан эдийн засагтай орнуудын өмнө тулгарч буй макро эдийн засгийн бэрхшээл, хөгжлийн тогтвортой байдлыг хангах зэрэг асуудлуудыг судалсан байдаг. "Баялгийн хараал", "Голланд өвчин" гэсэн оношийг байгалийн баялагт суурилсан хөгжлийн нийгэм, эдийн засгийн сөрөг нөлөөг тайлбарлахыг оролдохдоо ашигласан байдаг. Үүнийг Монголын хувьд ч бас авч үзэх боломжтой. Сүүлийн гурван жилд Монгол Улсын уул уурхайн салбарт гадаад, дотоодын олон компани их хэмжээний хөрөнгө оруулалт хийсэн бөгөөд инфляци, өрийн харьцаа, Засгийн газрын зардал зэрэг макро эдийн засгийн зарим нэг үзүүлэлтийг харахад Монгол Улс аль хэдийн Голланд өвчний халдвар авсан мэт санагдаж байна.

Монгол Улсын эдийн засгийн одоогийн байдлаас харахад өвчнийг илааршуулах нэг арга бол үндэсний үйлдвэрлэх чадавхийг хөгжүүлэх явдал юм. НҮБ-ын Худалдаа, Хөгжлийн байгууллагын тодорхойлсноор, үйлдвэрлэх чадвар гэдэг нь "Үйлдвэрлэлийн түүхий эд материал, ажиллах хүч, бизнес эрхлэх ур чадвар, бүтээгдэхүүний сүлжээ аль түвшинд байгаагаар тухайн улсын бараа, бүтээгдэхүүн үйлдвэрлэх чадавх болон цаашдын өсөлт хөгжилтийг тодорхойлно."

Хөрөнгийн хуримтлал гэж бүх төрлийн хөрөнгө (биет хөрөнгө, хүний хүчин зүйл, байгалийн баялаг) өсөх, өргөжих хөрөнгө оруулалтын үйл явцыг хэлэх бөгөөд энэ нь үйлдвэрлэх хүчин чадавхийг хөгжүүлэх гол элемент юм. Үүнтэй адил өөр нэг чухал зүйл бол технологийн дэвшил бөгөөд тухайн оронд шинэ бүтээгдэхүүн, үйлдвэрлэлийг нэвтрүүлэхдээ

технологийн шинэ санаа, дэвшлийг ашиглах, технологийг сурах арга замыг ашигладаг.

Шинэ дэвшил гэдгийг тайлбарласан олон тодорхойлолт байдаг боловч би хамгийн энгийнээр “Шинэ дэвшил, шинэ санаа гэдэг бол тухайн зүйлийг өмнөхөөсөө арай өөрөөр, ахицтайгаар хийх бүх аргыг хэлнэ” гэж тайлбарламаар байна. Энэхүү өргөн утга санаа нь, жишээлбэл, ГОУХАН-ийн Эрдэс баялаг, түүхий эдийн иж бүрэн санаачилгаас Монгол Улсын жижиг, дунд үйлдвэрүүдэд өгч байгаа зөвлөгөө, сургалтад шингэсэн байдаг. Шинэ бүтээгдэхүүн, шинэ арга хэлбэр нь өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх, эдийн засгийн өсөлтийг хурдасгах, хөдөлмөр эрхлэлтийг бий болгоход чухал үүргийг гүйцэтгэх бөгөөд эдийн засгийн хөгжилд түлхэц үзүүлнэ. Шинэ бүтээл, шинэ санааг гаргаж ирэх нь зах зээлийн хэмжээ, механизмаас хамаарч байдаг. Харамсалтай нь, Монгол Улсын зах зээл харьцангуй жижиг, хуваагдмал, дэд бүтцээс шалтгаалан бүрэн утгаараа ажиллаж чадахгүй байгаа бөгөөд нэг хүнд ногдох орлого бага, зохицуулалтын механизм сул хөгжсөн, институцийн бэрхшээл их байдгаас шалтгаалан бизнес эрхлэгчдэд санаачлагатай ажиллах нөхцлийг бүрдүүлж чадахгүй байна. Түүнчлэн, санхүүжилт авах боломж бага, зах зээлийн мэдээлэл хомс, бизнес эрхлэгчдийн ур чадвар тааруухан байгаа нь шинэ санаа, санаачилга гарахад саад болж байна.

Шинэ санаа, шинэ санаачилга гаргах нь ойд төөрч, адал явдалтай учрахтай адил бөгөөд технологийн хувьд боломжтой эсэх, зардлаа нөхөх эсэх, зах зээл байгаа эсэх нь тодорхойгүй гэсэн үг. Түүнчлэн шинэ санаа, санаачилга нь түүнийг зохиосон зохиогчийн хувьд ашигтай байж чадахгүй бөгөөд шинэ санаа, шинэ мэдлэг, шинэ технологийг түүний өрсөлдөгчид үнэ төлбөргүйгээр авч ашиглаж байна. Гэсэн ч бид энд дугуйг дахин бүтээх тухай яриагүй билээ. Тухайн улс, компанийн хувьд шинэ гэж тооцогдох ямар ч бүтээгдэхүүн, үйлчилгээ хэзээ ч хаана ч бий болж болохыг бид хүлээн зөвшөөрөх нь чухал. Зөвхөн өндөр технологитой бүтээгдэхүүн төдийгүй бүтээгдэхүүн үйлдвэрлэх, зах зээлд гарах гэх зэрэг үйл ажиллагаандаа шинэ арга хэлбэрийг алхам алхамаар нэвтрүүлж байгааг хэлнэ. Жижиг, том гэлтгүй олон мянган шинэ санаа нь бүтээмжийг нэмэгдүүлэх, орон нутагт нэмүү өртгийг бий болгох, бүтээгдэхүүний чанарыг сайжруулах, улмаар эдийн засгийг хөдөлгөх суурь хүчин зүйл болж чадна. Эдийн засаг нь хөгжиж байгаа Монгол гэх мэт орнуудын хувьд шинэ санаа, санаачилгыг дэмжсэнээр эдийн засгийг уул уурхайн баялгаас үлэмж ихээр хамаарч байгааг бууруулж чадна. Түүнчлэн, нийгмийн дийлэнх орлогын түвшин ихээхэн хэмжээгээр нэмэгдэх боломжтой болно.

Энэ нь Монгол Улсын хувьд технологи, инновацийн тусгай бодлого хэрэгжүүлэх шаардлагатай болохыг харуулж байна. Хөгжиж байгаа орнууд ерөнхийдөө технологийн хоцрогдлыг үсэрч биш, аажим аажмаар гүйцэх чиг хандлагыг баримталдаг байна. Өөрөөр хэлбэл, технологийн чадавхийг компанийн түвшинд төдийгүй улс орны түвшинд хөгжүүлэхийн тулд суурь менежментийн чадавхиас үйлдвэрлэлийн менежментийн чадавх, улмаар үйлдвэрлэлээ өргөтгөх, сайжруулахад шаардагдах инженер, техникийн чадавхи хүртэл үе шаттайгаар хөгжүүлэх шаардлагатай. Үүнтэй нэгэн адилаар бие даасан салбарын хөгжлийг ч мөн анхан шатны үйлдвэрлэлээс өргөтгөх, дэлгэрүүлэх, улмаар эрэлт, нийлүүлэлттэй уялдуулан салбар хоорондын хөгжлийг хангах зэрэг үе шаттай хөгжүүлэх нь зүйтэй.

Герман зэрэг аж үйлдвэр өндөр хөгжсөн орон болон Монгол Улсын хоорондох технологийн дэвшлийн зөрүү үлэмж их бөгөөд Монголын хувьд технологийн дэвшлийг гүйцэх шаардлагатай. Өнөөдөр технологитой холбоотой мэдээлэл,

Оюутолгойн ус дахин ашиглах байгууламж. Эх сурвалж: ГОУХАН-ийн ЭТИС хөтөлбөр



мэдлэгийг авах боломж бүрэн нээлттэй бөгөөд энэ боломжийг ашиглан үйлдвэрлэлээ сайжруулах замаар бүтээгдэхүүн, үйлчилгээгээ шинэчилж болно. Үндэстэн дамжсан корпорациуд тэрхүү мэдлэгийн үрийг тарьж байдаг бол түүнийг дотоодын компаниуд орон нутагтаа цааш өргөжүүлэн ашиглаж болно. Дэлхийн хэмжээнд судалгаа, мэдлэг түгээх сүлжээнүүд бий болж байгаа нь Монгол Улсыг энэхүү мэдээлэл солилцооны сүлжээнд нэгдэх боломжийг олгож байна. Монгол Улсын Их сургууль саяхан 130 их, дээд сургуулийг эгнээндээ нэгтгэсэн САП их, дээд сургуулиудын түншлэлийн хөтөлбөрийн гишүүн болохоор гэрээнд гарын үсэг зуржээ. САП нь дэлхийн хамгийн том бизнесийн программ үйлдвэрлэдэг компани бөгөөд Эдийн засгийн сургуулийн багш оюутнуудад үнэ төлбөргүйгээр орох ба онлайн хичээл болон амьдралд аль хэдийнэ хэрэгжиж эхэлсэн компанийн менежментийн программыг ашиглах боломжийг олгож байна.

Бизнесийн шинэ санаа, санаачилга гаргах чадварыг нэмэгдүүлэх тухай инновацийн бодлогын нэг чухал хэсэг нь (гол төлөв үндэстэн дамжсан) томоохон компаниудаас жижиг компаниуд руу технологийг шилжүүлэх, түгээх явдал юм. Монгол Улсад уул уурхайн салбарыг хөгжүүлэхэд гадаадын хөрөнгө оруулалт, туршлага шаардлагатай болж байгаа нь ноу-хауг шилжүүлэх боломж байгааг харуулж байна. Компани хоорондын хамаарал, хамтын ажиллагааг сайжруулах хандлагуудын нэг нь өртгийн сүлжээ, кластерыг хөгжүүлэх явдал юм. Томоохон компанийн нийлүүлэгч, гэрээлэгчээр ажиллах нь жижиг компаниудад зах зээлд нэвтрэх, том компаниудын технологиос суралцах, улмаар нэг кластерт багтсанаараа жижиг компаниудад төрөлжих, шинэ технологийг нэвтрүүлэх, худалдан авалт хийх боломжийг олгож байна.

